FORESTS FOR THE FUTURE FACILITY

Implemented by a consortium led by

particip

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ОЙН ТУХАЙ ХУУЛЬ

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ОЙН ТУХАЙ ХУУЛЬ

Улаанбаатар

2025

FUNDED BY THE EUROPEAN UNION

F4F - Forests for the Future Facility is an EU-funded project.

Printed by Particip GmbH
This publication was produced with the financial support of the European Union.
Its contents are the sole responsibility of Particip GmbH and do not necessarily reflect the views of the European Union.

Project implemented by:

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ 4
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ 5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ 6
УДИРТГАЛ 7
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ 8
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь 8
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох 8
1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох 8
1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох 11
1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох 12
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох 13
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ 14
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ 16
3.1.“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал 16
3.2.“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал 35
3.3.“Бусад үр дагавар” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал 57
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ 75
4.1. ДҮГНЭЛТ 75
4.2. ЗӨВЛӨМЖ 80
ТАВ. НОМ ЗҮЙ 84

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БНАТ	Байгалийн нөөц ашигласны төлбөр
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
БОХтХ	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЗЗНДНТУтХ	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
ОА	Ойн анги
ОАА	Ойн аж ахуй
ОМ	Ойн менежмент
ОМБ	Ойн мэргэжлийн байгууллага
ОМТ	Олон менежментийн төлөвлөгөө
ОН	Ойн нөхөрлөл
ОТМ	Ойн тогтвортой менежмент
ОтХ	Ойн тухай хууль
СДОА	Сум дундын ойн анги
ТББ	Төрийн бус байгууллага
ТМХ	Тэрбум мод хөтөлбөр
ТХГ	Тусгай хамгаалалттай газар
ТХГНтХ	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
УДШ	Улсын дээд шүүх
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт 9
Хүснэгт 2. "Практикт нийцэж байгаа байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт 11
Хүснэгт 3. Бусад үр дагавар шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт 11
Хүснэгт 4. ОтХ-аар хэм хэмжээний акт батлах эрхийг олгосон заалт, батлах субъект 21
Хүснэгт 5. ОтХ-д заасны дагуу батлагдсан хэм хэмжээний актын жагсаалт 22
Хүснэгт 6. Шилмүүст, навчит ой насны бүлгээр 46
Хүснэгт 7. Заган ой, насны бүлгээр 46
Хүснэгт 8. Байгалийн нөөц (2022, 2023 он) 46
Хүснэгт 9. Тархцын дундаж үзүүлэлт 48
Хүснэгт 10. Ойн сангийн газрын төрлийн өөрчлөлт 49
Хүснэгт 11. Монгол орны ойн сан, ойн дэглэмийн ангилал 55
Хүснэгт 12. Ойн ашиглалтын тайлан /ОМ-4-3/ 60
Хүснэгт 13. Эрүүгийн хуулийн зүйл, заалт 70
Хүснэгт 14. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн "Хууль бусаар мод бэлтгэх" гэмт хэрэг (2021-2024) 71

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Фокус бүлгийн ярилцлагад хамрагдсан төлөөлөл (Аймгаар) 14
График 2. Фокус бүлгийн ярилцлагад хамрагдсан төлөөлөл (Оролцогчоор) 15
График 3. ОтХ-д заасан бүрэн эрх, субъект тус бүрээр 27
График 4. СДОА-ийн хариуцаж буй ойн сан, ОН болон ОМБ-ын эзэмшиж буй талбай 35
График 5. Ашиглалтын болон хамгаалалтын бүсийн ойн харьцаа 54

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Түймэрт өртсөн талбай, га 16
Зураг 2. Ойн хөнөөлт шавжийн голомт, тархалт, тэмцэл хийсэн талбай, га 17
Зураг 3. Ойгоос бэлдсэн модны хэмжээ ба хүн ам, м^3/өрхийн тоо 18
Зураг 4. Ойгоос жилд бэлтгэх модны дээд хязгаарыг тогтоох үе шат 30
Зураг 5. Булган аймгийн ИТХ-ын ээлжит XII хурлын тогтоолын гуравдугаар хавсралт, Тусгай хамгаалалттай газрын ойн сангаас 2023 онд бэлтгэх 30
Зураг 6. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны тогтоол, 2023.12.18, Дугаар 03 тогтоолын нэгдүгээр хавсралт, Ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллагуудын ойгоос бэлтгэх модны дээд хязгаар 31
Зураг 7. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны тогтоол, 2023.12.18, Дугаар 03 тогтоолын нэгдүгээр хавсралт, Ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллагуудын ойгоос бэлтгэх модны дээд хязгаарт хийсэн шинжилгээ 32
Зураг 8. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны тогтоол, 2023.12.18, Дугаар 03 тогтоолын хоёрдугаар хавсралт "Цагаан-Уул сумаас Мөрөн сум руу бэлтгэх модны хэмжээ" 32
Зураг 9. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны тогтоол, 2023.12.18, Дугаар 03 тогтоолын хоёрдугаар хавсралт, Цагаан-Уул сумаас Мөрөн сум руу бэлтгэх модны хэмжээ 33
Зураг 10. Байгалийн нөөц ашигласны орлого (2023 он) 50
Зураг 11. Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөгч (2023 он) 50
Зураг 12. Байгалийн нөөц ашигласны орлого 2024 он, ... 51
Зураг 13. Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөгч (2024 он) 51
Зураг 14. Монгол Улсын ойн сан /2020 оны байдлаар/ 59
Зураг 15. Монгол орны ойн сангийн талбай /талбай-мянган га/ /2020 оны байдлаар/ 59
Зураг 16. Ойн сангийн байгалийн ойн талбай модны төрлөөр, талбай- га 60
Зураг 17. Хөвсгөл, Сэлэнгэ аймгийн ойн нөөц ба түүний орлогын эзлэх хувийн харьцуулалт (2023 оны байдлаар) 60
Зураг 18. Ойн нөхөрлөлийн чадавхийн ерөнхий үнэлгээ 65
Зураг 19. Ойн нөхөрлөлийн менежментийн чадавх 65

УДИРТГАЛ

Монгол орны ой экологийн өндөр ач холбогдолтой боловч нийт газар нутгийнхаа 8–9 хувийг эзэлдэг, доройтлын эрсдэлд өртөмтгий салбарын нэг юм. Үүнд ойн өсөлт удаан, газарзүйн өндөрлөг байршилд байдаг зэрэг байгалийн хүчин зүйлс нөлөөлдөг. Гэсэн хэдий ч цаг уурын нөхцөлд зохицсон модны төрөл зүйл элбэгтэй, нөхөн сэргээх боломжтой хангалттай их нөөцтэй, экологийн ач холбогдол өндөртэй салбар юм. Монгол орны ойн нөөц багатай гэдэг нь ч ташаа ойлголт билээ.

Ойн үр өгөөж нь зөвхөн экологийн ач холбогдлоор хязгаарлагдахгүй. Ой бол амьжиргааны эх үүсвэр, ажлын байр бий болгох, цаашлаад импортыг орлох боломжтой нийгэм, эдийн засгийн өндөр ач холбогдолтой баялаг юм. Цаашилбал чадварлаг мэргэжилтнүүдтэй, он удаан жилийн түүх, туршлагатай энэ салбарт сайжруулах боломж их бий.

Монгол Улсын хувьд ойн салбарт баримталж буй бодлого нь хамгаалах, өсгөх гэсэн үзэл санаанд суурилсан байдаг. Энэ нь Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.5.3.3-т "Байгалийн ургамал, ойн дагалт нөөцийн экспорт болон үндсэн ашиглалтын огтлолын бүрэн хориглож, ойн сангийн нөөцийг 2 хувиар нэмэгдүүлнэ", 3.5.3.4-т "Мод орлох технологи нэвтрүүлэхийг дэмжих, энэ төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж түлшний асуудлыг цогц байдлаар шийдэх, мод, модон бүтээгдэхүүний импортыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ" гэсэн заалтуудаас тодорхой харагдана. Улмаар "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт ойн хомсдлоос сэргийлэх, ойг хамгаалах тухай дурдсанаас бус ашиглалтын талаар тодорхой байр суурь илэрхийлэгдээгүй бол, Монгол Улсын Ерөнхийлөгч 2021 оны 58 дугаар зарлигаар "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийг санаачлан өрнүүлж байгаа билээ.

Иймд Ойн тухай хууль бол зөвхөн салбарын зохицуулалт биш, харин үндэсний хөгжлийн болон аюулгүй байдлын бодлоготой шууд уялдсан стратегийн хууль юм.

Гэвч ойг хамгаалах, өсгөх үзэл санааг хэрэгжүүлж буй аргачлал нь үр дүнтэй, зөв эсэхийг дахин үнэлэх шаардлагатайг бодит үр дагавар, олон улсын туршлага харуулах боллоо. Монгол орны ойн дундаж насжилт өндөрсөж, үүнийг дагаад чанар муудаж байгаагаас гадна ойн хөнөөлт шавж, түймрийн эрсдэл төдийлөн буурсангүй. Нөгөө талд Монгол Улс ойгоос маш бага ашиг хүртэж байгаа улс хэвээр байгаа нь бид ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлж чадахгүй байгааг харуулж байна.

Иймээс ойн тухай хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, хэрэгжилтийн явцад гарч буй хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж буй эерэг болон сөрөг нөлөөллийг илрүүлэх зорилгоор хууль хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийлээ. Уг үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу боловсруулсан болно.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Ойн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн. Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь

Монгол Улсын Их Хурал 2012 онд Ойн тухай хуулийг баталж, дагаж мөрдөх болсон. Тус хууль нь 7 бүлэг, 47 зүйлтэй бөгөөд нийт 13 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Тус хуульд оруулсан 13 нэмэлт, өөрчлөлтийн 5 нь 2022, 2023 онд орсон нэмэлт, өөрчлөлт юм. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Ойн тухай хуулийн эрх зүйн зохицуулалт зарим талаар боловсронгуй болсон боловч практикт маргаан дагуулсаар байгаа асуудлууд цөөнгүй байна. Тухайлбал, Ойн тухай хууль болон бусад хуулийн уялдаа холбоо, хуулийн нэр томьёо, Ойн тухай хуультай холбогдон гарсан захиргааны хэм хэмжээний акт, тус хуулийн зарим зохицуулалт практикт хэрэгждэггүй, нэг мөр ойлгон хэрэгжүүлэхэд хүндрэлтэй зэрэг асуудлууд бий болоод байна.

Иймд тус хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтэд үнэлгээ хийх зайлшгүй шаардлага үүссэн хэмээн үзэж энэхүү судалгааг гүйцэтгэлээ.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээг тогтоохдоо үнэлгээ хийх ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, хүний нөөц, цаг хугацаа, гарах зардлыг заавал харгалзан үзэх нь чухал. Хуулийг бүхэлд нь үнэлэх ажиллагааны зардал ихэвчлэн хэт өндөр гардаг тул зөвхөн тухайн хуулийн зорилго, үнэлгээний шалгуурт хамгийн ихээр нөлөөлж болохуйц хуулийн зохицуулалтыг зөв сонгох шаардлагатай.

Иймээс дээр дурдсан хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хэрэгцээ шаардлагад тулгуурлан Ойн тухай хуулийн зорилт, тус хуулиар хэм хэмжээний акт батлахаар эрх олгосон зохицуулалт, төрийн болон орон нутгийн байгууллагын бүрэн эрх, засаглал, ойн мэдээллийн сан, ойн тооллого, ойн зохион байгуулалт, ойн нөхөрлөлийн үйл ажиллагаа, чиг үүрэг, ой ашигласны төлбөр, хамгаалалтын бүсийн ой, ойд хориглох үйл ажиллагаа, зам, дэд бүтэц, алслагдмал газар нутгийн ойн ашиглалттай холбоотой асуудал болон Ойн тухай хууль ба бусад хуулийн харилцан уялдааг судалж, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхээр тогтов.

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

"Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу Ойн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах 3 шалгуур үзүүлэлтийг сонгосон болно. Үүнд:

1. Зорилгод хүрсэн түвшин;

2. Практикт нийцэж байгаа байдал;
3. “Бусад үр дагавар.

1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

2012 онд батлагдсан Ойн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт тус хуулийн зорилтыг “*Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмших, ашиглах, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино”* гэж тодорхойлжээ.

Энэ хүрээнд тус хуулийн зорилт, нийтлэг зохицуулалтын үзэл баримтлал нь зорилгодоо хүрсэн эсэх, хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт болон Ойн тухай хууль дахь төрийн болон орон нутгийн байгууллагын бүрэн эрх, засаглалтай холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэхийг судлан үзнэ.

Хүснэгт 1. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1.	Ойн тухай хуулийн 1 дүгээр зүйл.	**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт** 1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмших, ашиглах, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
2.	Ойн тухай хуулийн 4.10 дахь хэсэг, 6.2 дахь хэсэг, 7.5 дахь хэсэг, 10.2 дахь хэсэг, 23.3 дахь хэсэг, 28.5 дахь хэсэг, 30.5 дахь хэсэг, 30^1.4 дэх хэсэг, 30^1.8 дахь хэсэг, 34.5 дахь хэсэг, 34.6 дахь хэсэг, 35.5 дахь хэсэг, 38.6 дахь хэсэг, 39.1 дэх хэсэг, 39.5 дахь хэсэг	**4.10.**Ойн сангийн тодорхой хэсгийг ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх журмыг Засгийн газар батална. **6.2**.Энэ хуулийн 6.1-д заасан мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. **7.5.**Ойн тооллого, ой зохион байгуулалт хийх журмыг Засгийн газар батална. **10.2**.Энэ хуулийн 10.1-д заасан журмыг холбогдох газрын саналыг үндэслэн төрийн захиргааны байгууллага боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. **23.3**.Ойн мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага, ажиллах журмыг төрийн захиргааны төв байгууллага батална. **28.5.**Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. **30.5.**Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх болон таримал ойг үнэлэх, хүлээн авах, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журмыг санхүү, төсвийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. **30^1.4.**Үржлийн материал бэлтгэх, үйлдвэрлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг санхүү, төсвийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. **30^1.8.**Үржлийн материал бэлтгэх, үйлдвэрлэх, худалдах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

		34.5.Энэ хуулийн 34.1-д заасан эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ, түүнийг олгох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. **34.6.**Энэ хуулийн 33.1-д заасан гэрээ байгуулах, 34.1-д заасан гарал үүслийн гэрчилгээ, түүнийг олгох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. **35.5.**Ойгоос мод бэлтгэх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. **38.6.**Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах үйл ажиллагааг зохицуулсан журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. **39.1.**Ойд үзүүлэх хортой нөлөөллийг багасгасан, түүнчлэн дэвшилтэт арга технологи нэвтрүүлсэн иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулах бөгөөд журмыг Засгийн газар батална. **39.5.**Энэ хуулийн 39.2-39.4, 39.10-т заасан урамшуулал олгох журмыг санхүүгийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.
3.	Ойн тухай хуулийн 3 дугаар бүлэг буюу 11-19 дүгээр зүйл	**3 дугаар бүлэг. Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх** /Ойн тухай хууль дахь төрийн болон орон нутгийн байгууллагын бүрэн эрх, засаглалтай холбоотой зохицуулалт зорилгодоо нийцэж буй эсэх/
4.	Ойн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1.9 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.3.19 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.3.2 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.3.9 дэх заалт	6.1.Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ойн төлөв байдал, ойн сангийн эзлэх талбайн хэмжээ, нөөц, бүрэлдэхүүн, үнэлгээ, тэдгээрийн өөрчлөлт, ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний талаарх цогц мэдээллийг агуулсан улсын хэмжээний ойн мэдээллийн сантай байна. 6.2.Энэ хуулийн 6.1-д заасан мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. **13 дугаар зүйл.Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх** 13.1.9.улсын ойн мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хэрэгжилтэд хяналт тавих; 14.3.Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ойг хамгаалах, нөхөн сэргээх, ашиглах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.3.19.ойн мэдээллийн нэгдсэн сан хөтлөх, бүрдүүлэх, баяжуулах, мэдээллээр хангах; 17.3.Аймаг, нийслэлийн Байгаль орчны газар нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 17.3.2.аймаг, нийслэлийн ойн мэдээллийн санг бүрдүүлж, төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангах; 18.3.Сум дундын болон сум, дүүргийн ойн анги нь дараах эрх, үүрэгтэй: 18.3.9. мэдээллийн санг эрхлэх;

1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Ойн тухай хуулийн холбогдох зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

Иймд тус судалгааны хүрээнд Ойн тухай хуульд дараах зүйл, заалтуудыг сонгон практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэллээ.

Хүснэгт 2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1.	Ойн тухай хуулийн 21 дүгээр зүйл	21 дүгээр зүйл. Ойн нөхөрлөл, түүний эрх, үүрэг
2.	Ойн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэг	**7 дугаар зүйл.Ойн тооллого, ой зохион байгуулалт, түүний санхүүжилт** 7.1.Ойн тооллого, ой зохион байгуулалтын ажлыг төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан ойн мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ. 7.2.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ойн тооллогыг таван жил тутам улсын хэмжээнд явуулж, ойн сангийн төлөв байдлыг шинэчлэн тогтооно. Ой зохион байгуулалтын ажлыг арван жил тутамд хийж, ойг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг шинэчлэн батална.
3.	Ойн тухай хуулийн 40 дүгээр зүйл	40 дүгээр зүйл.Төлбөр, хураамж
4.	Ойн тухай хуулийн 8 дугаар зүйл	8 дугаар зүйл.Хамгаалалтын бүсийн ой, түүний дэглэм

1.3.3. “Бусад үр дагавар” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Судалгааны хүрээнд Ойн тухай хуулийн дараах зохицуулалтуудыг үнэлсэн болно.

Хүснэгт 3. Бусад үр дагавар шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Холбогдох хэсэгт хамаарах асуудал
1.	Ойн тухай хуулийн 29 дүгээр зүйл	Ойн тухай хуулийн хориглох үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтын асуудал
2.	Ойн тухай хуулийн 9 дүгээр зүйл	Ашиглалтын бүсийн ойн асуудал
3.	Ойн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт	Зам, дэд бүтэцтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын асуудал
4.	Ойн тухай хуулийн 21 дүгээр зүйл	Ойн нөхөрлөлийн чиг үүрэг бусад байгууллагын чиг үүрэгтэй давхардаж буй эсэх талаар асуудал
5.	Бусад хууль	Бусад хууль, тогтоомжтой харилцан уялдаа, нийцэлтэй байгаа эсэх талаар асуудал

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа;
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших;
- Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших;
- Тохиолдол судлах.

Судалгааны явцад Ойн тухай хуульд заасан асуудалтай арга хэмжээнүүдийн талаарх зүйл, заалтын байх ёстой болон одоо байгаа, хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших, хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших, хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших, тохиолдол судлах харьцуулах хэлбэрийг ашиглана.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Шалгуур үзүүлэлтийг томьёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр Ойн тухай хуулийн сонгон авсан хэсэгт тохируулан дараах таамаглал дэвшүүлж, асуулт дэвшүүллээ.

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Ойн тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан хуулийн зорилттой холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх. Тус хуулийн зорилт урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцэж байгаа эсэх.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Ойн тухай хуульд заасан хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. Ойн тухай хууль дахь төрийн болон орон нутгийн байгууллагын бүрэн эрх, засаглалтай холбоотой зохицуулалт зорилгодоо нийцэж байгаа эсэх.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4. Ойн тухай хуульд заасан ойн мэдээллийн сантай холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх.

Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Ойн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан ойн нөхөрлөлийн үйл ажиллагаа, зохион байгуулалттай холбоотой зохицуулалт нь практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тухайн зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл байгаа эсэх.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Ойн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан ойн тооллого болон ойн зохион байгуулалттай холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл учирч байгаа эсэх.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. Ойн тухай хуулийн 40 дүгээр зүйл заасан ой ашигласны төлбөртэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? зохицуулалт нь практикт нийцэж байгаа эсэх. Тухайн зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл үүсэж байгаа эсэх.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4. Ойн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хамгаалалтын бүсийн ойтой холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээл үүсэж байгаа эсэх.

Бусад үр дагавар шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Ойн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан ойд хориглох үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтын хэрэгжилт, тулгамдаж буй асуудал.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Ойн тухай хуулийн 9 дүгээр зүйлд ашиглалтын ойн асуудал.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. Ойн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтад заасан зам, дэд бүтэцтэй холбоотой зохицуулалтад тулгамдаж буй асуудал.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4. Ойн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан ойн нөхөрлөлийн чиг үүрэг бусад байгууллагын чиг үүрэгтэй давхардаж буй эсэх.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 5. Ойн тухай хууль ба бусад хуулийн харилцан уялдаа, нийцэлтэй байгаа эсэх.

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийхдээ мэдээлэл цуглуулах дараах аргуудыг сонгож ашиглах нь зүйтэй гэж үзэв.

(а) Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах

Үүний хүрээнд нийтэд нээлттэй байгаа болон өмнө хийгдсэн судалгааны тайлан, бодлогын баримт бичиг, хууль, журмуудыг судлах, шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, энэхүү сэдвээр бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл уншиж судлах зэргээр тоон болон чанарын мэдээлэл цуглуулна.

(б) Холбогдох субъектээс судалгаа авах

БОУАӨЯ, ХХААХҮЯ, Ойн газар, ОМБ, ОН зэрэг оролцогч талуудаас хэрэгжилттэй холбоотой мэдээлэл, тайлан гаргуулж авна.

(в) Биечлэн судалгаа хийх

Хууль тогтоомж хэрэгжиж байгаа орчин нөхцөлд биечлэн очиж, ажиглалт хийх ба ярилцлагын аргыг ашиглан мэдээлэл цуглуулна

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилт болон бусад үр дагаврыг илрүүлэхийн тулд холбогдох судалгааны тайлан, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл, шүүхийн шийдвэрийг судлах, харьцуулсан шинжилгээ хийх, холбогдох байгууллагаас мэдээлэл авах зэрэг аргуудыг төлөвлөж, хэрэгцээтэй мэдээллийг оновчтой тодорхойлон цуглуулж, судалгааны багийн оролцоотойгоор хэрэгжүүллээ.

(а) Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд

Холбогдох хууль тогтоомж, сурах бичиг, эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл, гарын авлага, эрдэм шинжилгээний болон бусад хурлын эмхэтгэл, нэг сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл,статистик мэдээ, судалгааны тайлан зэргийг цуглуулж үнэлгээ хийхэд ашиглав. Судалгааны хэрэгжүүлэх үе шатанд ашигласан эх сурвалжийг энэхүү судалгааны ном зүй хэсэгт дэлгэрэнгүй оруулсан болно.

(б) Холбогдох субъектээс судалгаа авах хүрээнд

БОУАӨЯ, ХХААХҮЯ, Ойн газар, ОМБ, ОН зэрэг оролцогч талуудаас хэрэгжилттэй холбоотой мэдээлэл, тайлан гаргуулав. Судалгааны хэрэгжүүлэх үе шатанд ашигласан эх сурвалжийг энэхүү судалгааны ном зүй хэсэгт дэлгэрэнгүй оруулсан болно.

(в) Биечлэн судалгаа хийх хүрээнд

Судалгааны баг Ойн тухай хуулийг хэрэгжүүлэхэд тулгамдаж асуудлыг тодорхойлох зорилгоор 4 аймагт фокус бүлгийн уулзалтыг зохион байгуулсан бөгөөд тус уулзалтад ойн анги, ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөл, байгаль орчныг газрын нийт 90 төлөөллийг хамруулсан. Үүнээс гадна Ойн тухай хуулийн хэрэгжилтийн оролцогч талууд болох аймаг сумын ИТХ-ын гишүүд, аймаг, сумын Засаг дарга нар, мэргэжлийн холбоодын төлөөлөл, салбарын экспертүүд гэх мэт хүмүүстэй ганцаарчилсан уулзалт хийж, мэдээлэл цуглуулсан.

График 1. Фокус бүлгийн ярилцлагад хамрагдсан төлөөлөл (Аймгаар)

Дээрх графикаас үзвэл, фокус бүлгийн ярилцлагад хамрагдсан 90 хүний 27 буюу 30 хувь нь Сэлэнгэ аймгаас, 15 буюу 16.7 хувь нь Булган аймгаас, 34 буюу 37.8 хувь нь Хөвсгөл аймгаас, үлдсэн 14 буюу 15.5 хувь нь Төв аймгаас тус тус оролцсон байна.

Судалгааны багийн хувьд фокус бүлгийн ярилцлагад ойн салбарын засаглалд оролцдог олон талын байгууллагын хамруулахыг зорьсон бөгөөд Сэлэнгэ, Булган аймагт ойн анги, ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөл болон байгаль орчны газрын төлөөллийг жигд оролцуулсан болно.

График 2. Фокус бүлгийн ярилцлагад хамрагдсан төлөөлөл (Оролцогчоор)

Фокус бүлгийн ярилцлагад хамрагдсан 90 хүний 25 буюу 27.8 хувь нь ойн ангийн, 22 буюу 24.4 хувь нь ойн мэргэжлийн байгууллагын, 15 буюу 16.7 хувь нь ойн нөхөрлөлийн 28 буюу 31.1 хувь нь Байгаль орчны газрын төлөөлөл байв.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд Ойн тухай хуулийн зүйл, заалтуудыг сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу дараах байдлаар үнэлгээ хийсэн.

3.1."Зорилгод хүрсэн түвшин" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Ойн тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан хуулийн зорилттой холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх. Тус хуулийн зорилт урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцэж байгаа эсэх.

Монгол Улсын Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт *"Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна"* гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт *"Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн"* гэж тус тус заажээ.

Иймээс ойн өмчлөлийн эрхийг төр хэрэгжүүлж, ойг хамгаалах, нөхөх сэргээх, үржүүлэх, эзэмших, ашиглахтай холбоотой харилцааг бие даасан Ойн тухай хуулиар зохицуулж байна. Энэ хүрээнд Ойн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д *"Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмших, ашиглах, ой хээрийн түймрээс урьдчилсан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино"* гэж заасан байна. Хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмших, ашиглах гэдэг нь товчоор ойн менежмент хэрэгжүүлэх тухай ойлголт юм.

Иймээс тус хууль зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлэхдээ ойн менежментийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдээр үнэлэх боломжтой юм. Үүнд:

(а) Ой хамгаалагдсан эсэх

Ойд эрсдэл учруулдаг үндсэн гурван хүчин зүйл байдаг нь ойн түймэр, хортон шавж, мөн хууль бус мод огтлол юм. Ойн түймрийн хохирлын хэмжээ жил ирэх тусам буурч байгаа ч эрсдэл буураагүй байна. Монгол Улсын хэмжээнд 2012-2023 оны хооронд буюу 12 жилийн хугацаанд нийт 2,104 удаагийн ой хээрийн түймэр гарч, 589.3 га ойн талбай түймэрт нэрвэгдэж, 269.2 тэрбум төгрөгийн экологийн хохирол учирч, түймэр унтраахад 9.9 тэрбум төгрөг зарцуулжээ.[1]

Зураг 1. Түймэрт өртсөн талбай, га



[1] Ойн менежментийн төлөвлөгөө

Урт хугацааны хандлагыг доорх зургаас харвал, түймэрт өртсөн талбайн хэмжээнд бууралт ажиглагдаж байна. Иймээс хуулийн ой хээрийн түймрээс хамгаалах тухай зорилго хэрэгжсэн гэж үзэж болох ч түймрийн бодит хохирлоос гадна түймрийн эрсдэл буурсан эсэхийг зайлшгүй харгалзаж үзэх хэрэгтэй.

Өнгөрсөн хугацаанд түймэр гарсан шалтгааны хувьд аянга цахилгаан, галт уулын дэлбэрэлт гэх мэт байгалийн жамаар түймэр гарсан түймэр маш бага хувийг эзэлдэг байна. Харин хүмүүсийн хайхрамжгүй үйлдлээс болж гарсан ойн түймэр 95 хувийг эзэлжээ.[2] Энэ нь шалтгааны эрсдэл буураагүйг илэрхийлнэ. Нөгөө талаас түймэртэй тэмцэх дэд бүтэц, материаллаг бааз тал дээр дутагдалтай, сайжруулах шаардлагатай хэвээр байна.

Харин хөнөөлт шавжийн голомт, тархалтын талбай нэмэгдсэн ч тэмцэл хийсэн талбай нэмэгдээгүй. Ойн экосистемд сөрөг нөлөө үзүүлж буй үндсэн хүчин зүйлүүдийн нэг нь ойн хөнөөлт шавж, өвчний хөнөөл юм.

Сүүлийн жилүүдэд цаг агаарын өөрчлөлт, хуурайшилт, түймэр, хүний ойд учруулж буй сөрөг үр дагавар, хөнөөлт шавж, өвчний үржин олшрох биологийн зүй тогтол зэрэгтэй холбогдон ойн хөнөөлт шавж, өвчин хэт олширч, нөлөөлөлд өртөгдсөн ой хатаж хуурайшин ойн чанараа алдаж байна.

Зураг 2. Ойн хөнөөлт шавжийн голомт, тархалт, тэмцэл хийсэн талбай, га

Ойн хөнөөлт шавжийн голомт, тархалтын талбайн хэмжээ сүүлийн жилүүдэд огцом өссөн нь цаашид мөн өсөх эрсдэлтэй байгааг харуулж байна (Зураг 2). Харин хөнөөлт шавжтай тэмцэх ажлын хувьд учир арга зүй, мэдлэг чадвар, техникийн тал дээр сайжруулалт шаардлагатай байгааг Ойн газраас улсын ойн менежментийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

Түүнчлэн, хууль бус мод бэлтгэл нэмэгдэж байгаа гэж үзэх үндэслэл байна. Хууль бус мод бэлтгэлийн цар хүрээний асуудал дээр талууд өөр өөр байр суурьтай байна. Ойн газраас боловсруулсан ойн менежментийн төлөвлөгөөнд *"Сүүлийн жилүүдэд хууль бус мод бэлтгэл харьцангуйгаар буурч байгаа"* тухай дурдсан бол Азийн Хөгжлийн Банкны судалгааны тайланд хууль бус мод бэлтгэлийн талаар албан ёсны тоо баримт байхгүйг дурдаад Монгол Улсад жилдээ

[2] Мөн тэнд.

зөвхөн түлээний зориулалтаар хэрэглэж буй модны хэмжээ л гэхэд жилд ойгоос бэлтгэх модны зөвшөөрлийн хэмжээнээс илүү байгаа гэсэн тооцоо гаргажээ.

Зураг 3. Ойгоос бэлдсэн модны хэмжээ ба хүн ам, м^3/өрхийн тоо

Манай улсад мод нь голдуу түлээ буюу эрчим хүчний эх үүсвэр болгож ашиглагддаг. Харин эрчим хүчний эх үүсвэрийн хувьд сүүлийн 10 орчим жилийн туршид ялангуяа орон нутгийн түвшинд дорвитой өөрчлөлт гараагүй. Тиймээс түлээний модны хэрэглээ хүн амын өсөлтөөс хамааран нэмэгдсэн байх үндэслэлтэй. Харин 2014 онтой харьцуулахад Монгол Улсын нийт өрхийн тоо 21 хувь, тэр дотроо орон нутагт амьдарч буй өрхийн тоо 11 орчим хувиар өссөн байхад жилд зөвшөөрөлтэй бэлтгэсэн модны тоонд үүнтэй уялдсан өөрчлөлт ажиглагдахгүй байна (Зураг 3). Энэ нь өсөн нэмэгдэж буй эрэлтийг хууль бусаар бэлтгэсэн модоор хангаж байгаа гэж үзэх үндэслэл болж байна.

(б) Урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцэж байгаа эсэх

2020 оноос эхлэн Монгол Улсын хөгжлийн бодлогод ойг хамгаалах, ашиглахтай холбоотой тодорхой зорилгыг дэвшүүлсэн. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт заасан "Ногоон хөгжил" буюу зорилго 6-д *"Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна"* гэж заасан.

Энэхүү зорилтын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 6.1.3-т *"Ой зохион байгуулалтыг тогтмол явуулж, ойн экосистемийн нөөц, төлөв байдлыг үнэлнэ"* гэж, 6.2.3-т *"Ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлыг зориудаар өсгөн үржүүлэх, тарималжуулах, ойн агропарк байгуулж, ашиглалтын нөөцийг бүсчлэн бий болгож байгалиас шууд авч ашиглах дарамтыг бууруулна"* гэж, 6.2.4-т *"Ойжуулах, ойн тэлэн ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, ой хамгааллын арга хэмжээ авах замаар ойн хомсдолоос сэргийлэн, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нийт газар нутгийн 9 хувьд хүргэж, нүүрсхүчлийн хийн шингээлтийг нэмэгдүүлнэ"* гэж тус тус заажээ.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын "Ногоон хөгжлийн сэргэлт" гэсэн 5 дугаар зорилтын хүрээнд "Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад дорвитой хувь нэмэр оруулах зорилгоор "Тэрбум мод" үндэсний

хөдөлгөөнийг үр дүнтэй өрнүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ" гэж заасан.[3]

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2021 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 76 дугаар чуулган дээр Монгол Улс "Тэрбум мод тарьж ургуулах үндэсний хөдөлгөөн өрнүүлэх" болсныг зарлаж, мөн оны 10 дугаар сарын 4-ний өдөр "Засгийн газарт чиглэл өгөх тухай" Ерөнхийлөгчийн 58 дугаар зарлиг гарсан. Уг зарлигт эх дэлхий, байгаль орчноо хайрлан зохицон амьдрах монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлэхийг дурдаж, зарлигийн 1.4-т *"Цөлжилттэй тэмцэх, газрын доройтлыг бууруулах зорилгоор агро-ойг хөгжүүлж, иргэдийн амьжиргааны тогтвортой эх үүсвэрийг бий болгох, иргэн, аж ахуйн нэгжид татварын болон татварын бус бодлогоор дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчин бүрдүүлж, халамжаас-хөдөлмөрт шилжих цогц бодлоготой мод тарьж ургуулах бүх нийтийн үйлсийг уялдуулах"* гэж заасан.[4]

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолоор баталсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний 2-т "Эрх зүйн орчныг боловсронгуй болгох" хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан. Үүнд:

- Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчныг үе шаттайгаар бүрдүүлэх.
- Агро ойн аж ахуйг хөгжүүлэх ажлын хүрээнд тариалангийн талбайг хамгаалах зориулалт бүхий ойн зурвасыг байгуулах, жимс, жимсгэнийн аж ахуйг хөгжүүлж иргэдийн амьжиргааны тогтвортой эх үүсвэрийг бий болгоход, иргэн аж ахуйн нэгжид татварын болон татварын бус бодлогоор дэмжлэг үзүүлэх, эрх зүйн орчин бүрдүүлэх.
- Эрчим хүчний хэмнэлттэй, ногоон технологи нэвтрүүлсэн аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгох.
- Мод үржүүлгийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжийн холбогдох техник, тоног төхөөрөмжийг гааль, НӨАТ, газар болон ус ашигласны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулж шийдвэрлүүлэх
- Хот, суурины ногоон байгууламжийн тухай хуулийг боловсруулж батлуулах.
- Модлог ургамлын үр, тарьц, суулгац бэлтгэх, импортлох, хадгалах, худалдан борлуулах, тээвэрлэх, ашиглах, үрийн нөөцийн улсын сан бүрдүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох.
- "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ыг шинэчлэн батлуулж, орлогыг хууль, журамд заасан зориулалтын дагуу зарцуулж, хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заажээ.[5]

---

[3] Монгол Улсын Их Хурлын Тогтоол, Дугаар 106, "Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай", 2021, https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390082532431

[4] Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Дугаар 58, "Засгийн газарт чиглэл өгөх тухай", 2021, https://president.mn/20893/

[5] Монгол Улсын Засгийн Газрын Тогтоолын хавсралт, Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389636287911&showType=1

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 86-д таримал ой бий болгох, улсын санд хүлээн авах, иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын мод тарьж ургуулах ажлыг урамшуулах, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох, ногоон эдийн засгийг дэмжих, ойн нүүрстөрөгчийн хуримтлалыг тооцож, олон улсын нүүрстөрөгчийн зах зээлд оролцох суурь нөхцөлийг бүрдүүлэх, ойн генетик нөөцийн талаарх зохицуулалтыг тодорхой болгох, ойн ангийг босоо бүтэцтэй болгож, ойн салбарын бодлого, хуулийн хэрэгжилтийг орон нутагт хангуулах, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтыг шинээр бий болгох, хушны самрыг биологийн нөөц болон ашиглалтын нөөцөд тулгуурлан дуудлага худалдаагаар зохистой ашиглах, хамгаалах, зохицуулалтыг бий болгох зорилтыг дэвшүүлсэн.[6]

Дүгнэн үзвэл, Монгол Улсын Их Хурлаас баталсан урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газраас баталсан урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээнд "Ойн тухай хуулийг ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагын тод тарьж ургуулах санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох, ногоон эдийн засгийг дэмжих, ойн нөөцийг зохистойгоор ашиглах, хамгаалах, зохицуулалтыг бий болгох" хүрээнд Ойн тухай хуулийг сайжруулахаар тусгажээ.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Ойн тухай хуулийн 1 дүгээр зүйлд тус хуулийн зорилтыг "Ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх эзэмших, ашиглах, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино" гэж заасан нь хэт ерөнхий бөгөөд тус хуулиар зохицуулсан зарим харилцааг огт дурдаагүй байна.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлаас баталсан урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газраас баталсан урт хугацааны хөгжлийн бодлогоор дэвшүүлсэн зорилго, зорилттой уялдаагүй.

Иймд Монгол Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газраас баталсан урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээнд уялдуулах замаар Ойн тухай хуулийг зорилго, зорилтыг "Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагын мод тарьж ургуулах санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох, ногоон эдийн засгийг дэмжих, ойн нөөцийг зохистойгоор ашиглах, хамгаалах, зохицуулалтыг бий болгох" гэсэн агуулгатай уялдуулан илүү боловсронгуй болгож, Ойн тухай хуулиар зохицуулагдах харилцааны хүрээг өргөжүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн гэж үзэж байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. *Ойн тухай хуульд заасан хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх.*

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй 2012 оны Ойн тухай хуулиар 15 хэм хэмжээний акт батлах эрхийг холбогдох төрийн байгууллагад олгосон байна. Эдгээр 15 журмыг батлах эрх бүхий субъектээр нь ангилан үзвэл Засгийн газарт 3, Засгийн газрын гишүүн 2, Санхүү төсвийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлах 3, Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 5, төрийн захиргааны төв байгууллага 1, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 1 журмыг тус тус батлахаар хуульчилсан байна.

[6] Монгол Улсын Засгийн Газрын Тогтоол, Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, https://legalinfo.mn/mn/detail?lawId=17333392437841&showType=1

Хүснэгт 4. ОтХ-аар хэм хэмжээний акт батлах эрхийг олгосон заалт, батлах субъект

Холбогдох төрийн байгууллага	Эрх олгосон байдал байдал, өөрчлөлт
Засгийн газар	- 4 дүгээр зүйлийн 4.10 дахь хэсэг - 7 дугаар зүйлийн 7.5; (2013 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулж "ойн зохион байгуулалт" байсныг "ойн тооллого, ойн зохион байгуулалт" болгож журмын хүрээг нэмэгдүүлсэн.) - 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг
Засгийн газрын гишүүн	- 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг - 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэг
Санхүү төсвийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран	- 30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсэг - 30^1 дугаар зүйлийн 30^1.4 дэх хэсэг (2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн Ойн тухай хуулийн нэмэлтээр шинээр бий болгосон.) - 39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсэг
Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	- 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг (2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулж төрийн захиргаа төв байгууллага батлах байсныг Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болгосон.) - 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсэг (2013 оны 7 дугаар 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулж "гарал үүслийн гэрчилгээний загвар, түүнийг олгох журам" байсныг өөрчилж эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ, түүнийг олгох" болгож журмын хүрээг нэмэгдүүлсэн.) - 34 дүгээр зүйлийн 34.6 дахь хэсэг (2023 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн Ойн тухай хуулийн нэмэлтээр шинээр бий болгосон.) - 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсэг (2015 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн Ойн тухай хуулийн нэмэлтээр шинээр бий болгосон.) - 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэг
Төрийн захиргааны төв байгууллага	- 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэг (2012 оны Ойн тухай хуульд байсан)
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	- 30^1 дугаар зүйлийн §30^1.8 дахь хэсэг (2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн Ойн тухай хуулийн нэмэлтээр шинээр бий болгосон.)
НИЙТ	**Хэм хэмжээний акт батлах эрхийг олгосон 15 журам байна.**

Эдгээр 15 журмын 11 журам нь 2012 оны Ойн тухай хуулийг батлах үед хуульчлагдсан байсан бөгөөд өнгөрсөн хугацаанд тус 11 журмын хоёр журмыг өөрчилсөн. Иймхүү өөрчлөхдөө тухайн журмаар зохицуулагдаж байсан харилцааны агуулга, хүрээг нэмсэн байна.

Харин 4 журмыг тус хуульд нэмэлт оруулах байдлаар шинээр бий болгосон байна. Тухайлбал, 2015 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн Ойн тухай хуулийн нэмэлтээр **35 дугаар зүйлийн 35.5-д заасан журам** батлах эрхийг, 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн Ойн тухай хуулийн нэмэлтээр **30^1 дугаар зүйлийн 30^1.4 дэх хэсэг, 30^1 дугаар зүйлийн §30^1.8-д заасан журам** батлах эрхийг, 2023 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн Ойн тухай хуулийн нэмэлтээр **34 дүгээр зүйлийн 34.6-д заасан журам** батлах эрхийг тус тус шинээр бий болгожээ.

Дээрх Ойн тухай хуульд журам батлахаар эрх олгосон 15 заалтын хүрээнд батлагдсан журмууд хүчин төгөлдөр эсэхийг шалгаан үзэхэд:

Хүснэгт 5. ОтХ-д заасны дагуу батлагдсан хэм хэмжээний актын жагсаалт

Батлах эрх бүхий субъект	Журмын нэр	Журмын холбоос
Засгийн газар	4 дүгээр зүйлийн 4.10 дахь хэсэг. Ойн сангийн тодорхой хэсгийг ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх журам	Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журам, 5 зүйл, 17 заалт /Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 227 дугаар тогтоолын хавсралт/ https://legalinfo.mn/mn/detail?lawId=202553
	7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг. Ойн тооллого, ой зохион байгуулалт хийх журам.	Ой зохион байгуулалт хийх журам, 7 зүйл, 26 заалт, / Засгийн газрын 2013 оны 105 дугаар тогтоолын хавсралт/ https://legalinfo.mn/mn/detail?lawId=205818
	39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг. Ойд үзүүлэх хортой нөлөөллийг багасгасан, түүнчлэн дэвшилтэт арга технологи нэвтрүүлсэн иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулах журам	Ойд үзүүлэх хортой нөлөөллийг багасгасан, дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам, 4 зүйл, 12 заалт /Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 59 дүгээр тогтоолын хавсралт/ https://legalinfo.mn/mn/detail?lawId=202610
Засгийн газрын гишүүн буюу Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг. Энэ хуулийн 6.1-д мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх журам	Ойн мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх журам, 3 зүйл, 23 заалт, /Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 02 дугаар сарын 19 - ны өдрийн А/53 дугаар тушаалын 03 дугаар хавсралт/, https://legalinfo.mn/mn/detail?lawId=206053&showType=1
	28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэг. Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх журам	Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх журам, 7 зүйл, 52 заалт, /Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/684 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт/ https://legalinfo.mn/mn/detail?lawId=16123488810501&showType=1
	10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг. Улсын тусгай хэрэгцээний газрын ойд явуулах ойн аж ахуйн арга хэмжээг зохицуулах журам	Улсын тусгай хэрэгцээний газрын ойд ойн аж ахуйн арга хэмжээ явуулах журам, 4 зүйл, 37 заалт /Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/134 дугаар тушаалын хавсралт/ https://legalinfo.mn/mn/detail?lawId=205864&showType=1
	34 дүгээр зүйлийн 34.5. 34.1-д заасан эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ, түүнийг олгох	Гарал үүслийн гэрчилгээ олгох, хяналт тавих журмыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 153 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан боловч хүчингүй болгосон. https://legalinfo.mn/mn/detail?lawId=205940
	34 дүгээр зүйлийн 34.6 дахь хэсэг. Энэ хуулийн 33.1-д заасан гэрээ байгуулах, 34.1-д заасан гарал үүслийн гэрчилгээ, түүнийг олгох журам	Ойгоос мод бэлтгэх журмыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн А/451 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт боловч хүчингүй болгосон. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140907214931&showType=1
	35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсэг. Ойгоос мод бэлтгэх журам	Ойгоос мод бэлтгэх журмыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн А/451 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан боловч хүчингүй болгосон. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140907214931&showType=1

	38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэг. Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах үйл ажиллагааг зохицуулсан журам	Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журмыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/450 дугаар тушаалын хавсралт баталсан боловч хүчингүй болгосон. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760455531521
Санхүү төсвийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран	30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсэг. Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх болон таримал ойг үнэлэх, хүлээн авах, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам	Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах журмыг Сангийн сайд, Байгаль орчны сайдын хамтарсан 2009 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 139/154 дүгээр тушаалын хавсралт баталсан боловч хүчингүй болгосон. https://legalinfo.mn/mn/detail?lawId=207182
	30^1 дугаар зүйлийн $30^1.4$ дэх хэсэг. Үржлийн материал бэлтгэх, үйлдвэрлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх журам	Уг журмыг батлаагүй. Шалтгаанаа "Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 05 дугаар сарын 21 -ны өдрийн 1/2702 дугаартай албан бичгээр батлагдсан. Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсаны дараа Үржлийн материал бэлтгэх, үйлдвэрлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг санхүү, төсвийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлуулна" гэж тайлбарласан. /https://mecc.gov.mn/storage/media/0e2bc4cc-9591-4420-b3f8-66b362e20be6.pdf,7 дахь тал/
	39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсэг. Энэ хуулийн 39.2-39.4, 39.10-т заасан урамшуулал олгох журам	Ойн тухай хуулиар **Нэгдүгээрт,** Ойн тухай хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг урамшуулах, **Хоёрдугаарт,** Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр бойжуулсан чанартай тарьц, суулгац, тарьсан мод, бут, сөөг, таримал ойг урамшуулах, **Гуравдугаарт**, Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр ой, хээрийн түймэр, хөнөөлт шавжтай тэмцсэн тохиолдолд урамшуулах 3 агуулгыг хуульчилсан. Гэвч ганц буюу Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр бойжуулсан чанартай тарьц, суулгац, тарьсан мод, бут, сөөг, таримал ойг урамшуулах хүрээнд журмыг баталсан бөгөөд үлдсэн хоёр тохиолдолд хамаарах урамшууллыг зохицуулалтад хамаарах журмыг өнөө хэр батлаагүй. Ойг хамгаалах, тарьц, суулгац ургуулах ажлыг урамшуулах журам, 11 зүйл, 27 зүйл, / Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын 2015 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А-140/63 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт/, https://legalinfo.mn/mn/detail?lawId=206743
Төрийн захиргааны төв байгууллага буюу Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэг. Ойн мэргэжлийн байгууллагын ажиллах журам	Ойн мэргэжлийн байгууллагын ажиллах журмыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/428 дугаар тушаалын хавсралтаар баталсан боловч хүчингүй болгосон. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760380853021

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	30^1 дугаар зүйлийн §30^1.8. Үржлийн материал бэлтгэх, үйлдвэрлэх, худалдах журам	Уг журмыг батлаагүй.Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн 1/2702 дугаартай албан бичгээр батлагдсан. Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсаны дараа Үржлийн материал бэлтгэх, үйлдвэрлэх, худалдах журмыг боловсруулж, батлуулна. https://mecc.gov.mn/storage/media/0e2bc4cc-9591-4420-b3f8-66b362e20be6.pdf 7 дахь тал.

Дээрх хүснэгтээс үзвэл, Ойн тухай хуульд заасан 15 журмаас:

- Засгийн газрын баталсан 1/ Ойн сангийн тодорхой хэсгийг ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх журам, 2/ Ойн тооллого, ой зохион байгуулалт хийх журам, **3/** Ойд үзүүлэх хортой нөлөөллийг багасгасан, түүнчлэн дэвшилтэт арга технологи нэвтрүүлсэн иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулах 3 журам хүчин төгөлдөр үйлчилж байна.
- Засгийн гишүүн буюу Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталсан 1/ Ойн мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх журам, **2/** Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх журам, 3/ Улсын тусгай хэрэгцээний газрын ойд ойн аж ахуйн арга хэмжээ явуулах журам хүчин төгөлдөр үйлчилж байна.
- Санхүү төсвийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталсан Ойг хамгаалах, тарьц, суулгац ургуулах ажлыг урамшуулах журам хүчин төгөлдөр үйлчилж байна.

Эдгээр хүчин төгөлдөр үйлчилж буй 7 журам нь нийт 41 зүйл, 194 заалт бүхий харилцааг зохицуулж байгаа бөгөөд цаашид хуулийн шинэчлэхдээ дээрх агуулгыг хуульд тусгах эсэх талаар тухайлан судлах зүйтэй. Учир нь дээрх журмуудад тусгагдсан зарим зохицуулалтыг нь журамд бус хуульд тусгасан шаардлагатай байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн "Захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох тухай" Дугаар А/68 тушаалаар Ойн тухай хуулийн хүрээнд үйлчилж байсан 10 журмыг хүчингүй болгосон.[7] Энэ нь Ойн тухай хуулиас давсан зохицуулалттай хэм хэмжээний актыг хүчингүй болгосон эерэг нөлөөллийг бий болгож байгаа ч зарим төрлийн харилцаанд эрх зүйн хийдэл үүсэх нөхцөлийг бий болгох эрсдэлийг дагуулж байна.

Түүнчлэн, Ойн тухай хуулиар хэм хэмжээний актыг батлах эрхийг шинээр олгосон хоёр зохицуулалтын хүрээнд эрх бүхий этгээд тус 2 журмыг батлаагүй байна. Ийнхүү батлаагүй шалтгаанаа хуулийн шинэчилсэн найруулгыг баталсны дараагаар журмын төслийг боловсруулна гэжээ. Үүнээс төрийн байгууллагын хувьд журам батлахыг урьтал болгож байгаа бөгөөд тухайн журмаар зохицуулагдах харилцаа нь хуулиар зохицуулах харилцаа мөн биш эсэхэд огт дүгнэлт өгдөггүй болохыг илтгэж байна.

[7] Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын тушаал, Дугаар А/68, Захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох тухай", https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140907175371

Нөгөөтээгүүр, төрийн байгууллагаас өөрт эрх олгосон, иргэн аж ахуйн нэгжид үүрэг болгосон захиргааны хэм хэмжээний актыг түргэн, шуурхай баталдаг бөгөөд ой хамгаалах, иргэдийг урамшуулахтай холбоотой хэм хэмжээний актыг батлахад учир дутагдалтай хандаж байна. Жишээлбэл, Ойн тухай хуулиар **Нэгдүгээрт,** Ойн тухай хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг урамшуулах, **Хоёрдугаарт,** Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр бойжуулсан чанартай тарьц, суулгац, тарьсан мод, бут, сөөг, таримал ойг урамшуулах**, Гуравдугаарт,** Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр ой, хээрийн түймэр, хөнөөлт шавжтай тэмцсэн тохиолдолд урамшуулах 3 агуулгыг хуульчилсан.

Гэвч зөвхөн иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр бойжуулсан чанартай тарьц, суулгац, тарьсан мод, бут, сөөг, таримал ойг урамшуулах талаар журмыг баталсан бөгөөд үлдсэн 2 урамшууллыг зохицуулалтад хамаарах журмыг батлаагүй байна.

Дээрхээс үзвэл, Ойн тухай хуульд журам батлахаар эрх олгосон зохицуулалт нь практикт бүрэн хэрэгжихгүй байна. Сүүлийн жилүүдэд төрийн эрх бүхий байгууллагын зүгээс хэм хэмжээний актаар зохицуулагдаж буй харилцааг багасгах чиглэлд анхаарч ажилласан бөгөөд энэ хүрээнд Ойн тухай хуульд хамаарах 6 журмыг хүчингүй болгосон байна. Ингэснээр одоо хүчин төгөлдөр үйлчилж буй /судалгааны багийн зүгээс судалснаар/ 7 журмын 41 зүйл, 194 заалт байна. Мөн хоёр хэм хэмжээний актыг ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэх боловсруулах ажил хүлээгдэж байна. Энэ нь Ойн тухай хуулийн үзэл баримтлал болон хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Иймд Ойн тухай хуулийг боловсронгуй болгож засаж сайжруулахдаа юун түрүүнд өмнө журмаар зохицуулагдаж байсан харилцааг хуульд тусгах шаардлагатай эсэхийг судалж, дүгнэлт өгөх шаардлагатай.

Судалгааны багийн зүгээс Ойн тухай хуулиар болон тухайлсан хэм хэмжээний актаар зохицуулах харилцааг ялган зааглах үүднээс дараах саналыг хүргүүлж байна. Энэхүү саналд үндэслэж 15 журмаас хуульд оруулах журмыг сонгох тодорхойлох шаардлагатай.

Захиргааны хэм хэмжээний акт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим, хүний эрх, эрх чөлөөг хангасан байхыг шаардахаас гадна хууль дээдлэх зарчмын дагуу бусад хууль тогтоомжид нийцсэн байхыг шаардана. Өөрөөр хэлбэл, хуульд нийцсэн байх шаардлагын хүрээнд захиргааны хэм хэмжээний акт хуулиас давсан, хуультай зөрчилдсөн зохицуулалтгүй, хуулиар нэгэнт зохицуулсан харилцааг хэм хэмжээний актаар давхардуулан, зэрэгцэн зохицуулахгүй байхыг ойлгоно.

Хуулиас давсан зохицуулалт агуулсан эсэх тухайд тус журам нь **нэгдүгээрт,** Үндсэн хууль болон бусад хуульд тусгагдсан "гагцхүү хуулиар..." гэсэн зохицуулалтын хүрээнд, **хоёрдугаарт** хэм хэмжээний актын зохицуулалтын хүрээ буюу эрх шилжүүлж буй хуулиар олгогдсон хүрээ, хязгаарын хувьд тусгайлан эрх олгож буй хуулийн агуулга, зорилго, хүрээнд байх ёстой.[8]

Тухайн зохицуулалтыг хууль, журамд тусгахын тулд тодорхой шаардлагыг хангасан байх ёстой. Тодруулбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлэгт заасан хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, хориглосон болон ямар нэг байдлаар хөндсөн агуулга бүхий зохицуулалттай эсэх,

[8] Д.Баттулга, "Хэм хэмжээний актаар зохицуулах харилцааны хүрээ, хязгаар, болон хяналтын зарим асуудлыг боловсронгуй болгох нь", (Уб, 2016), 8 дахь тал, https://legaldata.mn/b/338

гагцхүү хуулиар буюу тусгайлан эрх олгож буй хуулийн агуулга, зорилго, хүрээнээс давсан зохицуулалттай эсэх, тогтмол давтагдах процессын шинжтэй зохицуулалт агуулсан эсэх, нэг удаа батлахад удаан хугацаанд тогтвортой мөрдөгддөг хэм хэмжээ агуулсан эсэх гэх мэт шаардлагыг хангасан байх ёстой.

Дээрхээс дүгнэвэл, Ойн тухай хуулиар Засгийн газарт 3, Засгийн газрын гишүүн 2, Санхүү төсвийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлах 3, Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 5, төрийн захиргааны төв байгууллага 1, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 1 журмыг тус тус батлахаар хуульчилсан бөгөөд эдгээр хэм хэмжээний актын хэрэгжилт нь хуулийн зорилгод сөргөөр нөлөөлж байна.

Учир нь тухайн 15 хэм хэмжээний актаас практикт 7 журам хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Бусад хэм хэмжээний актуудын тухайд 6 журмыг хүчингүй болгосон бөгөөд 2 журам нь өнөөдрийг хүртэл батлагдаагүй байна.

Түүнчлэн, хүчингүй болсон, батлагдаагүй 8 журмаар нарийвчлан зохицуулах ёстой байсан асуудлын хүрээнд эрх зүйн хийдэл буюу зохицуулагдаагүй харилцааг бий болгож байна. Нэгэнт хуульд тодорхой байдлаар тусгаагүй асуудлын хүрээнд журам батлахаар хуульд заасан учир тухайн асуудлыг зохицуулсан эрх зүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатай байдаг.

Нөгөөтээгүүр, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 7 журмын тухайд Ойн тухай хуулийн зохицуулалтыг нарийвчилсан тусгасан бөгөөд тус харилцааг хуулиар бус хэм хэмжээний актаар зохицуулж, энэ нь Ойн тухай хуулийг зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэж байна.

Өөрөөр хэлбэл, Ойн тухай хуулийн зохицуулалтууд тус хуулийн зорилтыг хангахад чиглэж байх боловч үүнээс илүүтэй журмын зохицуулалтууд нь хуулиас давсан, тухайн харилцааг зохицуулах, ОтХ-ийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэж байхыг үгүйсгэхгүй юм. Хэдийгээр Ойн тухай хуулиар эрх олгосон хэм хэмжээний актыг багасгасан ч энэ нь бодит шийдэл биш.

Иймд Ойн тухай хуулийг засаж сайжруулах, боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байна. Ийнхүү боловсронгуй болгохдоо хэм хэмжээний актыг онцгойлон анхаарч, хуулиар зохицуулах харилцаа, журмаар зохицуулах харилцаагаа нарийвчлан тодорхойлох нь зүйтэй. Эс бөгөөс Ойн тухай хуулиас илүүтэй журмаар асуудлыг шийдвэрлэх, эсхүл хууль батлагдсаны дараагаар хэм хэмжээний актыг шинэчлэн батлах нэмэлт, өөрчлөлтийг оруулах жишиг үргэлжлэх эрсдэлтэй.

Дээрхээс нэгтгэн дүгнэвэл, Ойн тухай хуульд заасан хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт зорилгодоо хүрээгүй байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. Ойн тухай хууль дахь төрийн болон орон нутгийн байгууллагын бүрэн эрх, засаглалтай холбоотой зохицуулалт зорилгодоо нийцэж байгаа эсэх

Ойн тухай хуулийн 3 дугаар бүлэг буюу 11 дүгээр зүйлээс 19 дүгээр зүйл хүртэлх зохицуулалтаас үзвэл ойн салбарын хүрээнд Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл иргэдийн төлөөлөгчдийн хурлын болон засаг дарга, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын засаг дарга, баг, хорооны иргэдийн нийтийн хурал болон засаг дарга эрх эдэлж үүрэг хүлээж байна.

Тодруулбал, Ойн тухай хуулийн 11 дүгээр зүйлээр **Улсын Их Хурал 4 бүрэн эрх**, 12 дугаар зүйлээр **Засгийн газар 8 бүрэн эрх**, 13 дугаар зүйлээр **Байгаль орчны асуудал Төрийн захиргааны төв байгууллага 13 бүрэн эрх**, 14 дүгээр зүйлээр **Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага 25 бүрэн эрх**, 15 дугаар зүйлээр **Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын 3 бүрэн эрх**, 16 дугаар зүйлээр **Цагдаагийн байгууллагын 2 бүрэн эрх**, 17 дугаар зүйлээр **Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 6 бүрэн эрх**, **Аймаг, нийслэлийн Засаг даргын 21 бүрэн эрх, Байгаль орчны газрын 11 бүрэн эрх**, 18 дугаар зүйлээр **Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 бүрэн эрх**, **Сум дүүргийн засаг даргын 19 бүрэн эрх**, **Сум дундын болон сум, дүүргийн ойн ангийн 15 бүрэн эрх**, 19 дүгээр зүйлээр **Баг, хорооны иргэдийн Нийтийн хурлын 3 бүрэн эрх**, **Баг, хорооны Засаг даргын 6 бүрэн эрхийг** тус тус хуульчилсан.

График 3. ОтХ-д заасан бүрэн эрх, субъект тус бүрээр

Дээрх графикаас үзвэл, **ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага** нь бусад байгууллагатай харьцуулахад хамгийн их бүрэн эрхийг эдэлж байна. Энэ нь Ойн тухай хуулийн 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн нэмэлттэй холбоотой. Тус нэмэлтээр **"Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага"**-д ойг хамгаалах, нөхөн сэргээх, ашиглах талаар **25 бүрэн эрхийг шинээр олгосон** бөгөөд тус газар нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн статустай үйл ажиллагаагаа эрхэлж байна.[9]

Тус байгууллагыг байгуулах болсон шалтгаан нь ойн салбарын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулахад чиглэсэн бөгөөд ойн агентлагийг бий болгосноор ойн засаглалд тулгамдаж буй асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүй юм. Судлаачдын хувьд ойн агентлагийг бэхжүүлэхэд тодорхой хугацаа шаардлагатай[10] гэж үздэг.

[9] Монгол Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолын хавсралт, Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч, https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141010887611&showType=1

[10] Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр, Боть 2, Салбарын шинэчлэлийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, Төгсгөлийн тайлан, 43 дахь тал,

2023 оны 4 дүгээр сард хийсэн судалгаагаар ойн засаглалд тулгамдаж буй асуудлыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд;

- ***Орон нутаг дахь ойн засаглалын үйл ажиллагаа дахь улс төрийн нөлөөллийг бууруулах;***

Ойн тухай хуульд 2022 онд Ойн агентлаг байгуулах тухай нэмэлт, өөрчлөлт орсон ч орон нутагт Засаг дарга, ИТХ-ийн дарга нарт маш их үүрэг хариуцлага, эрх хэвээр үлдэж байгаа нь ойн салбарын хөгжилд саад болж байна. Тухайлбал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал ойн менежментийн төсөв, санхүүгийн хяналт биш харин ойн нөөц ашиглалтын үндсэн төлөвлөгөөг батлахад илүү анхаарах ёстой. Илүү нарийвчилсан сумдын ойн менежментийн төлөвлөгөөг Ойн агентлагаар батлуулж, бүх хариуцлагыг нь Ойн анги хариуцах ёстой. Ойн менежментийн төлөвлөгөө батлагдсаны дараа тухайн суманд өөр ойн аж ахуйн арга хэмжээ санал болгох шаардлагагүй болно (ОтХ-ийн 17.2.2 ба 17.2.7-г үзнэ үү). Тухайн сумын Засаг дарга, ИТХ нь нэгэнт батлагдсан ойн арга хэмжээний хэрэгжилтэд байнгын хөндлөнгөөс оролцох шаардлагагүй (ОтХ-ийн 18.2.2-ыг үзнэ үү), харин менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд мэргэжлийн түвшинд оролцох ёстой талуудын оролцоог бүрэн хангаж ажиллах талуудын оролцоог бүрэн хангасан Ойн менежментийн зөвлөл байгуулах шаардлагатай.[11]

- ***Ойн салбарын хүний нөөцийг сайжруулах***

Ойн аж ахуй нь урт хугацааны ажил бөгөөд урт хугацааны сэтгэлгээ, үйл ажиллагаа шаарддаг тул албан хаагчдын залгамж чанар нь хуулийн хэрэгжилтийг хангуулахад чухал асуудлын нэг юм. Бидний судалгаанаас харахад, ойн салбарын ажилтнуудыг ажлаас халах, солих хамгийн том шалтгаануудын нэг нь сонгуулийн дараах богино хугацааны улс төрийн өөрчлөлтүүд, цалин ба санхүүжилт, ажил мэргэжлийн онцлогтой холбоотой байна.[12]

- ***Ойн нөхөрлөлд бодит эрх мэдэл олгох***

Одоогийн байдлаар ойн нөхөрлөлүүд гэрээгээр хариуцсан ойн сандаа нөөцийг ашиглах талаар эрхгүй, хамгааллын үүрэг хүлээсэн байдалтай байна. Үүнийг өөрчлөх шаардлагатай. Нөхөрлөл нь, ойн менежментийг хэрэгжүүлэх, түүний дотор ойг сийрэгжүүлэх, мод огтлох үйл ажиллагаа явуулах боломжоор хангах, эсвэл энэ нь зөвхөн мэргэжлийн байгууллагад хамаарах хэвээр байгаа тохиолдолд хэрхэн урамшуулах талаар тодорхой болгох ёстой. Тиймээс ойн нөхөрлөлийн менежментийн хэрэгжилтийн хамрах хүрээ нь ойн мэргэжлийн байгууллагаас ялгаатай байх нь зөв. Гэсэн хэдий ч мод бэлтгэл явуулах сонирхолтой зарим нөхөрлөл мэргэжлийн байгууллагатай зэрэгцэн ашиглалт явуулах эрх авч үйл ажиллагаа явуулахыг зорьдог. Энэ нь улсын хэмжээнд байгаа ойн нөхөрлөлүүдийн чадамж, өнөөгийн байдал, хүчин чадлын ялгааг нэмэгдүүлээд зогсохгүй Ойн ангийн зүгээс (хууль болон хүний нөөцийн хувьд) бодитой хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах боломж хязгаарлагдмал байна.[13]

- ***Олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, хандлагыг сайжруулах***

Хуулийн хэрэгжилт нь дагаж мөрдөж буй иргэдийн ойлголт, чадавх, хандлагаас ихээхэн хамааралтай байдаг. Тиймээс бага наснаас нь (жишээлбэл, сургууль) чадавхыг хөгжүүлэх, олон нийтийн

---

[11] Мөн тэнд 43-44 дэх тал.
[12] Мөн тэнд, 44 дэх тал.
[13] Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр, Боть 2, Салбарын шинэчлэлийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, Төгсгөлийн тайлан, 45 дахь тал.

мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ нь бодлого, хууль тогтоомжид тусгасан зарчмуудыг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой юм.[14]

Судалгааны багийн зүгээс дээрх асуудлын хүрээнд Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Төв аймагт фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулсан. Энэхүү фокус бүлгийн ярилцлагад үр дүнгээс үзвэл:

- Аймаг, сумын ИТХ-ын шийдвэр гаргах процесс дээр мэргэжлийн хүмүүсийн тайлбар, тайлан мэдээтэй танилцаж дүгнэлт хийдэггүй.
- Сумын ИТХ мод хуваарилах процесс дээр мэргэжлийн бус ханддаг.
- Ойн мэргэжлийн мэргэшсэн зөвлөх ИТХ мэдээлэл өгмөөр байна.
- ИТХ хамгийн хүндрэлтэй үйл ажиллагаа явуулдаг.
- Модны зөвшөөрөл олгож байгаа шат дараалал /Ойн агентлагтай болсон зөв бүтэц бүрдсэн. Ойн төрийн өмч, тийм учраас ойд явуулах ажлыг Ойн газар л өөрөө хариуцмаар байна. Тогтолцооны асуудал гэж харагддаг.
- Шийдвэр гаргалт судалгаа шинжилгээнд үндэслэдэггүй.[15]
- Аймаг, сумын ИТХ нь шийдвэр гаргана. Салбарын мэргэжлийн бус хүмүүс хамгаалах бодлогыг мэргэжлийн түвшинд харж чаддаггүй.
- Аймаг, сумын ИТХ гишүүдэд мэргэжлийн сургалт оруулах зүйтэй санагддаг.[16]
- Салбарын бүтэц орон тооны асуудлыг тодорхой болгоогүйн улмаар ажлын үр дүн буурдаг.
- Аймгийн ИТХ-аас баталсан мод огтлох хэмжээг сумын ИТХ бууруулдаг.
- Хүний нөөцийн асуудлаас болоод хулгайн мод дээр хүрэлцээтэй ажиллах боломж байдаггүй.
- УИХ-ын гишүүд, аймаг, сумын ИТХ улс төрийн шинжтэй шийдвэр гаргадаг.
- Сумын ИТХ модны хуваарийн хязгаар дээр мэргэжлийн бус байдлаар хандсанаас болж нөлөөлөл ордог.[17]
- Ойн ангийн үйл ажиллагааны чиглэл эрх, үүрэг хуульд тодорхой байдаггүй.
- Сумын ИТХ-аас аймгаас батлагдсан хуваарийг нарийвчлан батлаагүй тохиолдол гарсан.
- Сум ИТХ модны хуваарийг тэнцүү хуваадаг.
- ИТХ тогтоол гарахад аж ахуйн нэгжийн ажиллах нөхцөлийг бодолцохгүй байдаг, үүнээс хамааралтай мод бэлтгэл хийгддэг.
- ИТХ оруулсан саналыг үндэслэн баталдаг. Холбогдох хороо нэгжээр гүйцэтгэлээ баталгаажуулж саналаа гаргадаг.
- Орон нутгийн ойн салбарын ажилтнуудын ажлын уялдаа холбоо сул байдаг.[18]
- Ойн ангиуд нь ижил ажил үүргийн хуваарьтай мөртлөө цалингийн харилцан адилгүй шатлалын хэмжээ байдаг.
- Хүний нөөцийн асуудал, ойн тухай ойлголттой хүн байдаггүй[19] гэх мэт асуудлыг ярилцлагын явцад хөндөж байсан болно.

[14]Мөн тэнд, 43-46 дахь талыг үзнэ үү.
[15] Сэлэнгэ аймагт 2025.08.29-ны өдөр зохион байгуулсан фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс.
[16]Сэлэнгэ аймгийн Мандал суманд 2025.08.30-ны өдөр зохион байгуулсан фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс.
[17] Хөвсгөл аймагт 2025.09.05-ны өдөр зохион байгуулсан фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс
[18] Булган аймагт 2025.09.04-ний өдөр зохион байгуулсан фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс.
[19] Төв аймагт 2025.09.10-ны өдөр зохион байгуулсан фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс.

Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Төв аймагт фокус бүлгийн ярилцлагаас ойн засаглалтай холбоотой асуудлыг нарийвчлан судалбал өмнөх судалгааны дүгнэлттэй төстэй үр дүн ажиглагдсан бөгөөд ойн засаглалд тулгамдаж буй асуудлыг **нэгдүгээрт**, ойн салбарын өөрийгөө санхүүжүүлэх боломж хязгаарлагдмал, **хоёрдугаарт,** орон нутаг дахь ойн салбарт ИТХ-ын оролцоо, улс төрийн нөлөө их, байгууллагын уялдаа холбоо хангалтгүй, **гуравдугаарт,** хүний нөөцийн хомсдолоос үүссэн асуудал хэмээн ангилж болохоор байна.

Судалгааны багийн зүгээс орон нутагт дахь ойн салбарт ИТХ-ын оролцоог тухайлан судлах явцад сумын ИТХ нь Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т заасан бүрэн эрхээ ойлгомжгүй байдлаар хэрэгжүүлж байна гэж үзсэн болно. Учир нь Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т *"Хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу тухайн жилд ашиглах ойн нөөцийн хэмжээг тогтоох"* бүрэн эрхийг сумын ИТХ-д олгосон. Үүнийг схемээр зураглан үзүүлбэл:

Зураг 4. Ойгоос жилд бэлтгэх модны дээд хязгаарыг тогтоох үе шат



Энэхүү зураглалаас үзвэл, ойгоос жилд бэлтгэх модны дээд хэмжээг Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу БОУАӨЯ засаг даргын санал, ойн зохион байгуулалтын баримт бичиг, ойн менежментийн төлөвлөгөөнд нийцүүлэх, Ойн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д заасны дагуу аймаг, нийслэл тус бүрээр баталж байна. Тухайлбал, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн А/581 тушаалаар "Ойгоос 2026 онд бэлтгэх модны дээд хязгаар"-ыг баталсан байна.[20]

Аймгийн ИТХ-ын хувьд дээд шатны байгууллагаас баталсан энэхүү хязгаарт багтаан Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4-т заасны дагуу сумдаар батална.

Доорх зурагт 2022 оны 12 дугаар сард Булган аймгийн ИТХ-аас 2023 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг баталсан бөгөөд энэхүү тогтоол нь 3 хавсралттай. Энэхүү гуравдугаар хавсралтаар тусгай хамгаалалттай газар нутаг болох Зэд Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газраас мод бэлтгэхээр заасан боловч үүний эрх зүйн үндэслэл нь тодорхойгүй байна.

Зураг 5. Булган аймгийн ИТХ-ын ээлжит XII хурлын тогтоолын гуравдугаар хавсралт, Тусгай хамгаалалттай газрын ойн сангаас 2023 онд бэлтгэх модны хэмжээ, ойжуулалт хийх талбайн

[20] https://mecc.gov.mn/storage/media/0851df5b-fe51-4a40-9ded-107769ad7d08.pdf

хэмжээ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны XII хуралдааны 10 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

Тусгай хамгаалалттай газрын ойн сангаас 2023 онд бэлтгэх модны хэмжээ, ойжуулалт хийх талбайн хэмжээ

Тусгай хамгаалалтай газар нутгийн нэр	Сумын нэр	Модны төрөл	Огтлолтын төрөл		Нийт бэлтгэх модны хэмжээ /м3/	Орлого /мян.төг/	Ойжуулалт хийх талбайн хэмжээ /га/	Мод бэлтгэх талбайн хэмжээ /га/
			Цэвэрлэгээний огтлолт	Цэвэрлэгээний ажил				
Зэд Хантай-Бүтээлийн нурууны ДЦГ	Тэшиг	Шинэс		150	150	888.00	0	10
		Хуш		40	40	236.80	0	5
	Сэлэнгэ	Шинэс	100	200	300	4,930.10	2	23
	Хутаг-Өндөр	Шинэс	100	150	250	4,634.10	2	17
	Дүн		200	540	**740**	**10,689.00**	**4**	**55**

Ийнхүү аймгийн ИТХ-аас баталсан хязгаар үндэслэж Сумын ИТХ-ын Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, 32 дугаар зүйлийн 32.3-т заасны дагуу ойгоос бэлтгэх, хэмжээ хязгаарыг баталдаг.

Зураг 6. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны тогтоол, 2023.12.18, Дугаар 03 тогтоолын нэгдүгээр хавсралт, Ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллагуудын ойгоос бэлтгэх модны дээд хязгаар

Цагаан-Уул сумын Иргэдийн төлөөлөгчдийн
хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны
өдрийн ээлжит XIV хуралдааны 03 дугаар
тогтоолын 1дүгээр хавсралт

ОЙН НӨХӨРЛӨЛ, МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ОЙГООС БЭЛТГЭХ МОДНЫ ДЭЭД ХЯЗГААР

д/д	ААНБ, ОН БАГИЙН НЭР	ЦАГААН-УУЛ СУМАНД БЭЛТГЭХ МОДНЫ ДЭЭД ХЭМЖЭЭ																	
		Үйлдвэрлэлтийн огтлолт м3			Арчилгааны огтлолт м3			Цэвэрлэгээний огтлолт м3			Цэвэрлэгээний ажил м3			Уламжлалт бүтээгдэхүүн м3			нийт дун м3		
		хэрэглэх	түлэх	дүн	хэрэглэх	түлэх	дүн	хэрэглэх	түлэх	дүн	хэрэглэх	түлэх	дүн	хэрэглэх	түлэх	дүн	хэрэглэх	түлэх	дүн
	Аймгийн хурлаас батласан хэмжээ	0	0	0	200	40	240	200	200	400	250	8500	8750	0	0	0	650	8740	9390
1	Булнай Хайрхан ХХК																		
2	Дээд Цахиурт ХХК				100	40	140	100	100	200							200	140	340
3	Агар баг										42	1400	1442				42	1400	1442
4	Өвгөд баг										42	1400	1442				42	1400	1442
5	Тосон баг										45	1425	1470				45	1425	1470
6	Хужирт баг										42	1425	1467				42	1425	1467
7	Шарга баг										42	1425	1467				42	1425	1467
8	Жаргалант баг										37	1425	1462				37	1425	1462
	нийт дун				100	40	140	100	100	200	250	8500	8750	0	0	0	650	8500	9390

Дээрх зурагт байгаа ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллагуудын ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг тогтоосон хавсралтыг шинжлэн үзвэл **Нэгдүгээрт,** Арчилгааны огтлолт, цэвэрлэгээний огтлолтын хуваарийг 2 компаниас зөвхөн нэг компанид 50 хувиар өгсөн бөгөөд ямар үндэслэлээр нэг компанийг сонгосон, яагаад дээд хязгаарыг 50 хувиар олгосон талаарх үндэслэл тодорхойгүй.

Хоёрдугаарт, аймгаас батлагдсан дээд хязгаарыг хэрэглээн дээр 650 байсныг 31 хувь багасган 450 болгож, түлээн дээр 8,740 байсныг 2 хувь бууруулан 8,500 болгон баталсан.

Зураг 7. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны тогтоол, 2023.12.18, Дугаар 03 тогтоолын нэгдүгээр хавсралт, Ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллагуудын ойгоос бэлтгэх модны дээд хязгаарт хийсэн шинжилгээ

Цагаан-Уул сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит XIV хуралдааны 03 дугаар тогтоолын 1дүгээр хавсралт

ОЙН НӨХӨРЛӨЛ, МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ОЙГООС БЭЛТГЭХ МОДНЫ ДЭЭД ХЯЗГААР

д/д	ААНБ, ОН БАГИЙН НЭР	ЦАГААН-УУЛ СУМАНД БЭЛТГЭХ МОДНЫ ДЭЭД ХЭМЖЭЭ																	
		Үйлдвэрлэлтийн огтлолт м3			Арчилгааны огтлолт м3			Цэвэрлэгээний огтлолт м3			Цэвэрлэгээний ажил м3			Уламжлалт бүтээгдэхүүн м3			нийт дүн м3		
		хэрэглээ	түлээ	дүн	хэрэглээ	түлээ	дүн	хэрэглээ	түлээ	дүн	хэрэглээ	түлээ	дүн	хэрэглээ	түлээ	дүн	хэрэглээ	түлээ	дүн
	Аймгийн хэмжээнд батлагдсан хэмжээ	0	0	0	200	40	240	200	200	400	250	8500	8750	0	0	0	650	8740	9390
1	Булнай Хайрхан ХХК																		
2	Дээд Цахиурт ХХК				100	40	140	100	100	200							200	140	340
3	Агар баг										42	1400	1442				42	1400	1442
4	Өвгөд баг										42	1400	1442				42	1400	1442
5	Тосон баг										45	1425	1470				45	1425	1470
6	Хужирт баг										42	1425	1467				42	1425	1467
7	Шарга баг										42	1425	1467				42	1425	1467
8	Жаргалант баг										37	1425	1462				37	1425	1462
	нийт дүн				100	40	140	100	100	200	250	8500	8750	0	0	0	650	8500	9390

Арчилгааны огтлолт, цэвэрлэгээний огтлолтын хуваарийг 2 компаниас зөвхөн 1-т нь өгсөн.

Аймгаас батлагдсан лимитийг хэрэглээн дээр 31%, түлээн дээр 2% бууруулж баталсан.

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны тогтоол, 2023.12.18, Дугаар 03 тогтоолын хоёрдугаар хавсралтаар "Цагаан-Уул сумаас Мөрөн сум руу бэлтгэх модны хэмжээ"-г заасан байна.

Зураг 8. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны тогтоол, 2023.12.18, Дугаар 03 тогтоолын хоёрдугаар хавсралт "Цагаан-Уул сумаас Мөрөн сум руу бэлтгэх модны хэмжээ"

Цагаан-Уул сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит XIV хуралдааны 03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ОЙН НӨХӨРЛӨЛ, МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ОЙГООС БЭЛТГЭХ МОДНЫ ДЭЭД ХЯЗГААР

д/д	ААНБ. ОН БАГИЙН НЭР	ЦАГААН-УУЛ СУМААС МӨРӨН СУМ РУУ БЭЛТГЭХ МОДНЫ ХЭМЖЭЭ														
		Үйлдвэрлэлтийн огтлолт м3			Арчилгааны огтлолт м3			Цэвэрлэгээний огтлолт м3			Цэвэрлэгээний ажил м3			нийт дүн м3		
		хэрэглээ	түлээ	дүн	хэрэглээ	түлээ	дүн	хэрэглээ	түлээ	дүн	хэрэглээ	түлээ	дүн	хэрэглээ	түлээ	дүн
	АЙМГААС БАТЛАГДСАН ЛИМИТ	0	0	0	100	20	120	50	20	70	140	1500	1640	290	1540	1830
1	Булнай Хайрхан ХХК															
2	Дээд Цахиурт ХХК															
3	МӨРӨН СУМ	0	0	0	0	0	0	50	20	70	0	1200	1200	50	1220	1270
	нийт дүн							50	20	70		1200	1200	50	1220	1270

Энэ тогтоолд шинжилгээ хийж үзвэл, аймгаас батлагдсан хэрэглээний дээд хязгаарыг 83 хувиар буюу 290 байсныг 50 болгож 83 хувиар, түлээн дээр 1,540 байсныг 1,220 болгож 21 хувиар тус тус бууруулжээ.

Зураг 9. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны тогтоол, 2023.12.18, Дугаар 03 тогтоолын хоёрдугаар хавсралт, Цагаан-Уул сумаас Мөрөн сум руу бэлтгэх модны хэмжээ



Цагаан-Уул сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийнээлжит XIV хуралдааны 03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ОЙН НӨХӨРЛӨЛ, МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ОЙГООС БЭЛТГЭХ МОДНЫ ДЭЭД ХЯЗГААР

ЦАГААН-УУЛ СУМААС МӨРӨН СУМ РУУ БЭЛТГЭХ МОДНЫ ХЭМЖЭЭ

д/д	АЛНБ. ОН БАГИЙН НЭР	Үйлдвэрлэлтийн огтлолт м3			Арчилгааны огтлолт м3			Цэвэрлэгээний огтлолт м3			Цэвэрлэгээний ажил м3			нийт дүн м3		
		хэрэглээ	түлээ	дүн	хэрэглээ	түлээ	дүн	хэрэглээ	түлээ	дүн	хэрэглээ	түлээ	дүн	хэрэглээ	түлээ	дүн
	АЙМГААС БАТЛАГДСАН ЛИМИТ	0	0	0	100	20	120	50	20	70	140	1500	1640	290	1540	1830
1	Булнай Хайрхан ХХК															
2	Дээд Цахиурт ХХК															
3	МӨРӨН СУМ	0	0	0	0	0	0	50	20	70	0	1200	1200	50	1220	1270
	нийт дүн							50	20	70		1200	1200	50	1220	1270

Аймгаас батлагдсан лимитийг хэрэглээн дээр 83%, түлээн дээр 21% бууруулж баталсан.

Дээрхээс дүгнэн үзвэл, ойн салбарын засаглалд аймаг, сумын ИТХ-ын оролцоо сөргөөр нөлөөлж байна. Учир нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны тогтоосон хязгаарын хүрээнд Аймгийн ИТХ сум бүрээр баталдаг. Ийнхүү батлахдаа хавсралтаар хэд хэдэн баримт бичиг гаргадаг бөгөөд энэхүү баримт бичигт үндэслэлийг тодорхой дурдалгүйгээр дархан цаазат газраас мод бэлтгэх хуваарийг баталсан. Хэдийгээр энэ нь үндсэн асуудал биш боловч ямар хэрэгцээ, шаардлагад үндэслэж Аймгийн ИТХ-аас тусгай хамгаалалттай газар нутгаас мод олборлосон болох нь ойлгомжгүй байна.

Түүнчлэн, Аймгийн ИТХ-аас мод бэлтгэх хуваарийг баталсны дараагаар сумын ИТХ хуралдаж тухайн жилд ойгоос бэлтгэх хуваарийг дахин хэлэлцэн тогтоодог. Ийнхүү хэлэлцэн тогтоохдоо аймгаас тогтоосон хэмжээг үндэслэлгүй бууруулах, арчилгааны болон цэвэрлэгээний огтлолын хуваарийг 50 хувиар тогтоох, тодорхойгүй үндэслэлээр 2 компаниас зөвхөн нэг компанид олгож байна. Мөн аймгаас батлагдсан дээд хязгаарыг хэрэглээ болон түлээн дээр үндэслэлгүйгээр бууруулан батлах, аймгийн төвийн сум руу нийлүүлэх хуваарийг огцом багасгаж байна.

Энэ нь нэг талаар хуулиар олгогдсон бүрэн эрх боловч нөгөө талаас тухайн жил батлах хуваарийг эцсийн дүндээ сумын ИТХ тогтоох нөхцөлийг бүрдүүлж, ойн засаглалд оролцож буй бусад байгууллагуудын оролцоог хязгаарлаж байна.

Эл асуудлыг бусад судалгаагаар хөндсөн бөгөөд *"...Тухайн жилийн бэлтгэх модны дээд хязгаарыг тогтоох нь, тухайн сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх байгаа юм. Энэ заалтыг уг хуулиас хасах хэрэгтэй. Үүний оронд мэргэжлийн байгууллагууд нь, ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан олон жилийн төлөвлөлтийн хүрээнд төлөвлөгдсөн урт хугацааны төлөвлөлттэй байх шаардлагатай. Мөн аймгийн ИТХ-ын үүргийн талаарх ОтХ-ийн 17.1.4 дэх заалтад засвар хийх шаардлагатай..."* гэжээ.

Иймд Ойн тухай хуулиар аймаг болон сумын ИТХ-ын эдлэх бүрэн эрхийг багасгах, модны хуваарийг гаргахдаа сумын ИТХ-ын дээд шатны хязгаарт батлуулан эцэслэн шийдвэрлэдэг байдалд хязгаар тогтоох буюу дээд шатнаас баталсан хуваарийг өөрчлөн батлах эрхийг хязгаарлах, эсхүл бусад судалгаанд дурдсаны дагуу тухайн жилийн бэлтгэх модны дээд хязгаарыг эцэслэн тогтоож буй сумын ИТХ-ын бүрэн эрхийг хүчингүй болгох зүйтэй.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4. Ойн тухай хуульд заасан ойн мэдээллийн сантай холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх.

Монгол Улсын ойн сан нь Байгаль-Сибирийн их тайга, Төв Азийн хээр цөлийн торгон заагт, уур амьсгалын эрс тэс нөхцөлд ургадаг, байгалийн жамаар нөхөн сэргэх чадвараар нэн хязгаарлагдмал, түймэр, хөнөөлт шавж болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд хялбархан өртөмтгий, шилмүүст, навчит ой болон нутгийн өмнө талын говь цөлийн бүсээр тархан ургадаг заган ойгоос бүрддэг, генетикийн олон янз байдлыг хадгалсан өвөрмөц экосистем юм.

Манай улсын хувьд Ойн тухай хуулиар ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмших, ашиглах, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой харилцааг зохицуулдаг.

Ойн тухай хуулийн 6 дугаар зүйлд ойн мэдээллийн сангийн тогтолцоо журмын талаар хуульчилсан. Тус зүйлийн 6.1-д *"Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ойн төлөв байдал, ойн сангийн эзлэх талбайн хэмжээ, нөөц, бүрэлдэхүүн, үнэлгээ, тэдгээрийн өөрчлөлт, ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний талаарх цогц мэдээллийг агуулсан улсын хэмжээний ойн мэдээллийн сантай байна"* гэж заасан.

Байгаль орчны нэгдсэн мэдээллийн сан нь https://eic.mn/ бөгөөд тус цахим сангийн "Мэдээллийн сан" хэсгийг сонгоход "ой" гэсэн хэсэг гарч ирэх бөгөөд ой дотор дараах мэдээллийн санг үүсгэсэн байна. Үүнд:

- Ойн нөөцийн мэдээллийн сан;
- Ой зохион байгуулалтын мэдээллийн сан;
- Ойн нөхөн сэргээлтийн мэдээллийн сан;
- Ой, хээрийн гал түймрийн мэдээллийн сан;
- Ойн хөнөөлт шавж, өвчний мэдээллийн сан.

Түүнчлэн, Ойн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т "Энэ хуулийн 6.1-д заасан мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" гэж заасан бөгөөд тус зохицуулалтын дагуу Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн А/53 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар "Ойн мэдээллийн сангийн бүртгэл тайлангийн маягт тэдгээрийн хөтлөх журам"-ыг баталсан байна. Гэвч тус журмын дагуу ойн мэдээллийн санг тогтмол хөтлөхгүй байна гэж үзэж болох юм.

Учир нь ойн мэдээллийн сан нь цахимаар хүн бүр тухайн сайтад хандан ойтой холбоотой бүх төрлийн мэдээллийг нэг дороос авах боломжтой байхаар хуульд тусгагдсан боловч сүүлийн жилийн мэдээллүүдийг шинэчлэн байршуулаагүй байна. Тухайлбал, ойн зохион байгуулалтын мэдээ хэсэгт ороход 2020 оноос хойш мэдээллийг оруулаагүй байна. Мөн ой, хээрийн галт түймрийн мэдээллийн сан руу ороход 2020-2023 онд гарсан гал түймрийн мэдээллийн огт байхгүй, 2024 онд 1 гэсэн тоон үзүүлэлтийг оруулсан байна.

Энэхүү мэдээллийн сангийн мэдээ, мэдээллийг тогтмол шинэчилж, статистик мэдээ, судалгаа, тайланг тухай бүрд нь оруулахгүй байгаа нь цахим сангийн ач холбогдлыг алдагдуулж байна.

Түүнчлэн, ойн мэдээллийн санг цахимаар бус ихэвчлэн цаасан хэлбэрээр тогтмол биш байдлаар хөтөлж байна. Цахим мэдээллийн сангийн платформ нь учир дутагдал ихтэй. Тухайлбал, улсын болон аймаг/сумын төлөвлөгөөнүүдийн нэршил, байршлын зөрүү зэргээс тухайн санд орсон өгөгдлийн бодит, үнэн зөв эсэхэд эргэлзэх үндэслэл болж байна.

Иймээс ч Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.9-д заасны дагуу төрийн захиргааны төв байгууллага улсын ойн мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хэрэгжилтэд хяналт тавих; тус хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т заасны дагуу ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ойн мэдээллийн нэгдсэн сан хөтлөх, бүрдүүлэх, баяжуулах, мэдээллээр хангах, мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т заасны дагуу аймаг, нийслэлийн Байгаль орчны газар нь аймаг, нийслэлийн ойн мэдээллийн санг бүрдүүлж, төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангах, тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.9-д заасны дагуу сум дундын болон сум, дүүргийн ойн анги нь мэдээллийн санг эрхлэх бүрэн эрхтэй байхаар хуульчилсан дээрх зохицуулалтууд зорилгодоо бүрэн хүрч чадахгүй гэж үзэж болох юм.

Дээрх зохицуулалтууд зорилгодоо хүрч, практикт бодитойгоор хэрэгжиж байсан бол ойн мэдээллийн сангаас тус хуульд заасны дагуу ойтой холбоотой цогц мэдээллийг авах боломжтой байсан гэж үзэж байна. Иймд ойн мэдээллийн сантай холбоотой Ойн тухай хуульд тусгагдсан зохицуулалтууд зорилгодоо бүрэн хүрч чадаагүй гэж дүгнэлээ. Энэ нь тус мэдээллийн сангийн үйл ажиллагаа тогтмол шинэчлэгдэхгүй байгаатай холбоотой.

3.2.“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Ойн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан ойн нөхөрлөлийн үйл ажиллагаа, зохион байгуулалттай холбоотой зохицуулалт нь практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тухайн зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл байгаа эсэх.

Монгол Улсад байгалийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд нутгийн иргэдийг татан оролцуулах, хамтын менежментийн арга хэлбэрийг нэвтрүүлэх зохион байгуулалтын нэг хэлбэр нь иргэдийн нөхөрлөл юм. Ойн нөхөрлөлийн хувьд энэхүү зорилгыг нэгэн адил хэрэгжүүлж, ойн нөөцийн тогтвортой менежмент, ашиглалтыг хангах, дороитсон ойг нөхөн сэргээх, байгалийн сэргэн ургалтад туслах ажилд чухал үүрэг гүйцэтгэдэг субъект.

Ойн нөхөрлөлийн үйл ажиллагаа зохион байгуулалтад дараах давуу талууд бий болж байна. Үүнд:

- **Орон нутгийн иргэдийн эзэмшил ба хяналт:** Ой модтой шууд холбоотой орон нутгийн иргэдээс бүрддэг. Нөхөрлөлийн гишүүд байгалийн нөхөн сэргэлт, ойжуулалтыг дэмжиж, тогтвортой ашиглалт, менежментийг хэрэгжүүлэх талаар сонирхол нэгтэй байдаг.
- **Хамтын шийдвэр гаргалт:** Ойг хэрхэн ашиглах, хэрхэн удирдах талаар ойн нөхөрлөлийн гишүүд хамтдаа шийдвэр гаргадаг. Энэ нь нөөц баялгийг хэрхэн ашиглах талаар хүн бүр санал бодлоо илэрхийлэх, нутгийн иргэд нийтлэг зорилгодоо хүрэхийн тулд хамтран ажиллах боломжийг олгодог.

- **Ойн тогтвортой менежмент:** Ойн тогтвортой менежментийн практикт ойн нөхөрлөлүүд хэрэгжүүлэх боломж бүрддэг. Энэ нь ойн экосистемийг хамгаалж, бүтээмжийг хадгалж, хойч үедээ үлдээх боломжийг бүрдүүлдэг.
- **Нөхөрлөлийн хөгжил:** МБХ нь зөвхөн ойг удирдаад зогсохгүй гишүүдийнхээ нийгэм, эдийн засгийн сайн сайхан байдал, бэлчээрийн менежментийг сайжруулах чиглэлээр ажилладаг. Үүнд, ойн бүтээгдэхүүний шинэ зах зээлийг хөгжүүлэх, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах эсвэл олон нийтийн хөгжлийн бусад санаачилга багтаж болно.
- **Эрх ашгийн хамгаалал ба төлөөлөл:** Ойн нөхөрлөлийн гишүүд нь ихэвчлэн өөрсдийн ашиг сонирхлыг бусад төрийн байгууллага, ТББ, хувийн компаниуд зэрэг гадны оролцогч талуудаас хамгаалах, малчдынхаа эрх ашгийг хамгаалах зорилгоор ажилладаг.[21]

Харин тухайн зохицуулалтын хүндрэл, бэрхшээлтэй асуудлуудын тухайд дараах агуулгыг судалж үзлээ.

График 4. СДОА-ийн хариуцаж буй ойн сан, ОН болон ОМБ-ын эзэмшиж буй талбай[22]



Ойн нөхөрлөлүүд нь хуульд заасны дагуу ойн сангийн тодорхой хэсгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх ойн менежментийн төлөвлөгөөтэй байгаа эсэх:

Ойн нөхөрлөл нь ойн сангийн тодорхой хэсгийг сум, дүүргийн ИТХ-аас гарсан шийдвэрийн дагуу Засаг даргатай гэрээ байгуулж эзэмшинэ. Нөхөрлөл нь тухайн газар нутагт амьдарч байгалийн баялгаа зүй зохистой ашиглаж, хамгаалж ирсэн нутгийн иргэд нөхөрлөл болон зохион байгуулалтад орсноор ойн цэвэрлэгээ, ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах, ойн түймэр, хортноос урьдчилан сэргийлэх, гол горхи, булаг шанд, нуур цөөрмийн усны ундаргыг хамгаалах, хөв, цөв байгуулах, аргаль хонь, янгир ямаа, соргог бөхөн, цоохор ирвэс, халиун буга, хар сүүлтэй зээр, тарвага зэрэг нэн ховор, ховордсон амьтдын тоо толгой нэмэгдэх, хууль бус ан агналтыг таслан зогсоох, биотехникийн арга хэмжээ авах, байгалийн ургамлыг тарьж ургуулах, бэлчээрийн зохистой ашиглах зэрэг өргөн цар хүрээтэй ажлыг гүйцэтгэдэг. Эзэмшлийн газартаа ойн менежментийн төлөвлөгөөний дагуу тасралтгүй үйл ажиллагаа явуулах, хуульд заасан журмын дагуу ойн нөөц, дагалт баялгийг ашиглах, худалдан борлуулах зэрэг үйл ажиллагааг явуулна. Товч дүгнэвэл, ойн нөхөрлөл нь байгаль

[21] ТТ-9899 МОН: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр тэрбум мод хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд ойн нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэх заавар, 2023, 4 дэх тал.
[22] ТА-9899 MON: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр (сум дундын) ойн ангийн үнэлгээ тайлангийн төсөл, 2022 оны 4 сарын 30-ны байдлаар, 44 дэх тал.

орчны тухай хууль тогтоомжид заасны дагуу байгуулагдсан бусад нөхөрлөлийн адилаар зөвхөн байгалийн тодорхой баялгийг "хариуцан хамгаалах" зорилгоор ашиглаж эзэмшдэг өвөрмөц субъект бөгөөд хуулийн этгээдийн эрхгүй юм.

Дээрх онцлог зохицуулалтаас үзвэл ойн нөхөрлөлийн эрх, үүрэг, зохион байгуулалт, сум орон нутаг болон төрөөс үзүүлэх дэмжлэг, хамтын ажиллагааны суурь зохицуулалтыг дахин авч үзэх шаардлага үүсгэж байгаа юм. Ойн тухай хуулийн дээрх заалтад зааснаар ойн нөхөрлөл нь ойн сангийн тодорхой хэсгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх ойн менежментийн төлөвлөгөөтэй байх бөгөөд хуулиар тодорхойлж өгсөн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх суурь нь энэхүү төлөвлөгөө юм.

Ойн ангийн чадавхын үнэлгээний тайланд дурдсанаар Монгол Улсын хэмжээнд ойролцоогоор 1,267 ойн нөхөрлөл үйл ажиллагаа явуулж байна.[23] Үүнд зөвхөн Ойн тухай хуульд заасан шалгуур, шаардлагыг бүрэн хангасан ойн нөхөрлөлүүдээс гадна гэрээний хугацаа, гэрчилгээ нь дуусан нь ч мөн багтсан. Эдгээр нөхөрлөл дунджаар 20 гишүүнтэй бөгөөд нийт 4,143 га ойн сангийн талбайг гэрээгээр эзэмшиж байна. Дээр дурдсан судалгааны хүрээнд нийт 107 нөхөрлөлөөс нэг бүрчлэн чадавхын үнэлгээ авч судалсан.

Дээрхээс нөхөрлөлийн 86 хувь нь ойн менежментийн төлөвлөгөөтэй байх бөгөөд үүний 92 хувь нь сумын ИТХ-аар батлуулжээ. Эдгээрээс ойн менежментийн төлөвлөгөөг ойн мэргэжлийн байгууллагаар 58, ойн ангиар 31 нь хийлгэсэн бол бусад нь өөр байгууллагаар хийлгэсэн бөгөөд ийнхүү мэргэжлийн байгууллагаар хийлгэх нь төсөв санхүүгийн хувьд зардалтайгаас гадна өөрсдийн үйл ажиллагаанд нь төдийлөн хэрэг болдоггүй, газар дээр нь ирж боловсруулалт хийдэггүй, бусдын төлөвлөгөөг хуулсан байхаас гадна ойн нөхөрлөлүүд мод бэлтгэх эрхгүй байхад бодит байдал дээр огт хэрэгжихээргүй ой зохион байгуулалтын тайлангаас хуулсан тоонууд гаргасан байдаг аж.[24]

Ойн нөхөрлөл бол ойг хариуцан хамгаалах зорилготой, мэргэжлийн бус буюу иргэд, олон нийтийн төлөөллөөс бүрдсэн сайн дурын шинжтэй байгууллага юм. Гэтэл одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ОтХ-аар ойн менежментийн төлөвлөгөөтэй байхаар заасан нь тухайн хариуцаж буй ойн талбайд хэрэгжих мэргэжлийн шинжтэй үйл ажиллагааг ойн нөхөрлөлүүд хийх мэт давхардсан ойлголтыг бий болгожээ. Энэ үүднээс ойн менежментийн төлөвлөгөөг эргэн авч үзэж зөвхөн тухайн сумын ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бүх тал анхаарч ажиллах боломжийг бүрдүүлэхийг анхаарах нь зүйтэй.

ОтХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэгт заасны дагуу ойн нөхөрлөл нь сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ойн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагааныхаа хөтөлбөр, ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг жил бүр тавьдаг эсэх:

Ойн нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх талаарх ганцхан зохицуулалтыг ОтХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэгт заасан. Тус зохицуулалтад *"Ойн нөхөрлөл нь сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ойн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр явуулж*

[23] Финляндын Зөвлөх групп, Монголын Ойн судалгааны нийгэмлэг ТББ, TA-9899 MON: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр Ойн ангийн чадавхын үнэлгээний тайлан, 2023.
[24] Мөн тэнд.

байгаа үйл ажиллагааныхаа хөтөлбөр, ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг жил бүр тавина" гэж заажээ.

Засаг даргын хувьд зөвхөн хуулийн 21.11-д[25] заасан тохиолдолд тухайн ойн санд нөхөрлөлийн явуулах үйл ажиллагааг зогсоож, гэрээг цуцална. Иймд ойн нөөцийн тогтвортой менежмент, ашиглалтыг хангах, доройтсон ойг нөхөн сэргээх, байгалийн сэргэн ургалтад туслах ажилд чухал үүргээ ойн нөхөрлөл хэр зэрэг хэрэгжүүлж буйг үнэлж дүгнэх гол механизм нь энэхүү зохицуулалт учир нэг мөр хэрэгждэг байх учиртай.

Дээр дурдсан үнэлгээнээс үзвэл нийт судалгаанд хамрагдсан 107 ойн нөхөрлөлүүдийн 45 орчим хувь нь сумынхаа ИТХ-д ажлаа жил бүр тайлагнадаг, 23 хувь нь огт тайлагнадаггүй бол 8.4 хувьд хааяа, 12.15 хувь нь заримдаа, 11.2 хувь нь ихэнхдээ танилцуулдаг гэжээ. Эндээс товч дүгнэвэл ойн нөхөрлөлийн үйл ажиллагааг тогтмол буюу жил бүр үнэлж дүгнэх механизмыг хангалттай түвшинд хэрэгжүүлэх, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлага үүсэж байна.

Ойн нөхөрлөл нь гэрээний дагуу эзэмшиж байгаа ойн сангийн тодорхой хэсгийг ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн эсэх:

Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажил нь онцгой байдал, орон нутгийн захиргаа зэрэг олон талын оролцоотой хэрэгжинэ. Ойн нөхөрлөлийн хувьд гэрээгээр эзэмшиж буй ойн сангийн тодорхой хэсэгт түймрээс хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх бөгөөд эдгээр үйл ажиллагааг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ёстой. Үнэлгээ хийж үзвэл, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түймэр унтраах ажилд оролцдог уу гэсэн асуултад оролцогчдын 54 орчим хувь нь ойн түймрийн улиралд бүх гишүүд гал түймрийн эргүүл, хяналтад бүрэн оролцдог, эсвэл нөхөрлөл байгуулагдсанаас хойш ойн түймэр гараагүй гэж хариулсан байна. Түүнчлэн 30-аас дээш хувь нь ойн түймэр унтраахад бүх гишүүдийн 60-аас доошгүй хувь нь оролцож байсан гэж хариулсан. Мөн ихэнх ойн нөхөрлөлийн гишүүдийн 60-аас доошгүй хувь нь ойн түймэр унтраах гар багаж, техник хэрэгсэл бэлтгэсэн гэж хариулсан. Түүнээс гадна, үнэлгээнд оролцогчид ойн биологийн олон янз байдал нэмэгдсэн, ойн түймэр гарах, хууль бусаар мод бэлтгэх, хортон шавж тархах эрсдэл буурсан гэж хариулсан.

Нөгөө талаас ойн нөхөрлөлүүд зөвхөн ойн түймэр бус, хууль бус мод бэлтгэл, хортон шавжаас урьдчилан сэргийлэх, гарсан тохиолдолд шуурхай арга хэмжээ авах чиглэлээр идэвхтэй ажиллаж байгаа ч орон нутгийн засаг захиргааны зүгээс тэдэнд ямар ч урамшуулал байхгүй байгаа нь тэдний идэвх буурах үндсэн шалтгаан болж байна.

---

[25] 21.11.Дараах тохиолдолд тухайн сум, дүүргийн Засаг дарга ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшиж хамгаалах чиглэлээр явуулах ойн нөхөрлөлийн үйл ажиллагааг зогсоож, гэрээг цуцална:

21.11.1.ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшиж хамгаалах чиглэлээр явуулах үйл ажиллагааг зогсоох тухай баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын санал, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр гарсан;

21.11.2.ойн нөхөрлөлийн бүх гишүүдийн хурлаар ойн сангийн тодорхой хэсгийг эзэмших үйл ажиллагааг зогсоох шийдвэр гарсан;

21.11.3.энэ хуулийн 21.6, 21.7-д заасан нөхцөл, шаардлага болон энэ хуулийн 21.9-д заасны дагуу байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй, эсхүл гэрээ байгуулснаас хойш зургаан сарын хугацаанд ойг хамгаалах чиглэлийн үйл ажиллагаа явуулаагүй.

Дээрх хуулийн зохицуулалтын хувьд ой, хээрийн түймрээс хамгаалах ажлыг ойн нөхөрлөл өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэхээр заасан нь хэрэгжих боломжийг хязгаарлаж байна. Өмнө дурдсанаар ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх нь төрийн чиг үүргийн олон төрлийн байгууллага, албан тушаалтан, төрийн бус байгууллага, ойн нөхөрлөл, иргэдийн оролцоотой хэрэгждэг ажил юм. Тухайлбал, ОтХ-ийн 18 дугаар зүйлийн 18.2.10 - 18.2.14 дэх заалтад ой, хээрийн түймрээс сэргийлэх, хамгаалах талаар сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрхийг тусгаж өгсөн бөгөөд ойн нөхөрлөлд өөрийн хөрөнгөөр энэ ажлыг давхар гүйцэтгэх үүргийг хүлээлгэсэн нь эрх зүйн хэм хэмжээний давхардал үүсгэж байна.

Нөгөө талаас ойн нөхөрлөлийн хувьд зөвхөн ойн сангийн тодорхой хэсгийг гэрээний үндсэн дээр хариуцан хамгаалж буй иргэдийн сайн дурын нэгдэл тул эдгээр олон субъектийн өмнөөс хөрөнгө гаргаж ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах нь зохимжгүй. Түүнчлэн, хуулийн этгээдийн эрхгүй, сайн дурын нэгдлийн шинжтэй ойн нөхөрлөлүүдэд ой, хээрийн түймрээс хамгаалах чиглэлээр арга хэмжээ авах санхүүгийн болон мэргэшсэн байдлын чадавх бий эсэх нь эргэлзээтэй бөгөөд энэ талаар судалгааны дараах хэсгүүдэд авч үзнэ.

Ойн нөхөрлөл нь ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх, ойн менежментийн төлөвлөгөөний дагуу тасралтгүй үйл ажиллагаа явуулахуйц чадамжтай эсэх:

Ойн нөхөрлөлд ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх зэрэг олон талын үүргийг хууль тогтоомжоор хүлээлгэсэн боловч эдгээрийг хэрэгжүүлэх чадавх бүрдсэн эсэх, энэхүү чадавх бэхжихэд дэмжлэг болохуйц хууль тогтоомжийн зохицуулалт бий эсэх, тэдгээр нь үр нөлөөтэй хэрэгждэг эсэхийг тодруулах шаардлагатай.

Ойг нөхөн сэргээх, хамгаалах талаар ойн нөхөрлөлүүдийн хийж буй ажлын талаар судалсан дүнгээс үзэхэд нийт ойн нөхөрлөлүүдийн 25 орчим хувь нь байгалийн сэргэн ургалтад туслах ажил огт хийж байгаагүй, 62 хувь нь 0.1-ээс 5 хүртэлх га, харин 13 хувь нь 5 га-аас дээш талбайд байгалийн сэргэн ургалтад туслах ажил хийсэн байна. Ойн нөхөрлөлүүдийн байгалийн сэргэн ургалтад туслах гол ажил нь бэлчээрийн менежмент хийх бөгөөд зарим нөхөрлөл тодорхой газрыг хашиж малд идэгдэхээс хамгаалсан бөгөөд ойн нөхөрлөлүүдийн хийж чадах хамгийн амархан ажил бол малын бэлчээрлэлтээс өсвөр моддыг хамгаалах үйл ажиллагаа болох нь тодорхой харагдаж байна. Ойн нөхөрлөлүүдийн ойг хамгаалснаас хойш тэдний хариуцсан нутаг дэвсгэр дээрээ байгалийн сэргэн ургалт эрчимтэй явагдаж байгаа бөгөөд ойн сангийн сэргэн ургалт явагдах боломжтой газруудын 21-60 хувьд байгалийн сэргэн ургалт явагдаж байна гэж ихэнх нөхөрлөл хариулсан. Байгалийн сэргэн ургалтыг дэмжих нь ойн талбайг нэмэгдүүлэх хамгийн ашигтай, зардал багатай хувилбар байхаар байна.

Үнэлгээнд хамрагдсан ОН-үүдийн 59 орчим хувь нь мод үржүүлгийн газаргүй, зөвхөн 10 хувь нь 20,000-аас дээш тооны тарьц, суулгацтай гэж хариулсан байна. Мөн ойн нөхөрлөлүүдийн 36-аас дээш хувь нь ойжуулалт, нөхөн сэргээлт тал дээр огт туршлагагүй бол ОН-үүдийн 7.5 орчим хувь нь 4 га- аас дээш талбайд ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажил хийдэг байна. Үлдсэн ойн нөхөрлөлүүдийн хувьд 0.1 га-аас 4 га хүртэл ойжуулалт, нөхөн сэргээлт хийж байсан туршлагатай байна.

Ойн нөхөрлөлүүдийн санхүүгийн чадавхын байдлыг судалж үзэх нь зүйтэй. Санхүүгийн чадавхын хувьд ойн нөхөрлөлүүд сул байна. Өмнө дурдсанаар ойн нөхөрлөлүүд нь хуулийн этгээдэд тооцогддоггүй, гэрээний үндсэн дээр бий болсон иргэдийн хамтрал хэлбэртэй бөгөөд улсын

бүртгэлтэй татварын дугааргүй тул ашиг олох үйл ажиллагаа нь маш хязгаарлагдмал байна. Нөхөрлөлийн дундын сан, орлого бий болгох үйл ажиллагаа, ой хамгаалал, нөхөн сэргээлтэд гардаг зардлыг тодруулж үзвэл судалгаанд хамрагдсан ойн нөхөрлөлүүдийн 44 хувь нь дундын сангүй, 22.4 хувь нь 1 сая төгрөгөөс бага, 17 хувь нь 3.1-10 сая төгрөг, ердөө 3 хувь нь 10 сая төгрөгөөс дээш дундын сантай байна. Нөгөө талаас ОН-үүдийн 36 орчим хувь нь үндсэндээ орлогогүй, ердөө 7.5 хувь нь 10 сая төгрөгөөс дээш орлоготой байна. Санхүүгийн хувьд чадавх сул байгаа нь ойн тогтвортой менежментэд хувь нэмэр оруулж ойг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг хэрэгжүүлэх чадавхтай нь шууд холбогдох бөгөөд иймд ойн нөхөрлөлүүдийг санхүүгийн хувьд чадавхжуулахын тулд тодорхой урамшууллын механизм бий болгох аргыг хуульд тусгах шаардлагатай.

Нөгөө талаас сум орон нутгийн түвшинд ойн нөхөрлөлүүдийг дэмжих, хамтран ажиллаж байгаа эсэх нь тэдгээрийн үйл ажиллагаа амжилттай явагдахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Сум/сум дундын ойн ангиуд ой модтой холбоотой бүхий л үйл ажиллагаануудад ойн нөхөрлөлүүдэд хяналт тавьж, дэмжлэг үзүүлж ажилладаг. Үүнд ойн нөхөрлөлийг шинээр байгуулах, хариуцсан ойн сангийн зураглал хийх, ойн менежментийн төлөвлөгөө гаргах, чадавхжуулах сургалтууд зохион байгуулах зэрэг ордог.

Ойн ангиуд байгуулагдсан цагаас эхлэн ОН-үүдэд ойн цэвэрлэгээ, талбайн хилийн заагийг тогтоох, мод үржүүлгийн газарт мод тарих, байгалийн сэргэн ургалтыг дэмжих, ойн түймэр, хортон шавжийг хянах гэх мэт мэргэжил аргазүйн тал дээр нөхөрлөлүүдийг чадавхжуулснаар ой хамгааллын менежмент ихээхэн үр дүнтэй болсон байна. Түүнчлэн ОН-үүд ойн аж ахуйтай холбоотой сургалт, чадавхыг бэхжүүлэх арга хэмжээнд 70-аас дээш хувь нь хагас жил дотроо оролцдог гэсэн бөгөөд үүнд ойн ангитай хийдэг уулзалт, зөвлөгөө, хөгжлийн төсөл хөтөлбөрүүдийн чадавхжуулах сургалт, дэмжлэг, оролцооноос хамаарч байна.

Сумын засаг даргаас дэмжлэг авдаг талаар асуухад 46 хувь нь хэзээ ч дэмжлэг авч байгаагүй, зөвхөн 6 хувь нь маш сайн дэмжлэг авдаг гэж хариулсан. Мөн ялгаагүй сумын ИТХ-аас ойн нөхөрлөлүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэггүй нь харагдаж байна. Үндсэн хуулиар байгалийн баялаг төрийн нийтийн өмч байдаг тул өмчийн эзэн болох орон нутгийн удирдлагын зүгээс дэмжлэг үзүүлэхгүй тохиолдолд хэдийгээр олон нөхөрлөл байгуулагдсан боловч үйл ажиллагаа нь суларч, идэвхгүй болж байна.

Дээрх асуудлуудаас гадна ойн нөхөрлөлийн үйл ажиллагаа, зохион байгуулалттай холбоотой дараах асуудлууд үүсдэг байна.Үүнд:

Ойн нөхөрлөлүүдэд бодит эрх мэдэл олгох: Одоогийн байдлаар ойн нөхөрлөлүүд гэрээгээр хариуцсан ойн сандаа нөөцийг ашиглах талаар эрхгүй, хамгааллын үүрэг хүлээсэн байдалтай байна. Үүнийг өөрчлөх шаардлагатай. Нөхөрлөл нь, ойн менежментийг хэрэгжүүлэх, түүний дотор ойг сийрэгжүүлэх, мод огтлох үйл ажиллагаа явуулах боломжоор хангах, эсвэл энэ нь зөвхөн мэргэжлийн байгууллагад хамаарах хэвээр байгаа тохиолдолд хэрхэн урамшуулах талаар тодорхой болгох ёстой. Ойн нөхөрлөлийн тодорхойлолт нь, Иргэний хууль болон Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан ойлголтод нийцдэг. Тиймээс ойн нөхөрлөлийн менежментийн хэрэгжилтийн хамрах хүрээ нь ойн мэргэжлийн байгууллагаас ялгаатай байх нь зөв. Гэсэн хэдий ч мод бэлтгэл явуулах сонирхолтой зарим нөхөрлөл мэргэжлийн байгууллагатай зэрэгцэн ашиглалт явуулах эрх авч үйл ажиллагаа явуулахыг зорьдог.

Энэ нь улсын хэмжээнд байгаа ойн нөхөрлөлүүдийн чадамж, өнөөгийн байдал, хүчин чадлын ялгааг нэмэгдүүлээд зогсохгүй Ойн ангийн зүгээс (хууль болон хүний нөөцийн хувьд) бодитой хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах боломжгүй болгож байгаа юм. Жишээлбэл, нөхөрлөлүүдэд босоо хатсан (үхсэн) мод бэлтгэхийг зөвшөөрөх нь зүйтэй боловч Байгаль орчны тухай хуулийн дагуу байгуулагдаж буй нөхөрлөлүүдийн үндсэн үйл ажиллагаатай нийцэхгүй байгаа тул хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай болно. Нөгөө талаас хяналт хангалтгүй байх нь, ойн нөөцийг хэтрүүлэн ашиглах байдалд хүргэж болзошгүй юм. Мөн ойн нөхөрлөлийн гишүүд хүссэн үедээ ТББ, мэргэжлийн байгууллага байгуулж, статус, удирдлагын эрхээ сайжруулах бүрэн боломжтой.

Ойн нөхөрлөлүүдийг бэхжүүлэх нэг арга бол ойн дагалт баялаг ашиглах төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх эсвэл ойн сангаа амжилттай хамгаалсны төлөө нөхөрлөлийн дундын санд мөнгө төлөх гэх мэт менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлд суурилсан урамшуулал олгох явдал юм. Тухайн мөнгө байгалийн нөөц ашигласны төлбөр болон бусад салбараас (жишээлбэл, уул уурхай) орж ирж болох бөгөөд ой нь экосистемийн олон үүргийг гүйцэтгэдэг, байгалийн нөөц ашигласны орлогыг бүрдүүлдэг томоохон үүрэг бүхий экосистем юм.

Тарьсан мод, ойжуулалт, байгалийн сэргэн ургалтыг хамгаалах: Энэ нь тэрбум мод ургуулах санаачилгын хүрээнд чухал ач холбогдолтой үйл ажиллагааны нэг юм. Тэрбум мод ургуулах ажлыг орон даяар өрнүүлж байгаа ч бодлого нь зөвхөн мод тарихад гол анхаарлаа хандуулж болохгүй, тарьсан талбайг хамгаалах, доройтсон ойг нөхөн сэргээхэд чиглэгдсэн байх ёстой. Үүнд ойн нөхөрлөлүүд болон нутгийн иргэд чухал үүрэг гүйцэтгэж чадна. Ойн тухай хуульд үүнийг хэрэгжүүлэх нөхцөлийг тогтоож, дүрэм журмаар нарийвчлан тусгаж болно. Цаашилбал, ойн байгалийн нөхөн сэргэлтийг дэмжих, бэлчээрийн тогтвортой менежменттэй холбоотой зохицуулалтууд, ойн нөхөрлөлийн гэрээгээр эзэмшиж байгаа ойн санд мал бэлчээх журам гаргах талаар тусгах шаардлагатай. Ойжуулалт, байгалийн нөхөн сэргэлтийн бүсэд мал бэлчээрлэх, хадлан бэлтгэхийг хориглохоор заасан боловч бодит амьдралд хэрэгжихгүй байгаагаас үр дүнгүй байгаа тул хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарах нь зүйтэй.

Мод үржүүлгийн газар байгуулахад татварын хөнгөлөлт, хөнгөлөлт үзүүлэх:

Энэ нь мод тарих зорилгыг хэрэгжүүлэх чухал нөлөө үзүүлнэ. Мод үржүүлгийн газрыг ойжуулалт, нөхөн сэргээлт, ойн зурвас байгуулах талбайн ойролцоо хийх, ойн нөхөрлөлүүдийг мод үржүүлгийн газрын төлбөрөөс чөлөөлж, дуудлага худалдаагүй газрын нь олгох зохицуулалтыг тусгаж болно.

Ойн нөхөрлөлүүд ойг хамгаалах чиглэлээр ажилладаг боловч менежментийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, ойг хамгаалахад хувь нэмэр оруулах зохих урамшуулал дутмаг байдаг. Иймд ойн нөхөрлөлүүдэд олгох санхүүгийн урамшууллыг нэмэгдүүлэх, сайжруулах шаардлагатай. Тухайлбал:

- ОтХ-ийн 21 дүгээр зүйлд ОН-ийн эрх, үүрэгт ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах ажил хийсэн газрыг хэдэн жилийн хугацаанд хамгаалах зорилгоор сумдын Засаг дарга эсвэл Ойн ангитай гэрээ байгуулж болно гэж тодорхой заалт нэмж оруулах. (Тэрбум мод санаачилгыг хэрэгжүүлэхэд хамааралтай)

- Ойн нөхөрлөлийн гэрээгээр эзэмшиж буй ойн санд байгалийн сэргэн ургалтыг дэмжих, бэлчээрийн тогтвортой менежменттэй холбоотой зохицуулалтыг тодорхой болгох. (Тэрбум мод санаачилгыг хэрэгжүүлэхэд хамааралтай).

- Ойн нөхөрлөлүүдийг хамгааллын менежментэд оролцуулахдаа дагалт баялгийг хөнгөлөлттэй үнээр ашиглуулах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос урамшуулах, төлбөрөөс чөлөөлөгдөх, хөнгөлөлт эдлэх боломжийг нэмэгдүүлэх гэх мэт санхүүгийн хөшүүрэг бий болгох. Ойжуулалт, ойн аж ахуй эрхэлдэг иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгжийг урамшуулах журмыг боловсруулах.[26]

- ОН-үүд нь хуулийн этгээд биш улсын бүртгэлийн дугааргүй, мод бэлтгэх зөвшөөрөл байдаггүй учир хэдэн хувийг дундын сандаа оруулахаа өөрсдөө шийдвэрлэх нь тохиромжтой.

- ОН-үүдэд ойг түймрээс хамгаалахад сумаас дэмжлэг, төсөв батлах.

- ОН-үүдийг мэргэжил арга зүйгээр хангах, ойн сангийн өөрчлөлтийг бүртгэсэн тохиолдолд урамшуулал өгөх.

- Идэвхтэй үйл ажиллагаатай ОН-үүдийг улсын бүртгэлд бүртгүүлж, ажиллагаа үйл өргөжүүлэх боломжийг хангах.

- ОН-үүд байгалийн нөөцөө хамгаалж байгаа учир нөөцийн төлбөрөөс чөлөөлөгдөх, хөнгөлөлт эдлэх боломжийг нэмэгдүүлэх гэх мэт урамшууллын арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн, практикт сумын Засаг дарга нь сумынхаа ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсвийг ИТХ-аар батлуулан хэрэгжүүлдэг. Уг төсөвт ОН-үүдийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөв давхар батлагдах шаардлагатай.[27]

Мөн тухайн судалгааны төслийн ажлын хүрээнд орон нутгийн ойн нөхөрлөлүүдтэй уулзан ярилцахад дараах хүндрэл, бэрхшээл учирдаг талаар мэдээлэл өгсөн юм.

Шигтгээ 1.

"...Ойн нөхөрлөлүүд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Орлогын эх үүсвэрээ төрөлжүүлэх, нэмэгдүүлэх нь зохистой. ...Тусгай зөвшөөрөл эрхийг тодорхой байлгах нь зүйтэй. Хүний нөлөө ихтэй байна. ИТХ Улсын байцаагч, багийн дарга, засаг дарга гэх мэт шат шатандаа өөрсдийн үзэмжээр хандах хандлага байна..."

Сэлэнгэ аймгийн 7 нөхөрлөлийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлийн хэсгээс

Шигтгээ 2.

[26] Финляндын Зөвлөх групп, Монголын Ойн судалгааны нийгэмлэг ТББ, ТА-9899 MON: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр Ойн ангийн чадавхын үнэлгээний тайлан, 2023.

[27] ТТ-9899 MON: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсын Ойн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид хийсэн дүн шинжилгээ, 2023, 2-26 дахь тал.

"...Шинээр нөхөрлөл байгуулах эсэх тодорхойгүй. /Газрын гэрчилгээний бүтэцтэй адил/ Ойн нөхөрлөл нь одоогийн байдлаар 215-аас 160 болж буурсан. Одоо 63 нөхөрлөл байна. Одоогийн ЗДТГ-ын үзэмжээр үйл ажиллагаа явж байна..."

Булган аймгийн 4 нөхөрлөлийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлийн хэсгээс

Шигтгээ 3.

"...Сумын ойн мэргэжлийн байгууллага тусгаарлалт хийлгэсэн боловч ирж ажиллаагүй байна. ...Аймагт ойр учир модны хулгай гардаг. ...Хуулийн хэрэгжилт явахад мэргэжлийн байгууллагаар заавал хэрэглээний модны зөвшөөрөл авдаг асуудал байна. ...Байгаль орчны тухай хуультай "Нөхөрлөл" гэх ойлголтын хүрээнд давхцал байнга үүсгэдэг..."

Хөвсгөл аймгийн 2 нөхөрлөлийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлийн хэсгээс

Дээрхээс дүгнэвэл, Ойн тухай хууль дахь нөхөрлөлийн үйл ажиллагаа, зохион байгуулалттай холбоотой дараах асуудал үүсэж байна.

1. Эрх зүйн зохицуулалтын давхардал, зөрчилтэй байдал

- Ойн нөхөрлөл нь нутгийн иргэдийн сайн дурын, мэргэжлийн бус нэгдэл хэдий ч хуулиар мэргэжлийн байгууллагын шинжтэй үйл ажиллагаа (ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх) явуулах үүрэг хүлээлгэсэн нь ойлгомжгүй, зөрчилтэй байдлыг үүсгэж байна.

Ойн нөхөрлөлийг хуулийн этгээдэд тооцдоггүй тул татварын дугааргүй, санхүүгийн боломж хязгаарлагдмал, ашиг олж нөөц бүрдүүлэх эрхгүй, хамгааллын үүрэгтэй боловч бодит эрх мэдэл дутмаг байна.

2. Ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт сул

Судалгаанд хамрагдсан нөхөрлөлийн 86 хувь нь төлөвлөгөөтэй боловч тэдгээрийн олонх нь бусдын загварыг хуулбарласан, газар дээр нь судалгаа хийдэггүй, бодит үйл ажиллагаанд ашиглагдахгүй төлөвлөгөө байдаг. Үүний улмаас ойн нөхөрлөлийн ажил "цаасан дээр" үлдэх, бодит үр нөлөө үзүүлэхгүй байна.

3. Жил бүрийн тайлагнал хангалтгүй

Хуулиар сумын ИТХ-д жил бүр тайлагнах зохицуулалттай боловч 45 хувь нь тогтмол тайлагнадаг, үлдсэн хэсэг нь тогтмол бус буюу огт тайлагнадаггүй байна. Энэ нь үйл ажиллагааг үнэлэх, хариуцлага тооцох механизм хангалтгүй байгаатай холбоотой.

4. Санхүүгийн чадавх сул

Судалгаанд хамрагдсан нөхөрлөлийн 44 хувь нь дундын сангүй, 36 хувь орлогогүй. 7.5 хувь нь 10 сая төгрөгөөс дээш орлоготой байна. Үүнээс үзвэл, санхүүгийн эх үүсвэр дутмаг байгаагаас ойн нөхөрлөлийн идэвх сулрах, тогтвортой ажиллах нөхцөл бүрдэхгүй байна.

5. Ойн түймэр болон хортон шавжтай тэмцэх чадавх хангалтгүй

Хуульд өөрийн хөрөнгөөр түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахаар хуульчилсан нь сайн дурын иргэдийн хувьд хүндрэлтэй байдлыг бий болгож байна. Түүнчлэн, хуулиар үүрэг

хүлээлгэхээс гадна төрийн болон орон нутгийн байгууллагуудын хариуцлага, дэмжлэг тодорхой бус байна.

6. Ойн нөхөн сэргээлт, ойжуулалтын үр нөлөө хязгаарлагдмал

Ойн нөхөрлөлийн 25 хувь нь нөхөн сэргээлтийн ажил хийж байгаагүй, 59 хувь нь мод үржүүлгийн газаргүй, туршлага дутмаг байна. Байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажил хэрэгжиж байгаа боловч малын бэлчээрийн дарамтаас болж үр нөлөө багасаж байна.

7. Орон нутгийн дэмжлэг сул

Сумын ИТХ, Засаг дарга нар ойн нөхөрлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхгүй байгаа нь нөхөрлөлийн идэвхийг бууруулж байна.

Дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах талаар дараах саналыг гаргаж байна. Үүнд:

1. Эрх зүйн шинэчлэл

Ойн нөхөрлөлийг зөвхөн "Ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах" биш, харин сумын хэмжээнд батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцох чиг үүрэгтэй, эрх зүйн статусыг тодорхой болгох. Сайн дурын иргэдийн бүлэг хэлбэрээр үлдээх эсвэл хуулийн этгээд болгон өөрчлөх боломжийг судлах.

2. Санхүүгийн дэмжлэг ба урамшууллын тогтолцоо

Ойн нөхөрлөлийн дундын сан бүрдүүлэхэд татварын хөнгөлөлт, байгалийн нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, төсвийн дэмжлэг үзүүлэх. "Менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлд суурилсан урамшууллын систем" бий болгож, ой хамгаалах, нөхөн сэргээх ажилд бодит шагнал олгох. Мөн тэрбум мод санаачилгатай уялдуулан мод үржүүлгийн газрыг үнэ төлбөргүй эсвэл татварын хөнгөлөлттэй олгох.

3. Хариуцлага ба тайлагнал

Жил бүрийн тайлагналыг бүх нөхөрлөлөөс тогтмол авч, сумын ИТХ-аар хэлэлцэн үнэлдэг хяналтын тогтолцоог сайжруулах. Үйл ажиллагааны тайланг үнэлэх шалгуур үзүүлэлт боловсруулж, олон нийтэд ил тод мэдээлэх.

4. Ойн хамгаалал, нөхөн сэргээлт

Байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажлыг өргөжүүлэх, малын бэлчээрлэлтээс хамгаалах арга хэмжээг мөрдүүлэх. Ойн нөхөрлөлийг мод үржүүлгийн газар байгуулахад татварын болон газар эзэмших дэмжлэг үзүүлэх. Ойн нөхөн сэргээлтийн ажлыг төрийн болон олон улсын төсөл, хөтөлбөртэй уялдуулах.

5. Түймэр, хортонгоос хамгаалах чадавх бэхжүүлэх

Ойн түймэртэй тэмцэхэд орон нутгийн төсвөөс тогтмол хөрөнгө батлах, нөхөрлөлийг шаардлагатай тоног төхөөрөмж, гар багаж, сургалтаар хангах. Түймрийн эргүүл, хяналт хийхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, нөхөрлөлийг орон нутгийн гамшгийн бэлэн байдлын тогтолцоонд нэгтгэх.

6. Орон нутгийн хамтын ажиллагааг сайжруулах

Сумын ИТХ, Засаг даргын төсөвт ойн нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардлыг тусгах. Ойн анги, сум орон нутгийн байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, чадавхжуулах сургалт, хяналт, зөвлөгөөг тогтмолжуулах гэх мэт.

Монгол Улсын хувьд ойн нөхөрлөлүүдийн зохицуулалт нь иргэдийн сайн дурын оролцоонд тулгуурласан, төрийн байгууллагын захиалга, хяналтаар чиглэсэн хэлбэртэй байсаар байгаа бөгөөд эрх зүйн статусаараа сул, эдийн засгийн хувьд хараат, өөрийн хөрөнгө, техникийн чадавх, бүтээгдэхүүн борлуулах эрх сул хэвээр байна. Монголын ойн нөхөрлөлүүд нь ихэнхдээ байгаль хамгаалалт, нөхөн сэргээлтийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, ойн бүтээгдэхүүнээр зах зээлд оролцох боломж хязгаарлагдмал, гишүүдэд очих үр ашиг, ашиг орлого бага байдаг нь үйл ажиллагааны идэвхийг сулруулж, тогтвортой байдлыг хангахад хүндрэл учруулж байна.

Монгол Улсад ойн нөхөрлөлийн эрх зүйн статусыг тодорхой болгож, хуулийн этгээдийн хувьд бүртгэгдсэн, эдийн засгийн үйл ажиллагаа явуулах бүрэн эрхтэй, менежментийн төлөвлөгөөтэй, гишүүдийн оролцоонд тулгуурласан, төрийн байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн, хариуцлагатай бүтэц болгон хөгжүүлэх нь чухал юм. Энэ нь зөвхөн байгаль хамгаалалтаар хязгаарлагдахгүйгээр ойн нөхөрлөлийг жинхэнэ утгаар нь хамтын менежментийн нэгж болгон хөгжүүлэх, эдийн засгийн үр ашиг бий болгох, ойн тогтвортой ашиглалтыг хангах цогц эрх зүйн шинэчлэлийн үндэс суурь болох боломжтой юм.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Ойн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан ойн тооллого болон ойн зохион байгуулалттай холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл учирч байгаа эсэх.

Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.13-т *"ойн тооллого, ой зохион байгуулалт" гэж ойн сангийн талбай, нөөц, тархац, бүрэлдэхүүн, чанар, төлөв байдал, өөрчлөлтийг тогтоох, хүлэмжийн хийн шингээлтийг тооцох, биомассын судалгаа хийх, ойн нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг цогц байдлаар тодорхойлсон үйл ажиллагааг"* ойлгохоор заасан бөгөөд тус хуулийн 7 дугаар зүйлд ойн тооллого, ой зохион байгуулалт, түүний санхүүжилттэй холбоотой асуудлыг хуульчилжээ.

Тус хуулийн 7 дугаар зүйлд зааснаар ойн тооллого, ой зохион байгуулалтын ажлыг төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан ойн мэргэжлийн байгууллага гүйцэтгэх бөгөөд Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулага ойн тооллогыг 5 жил тутам улсын хэмжээнд явуулахаар, ой зохион байгуулалтын ажлыг арван жил тутамд хийж ойг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг шинэчлэн батлахаар тусгажээ.

Манай улсын хувьд үндэсний ойн тооллогыг 2014-2016 онд хийж байсан бөгөөд ойн зохион байгуулалтын ажлыг 2020 онд Увс, Өвөрхангай, Ховд аймгийн ойн санд хийж, улсын ойн сангийн төлөв байдлын мэдээллийг шинэчилсэн байна.[28] Түүнчлэн, 2021 онд Өмнөговь аймаг, 2022 онд Говь-Алтай аймаг, 2023 онд Хэнтий, Дархан-Уул, Сүхбаатар, Орхон аймагт ойн зохион байгуулалтын ажлыг тус тус хийсэн байна.

2024 оны байдлаар 21 аймаг, 238 сум, 1 хот 5 дүүргийн газар нутагт тархан ургаж байгаа ойн сангийн мэдээг нэгтгэн Улсын ойн мэдээг шинэчлэн боловсруулсан байна. Түүнчлэн, шилмүүст

[28] ҮСХ, Байгаль орчин-эдийн засгийн данс: Ойн нөөцийн данс-2023, (Уб, 2024), 5 дахь тал.

навчит ойн сан бүхий 16 аймаг, 194 сум, 1 хот, 5 дүүрэг байгаа бол заг тооройн ойн сан бүхий 8 аймаг 43 сум байна. Монгол Улсын ойн сангийн нийт талбайн 72.8 хувийг навч, шилмүүст ой, 27.2 хувийг заган ой эзэлж байна.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монгол Улсын ойн сангийн нийт талбай нь 19,103,221 га байна. Үүнээс ойн талбай 18,585,024 га буюу 97.3 хувь, ойн бус талбай 518,197 га буюу 2.7 хувийг эзэлж байна. Түүнчлэн, ойгоор бүрхэгдсэн талбай 13,217,327 га бөгөөд үүнээс байгалийн ой 12,215,614 га, сөөг торлог 991,966 га, таримал ой 9,747 га байна.

Харин ойгоор бүрхэгдээгүй талбай 5,367,697 га байгаагаас Тармаг мод 3,609,116 га, Түймэрт нэрвэгдсэн талбай 1,376,664 га, Мод бэлтгэсэн талбай 129,731 га, Ойжиж буй талбай 25,790 га, Хөнөөлт шавжид нэрвэгдсэн талбай 100,064 га, Салхи цасанд унасан талбай 457 га байна. 2024 оны байдлаар байгалийн ойн талбай 12,217,060 га, байгалийн ойн нөөц 1,259,025,491 шоо метр байна.

Хүснэгт 6. Шилмүүст, навчит ой насны бүлгээр

Насны бүлэг	Талбайн дүн /га/	Хувь	Нөөцийн дүн /шоо метр/	Хувь
Болц гүйцсэн хөгшин ой	6,512,589	64.1%	915,608,980	72.8%
Болц гүйцэж яваа	1,534,752	15.1%	186,007,590	14.8%
Дунд насны ой	1,743,550	17.2%	145,031,230	11.5%
Залуу ой	364,610	3.6%	10,483,410	0.8%
Нийт	**10,155,501**	**100%**	**1,257,131,210**	**100%**

Хүснэгт 7. Заган ой, насны бүлгээр

Насны бүлэг	Талбайн дүн /га/	Хувь	Нөөцийн дүн /шоо метр/	Хувь
Хөгшин заг	705,922	34.25%	749,537	42.08%
Болц гүйцсэн заг	778,296	37.76%	681,301	38.25%
Болц гүйцэж яваа заг	312,797	15.18%	218,867	12.29%
Дунд насны заг	137,327	6.66%	52,895	2.97%
Залуу заг	126,625	6.14%	78,797	4.42%
Нийт	**2,060,967**	**100%**	**1,781,399**	**100%**

Хүснэгт 8. Байгалийн нөөц (2022, 2023 он)

Модны төрөл	2022 он	2023 он
Шинэс	988,413,730	992,299,640
Нарс	61,756,860	64,450,140
Хуш	111,175,550	112,634,920
Гацуур	2,817,230	2,816,300
Жодоо	153,340	153,340
Хус	74,372,540	78,896,460
Улиас	2,147,530	2,085,030
Улиангар	677,800	640,080

Хайлаас	76,200	95,230
Бургас	3,132,720	3,160,070
Заг	1,728,391	1,728,391
Тоорой	65,890	65,890

Хүснэгт 9. Тархцын дундаж үзүүлэлт

Модны төрөл	Байгалийн ойн талбай /га/	Бүх нөөц /ш.м/	Б.Г.Х ойн талбай /га/	Б.Г.Х ойн нөөц /ш.м/	Бүх дундаж өсөлт /ш.м/	Дундаж			Б.Г.Х ойн 1 га-н нөөц /ш.м/	Ойгоор бүрхэгдсэн 1 га талбайн	
						Нас /жил/	Бонитет	Өтгөрөл		нөөц /ш.м/	өсөлт /ш.м/
Шинэс	7,408,922	992,299,640	5,633,837	798,255,300	7,194,318	137.9	4.3	0.50	141.69	133.93	0.97
Нарс	531944	64,450,140	311,251	43,153,570	567,137	113.6	4.0	0.50	138.65	121.16	1.07
Хуш	626,970	147,314,920	231,590	46,437,150	1,006,800	146.3	4.5	0.51	200.51	234.96	1.61
Гацуур	20.944	2,816,300	12,632	1,825,220	23,906	117.8	4.2	0.49	144.49	134.47	1.14
Жодоо	1,081	153,340	687	112,980	1,160	137.6	4.0	0.53	164.45	141.85	1.07
Хус	1,361,977	78,896,460	302,676	24,450,560	1,662,466	47.5	4.1	0.49	80.78	57.93	1.22
Улиас	33,850	2,085,030	18,577	1,290,730	31,082	66.8	4.1	0.49	69.48	61.60	0.92
Улиангар	13,469	640,080	1,029	71,390	16,413	39.0	4.2	0.51	69.38	47.52	1.22
Хайлаас	3,631	95,230	310	12,080	2,064	45.6	4.4	0.40	38.97	26.23	0.57
Бургас	152,713	3,160,070	-	-	129,428	24.4	4.5	0.40	-	20.69	0.85
Дүн	**10,155,501**	**1,291,911,210**	**6,512,89**	**915,608,980**	**10,634,774**		**4.23**	**0.51**	157.96	153.27	1.17
Заг	2,059,634	1,728,391	5,401	7,787	62,105	27.82	2.95	0.37	1.44	0.83	0.03
Тоорой	1,925	65,890	1,413	36,620	1,080	60.99	4.46	0.36	25.91	34.22	0.56
Дүн	**2,061,559**	**1,794,281**	**5,384**	**7,306**	**65,717**						
Нийт дүн	**12,217,060**	**1,293,705,491**	**6,517,973**	**915,616,286**	**10,700,491**						

Монгол орны ойн сангийн жилийн дундаж өсөлт 10,700,491 шоо метр байна.

Хүснэгт 10. Ойн сангийн газрын төрлийн өөрчлөлт

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он
Монгол орны газар нутгийн хэмжээ	156,411.6	156,411.6	156,411.6	156,411.6
Ойн сангийн нийт талбай	18,610.428	18,704.405	19,073.7	19,103.2
Ойгоор бүрхэгдсэн	12,619.423	12,798.3	12,949.8	13,217.3
Байгалийн ой	11,851.742	11,813.01	11,944.0	12,215.6
Сөөг, торлог	759.725	975.89	996.4	992.0
Таримал ой	7.956	9.4020	9.4020	9.7470
Ойрхог чанар, %	**8.07**	**8.18**	**8.28**	**8.45**
Ойгоор бүрхэгдээгүй	5,456.31	5,371.41	5,603.5	5,367.7
Тармаг модод	3,399.2	3,319.6	3,584.3	3,609.1
Түймэрт нэрвэгдсэн	1,645.4	1,645.4	1,645.4	1,376.7
Мод бэлтгэсэн	130.7	130.1	129.1	129.7
Байгалийн аясаар ойжиж байгаа	151.7	147.9	116.2	125.9
Зориудаар ойжуулсан	25.8	25.8	25.8	25.8
Хөнөөлт шавжид нэрвэгдсэн	102.2	102.2	102.2	100.1
Салхи цасанд унасан ой	0.5	0.5	0.5	0.5
Хатсан заг	0.82	0.01	0.01	0.01
Ойн талбай	18,075.728	18,169.705	18,553.3	18,585.0
Ойн бус талбай	534.7	534.7	520.4	518.2

Ойн сангийн нийт талбай нэмэгдэж гарсан нэг шалтгаан нь 2009 оноос эхлэн ой зохион байгуулалтын зураглалын ажилд Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолоор баталсан стандартын дагуу проекцын шинэчлэл хийгдсэн явдал юм. Мөн ой зохион байгуулалтын ажилд орон зайн нарийвчлал сайтай хиймэл дагуулын мэдээг *(Зарим тохиолдолд өндөр нарийвчлалын сансрын зураг)* ашиглаж байгаатай холбоотой.

Олон зорилтот ойн тооллогын ажлын арга менежментэд тулгуурлан 2017 оноос эхлэн ойн бүрхэвчийн үнэлгээ хийх, Collect Earth программаар газар ашиглалтын үнэлгээг хийж ой зохион байгуулалтын давтан зохион байгуулалтын ажлын ойн тархалтын талбайг тодорхойлж, дээж талбай байгуулан ойн сангийн үзүүлэлтийг нарийвчлан тогтоож байгаа нь ойн сангийн өөрчлөлтийг гаргахад ойн сангийн газрын төрлийн нарийвчлал нь өмнөх онуудад хийгдэж байсан зураглалын ажлаас чанарын хувьд дээшилсэн гэж дүгнэжээ.

Ойн тооллоготой холбоотойгоор тухайн тооллогын үр дүн бүрэн бодитой эсэх асуудал хөндөгддөг. Учир нь ойн тооллого хийхэд хүний нөөц хангалтгүй, санхүүжилт дутмаг байгаа нь ойн менежментийн төлөвлөгөөнд нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, ойн тооллого болон ойн зохион байгуулалтын ажлыг хуульд заасны дагуу гүйцэтгэж байгаа боловч тухайн салбарын хүний нөөц, ойн тооллого, ойн зохион байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай төсвийн асуудал тухайн хуулийн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагавар, зорилгод нөлөөлж байна.

Түүнчлэн, хуульд ойн тооллого, ойн зохион байгуулалтыг хамтад нь хуульчилсныг ойлгомжтой болгох үүднээс тухайн ойлголтуудыг өөр хоорондын ялгаатай байдлыг харгалзан тусад нь нэр томьёог тайлбарлан хуульчлах нь зүйтэй.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. Ойн тухай хуулийн 40 дүгээр зүйл заасан ой ашигласны төлбөртэй холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? зохицуулалт нь практикт нийцэж байгаа эсэх. Тухайн зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл байгаа эсэх.

Ойн тухай хуулийн 40 дүгээр зүйлд ойн ашигласны төлбөр, хураамжийг зохицуулсан бөгөөд ойн баялгийн нөөц ашигласны төлбөрт ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөр, ойн дагалт баялгийн нөөц ашигласны төлбөр хамаарч байна. Мөн энэхүү асуудлыг Байгалийн нөөц, ашигласны төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэг, 11 дүгээр зүйл, 13 дугаар зүйл, 16 дугаар зүйл, 18 дугаар зүйлээр тус тус зохицуулж байна.[29]

Өөрөөр хэлбэл, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого нь 5 орлогоос бүрддэг бөгөөд үүнд ойн нөөц, ашигласны төлбөрийн орлого хамаарч байна. Эдгээр орлогыг дурдвал;

- байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого;
- ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого;
- ойн нөөц ашигласны төлбөрийн орлого;
- ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого;
- газрын нөөцийн төлбөрийн орлого зэрэг болно.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сангаас үзвэл, 2023 онд Байгалийн нөөц ашигласны орлого 164,123,025,911 (Нэг зуун жаран гурван тэрбум нэг зуун хорин гурван сая хорин таван мянга есөн зуун ерэн нэг) төгрөг байжээ. Үүнийг 57.4 хувь нь ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого, 30 хувь нь газрын нөөцийн төлбөрийн орлого, 13 хувь нь ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого, 4.1 хувь нь ойн нөөц ашигласны төлбөр байжээ.[30]

Зураг 10. Байгалийн нөөц ашигласны орлого (2023 он)

2023 онд ойн нөөц ашигласны төлбөр 6,715,026,034 (Зургаан тэрбум долоон зуун арван таван сая хорин зуун мянга гучин дөрөв) төгрөг байжээ. 2023 онд байгалийн нөөц ашигласны төлбөр төлөгч 1,518 этгээд байсан бөгөөд үүний 416 буюу 27.4 хувь нь ойн нөөц ашигласны төлбөр төлөгч байжээ.

Зураг 11. Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөгч (2023 он)

[29] Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 2012, https://legalinfo.mn/mn/detail?lawId=8663
[30] https://finance.eic.mn/implement?y=2023&a=



2024 онд Байгалийн нөөц ашигласны орлого 179,533,101,048 (Нэг зуун далан есөн тэрбум таван зуун гучин гурван сая нэг зуун нэг мянга дөчин найм) төгрөг байжээ. Үүнийг 63.9 хувь нь газрын нөөц төлбөрийн орлого, 24.7 хувь нь ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого, 6.7 хувь нь ан амьтны нөөц ашигласны төлбөрийн, 4.6 хувь нь ойн нөөц ашигласны төлбөр байжээ.[31]

Зураг 12. Байгалийн нөөц ашигласны орлого 2024 он,



2024 онд ойн нөөц ашигласны төлбөр 8,252,270,131 (Найман тэрбум хоёр зуун тавин хоёр сая хорин зуун далан мянга нэг зуун гучин нэг) төгрөг болж, өмнөх оноос 1.5 тэрбум төгрөгөөр өссөн байна. 2024 онд байгалийн нөөц ашигласны төлбөр төлөгч 1,502 этгээд байсан бөгөөд үүний 400 буюу 26.6 хувь нь ойн нөөц ашигласны төлбөр төлөгч байжээ.

Зураг 13. Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөгч (2024 он)

[31] https://finance.eic.mn/implement?y=2024&a=

Хэрэгжүүлсэн БОХНСАХ-ний тоо (нөөцийн төрлөөр)



Байгалийн нөөц баялаг ашигласны нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын 85 хувийг байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах"-аар хуульчилсан. Гэвч Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасны дагуу мод огтолсны төлбөрийн 85 хувийг ойн анги сум дундын ойн ангид буцааж өгөх ёстой боловч орон нутгийн засаг захиргаа энэ тал дээр хайнга хандаж байна.[32]

Тодруулбал, 2017 онд ойн ашиглалтын төлбөрөөс 10.9 тэрбум төгрөг (5.4 сая ам. доллар) төвлөрүүлсэн боловч орон нутгийн төсвөөс ойн аж ахуй, ойг хамгаалах үйл ажиллагаанд зориулж ердөө 3 тэрбум төгрөг (1.5 сая доллар) зарцуулсан байна. Энэ нь нийт хураасан төлбөрийн 28 хувьтай тэнцэж байгаа нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд (2012) ой ашигласны төлбөрийн 85-аас доошгүй хувийг байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд дахин хөрөнгө оруулалт хийх ёстой гэсэн заалтыг зөрчсөн байна. Эндээс харахад Байгалийн нөөц ашигласны тухай хууль ч Засгийн газрын холбогдох дүрэм журам ч зохих ёсоор мөрдөгдөөгүй нь илт байна. Хэрэв 2017 онд зөв хэрэгжүүлсэн бол ойд 6.3 тэрбум төгрөг буюу 3.1 сая ам.долларын нэмэлт хөрөнгө оруулалт хийх байсан. 2019 онд ой ашигласны төлбөрт 3.6 тэрбум төгрөг төвлөрүүлсний 2.4 тэрбум төгрөг буюу 67 орчим хувийг л ой хамгаалах ажилд зарцуулсан байна.[33]

Өөрөөр хэлбэл, ойн нөөц ашиглалтын төлбөрийн зарцуулалт нь хуульд зааснаар бол буцаад салбартаа хөрөнгө оруулалт орж чаддаггүй.[34]

Сүүлийн жилүүдэд БГАТтХ-ийн дагуу төлбөрийн орлого өсөж, хуулийн хэрэгжилт буюу орон нутгийн төсөвт ордог ус, ой, байгалийн ургамал, амьтны нөөц, газрын төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийн нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах байдал сайжирсан. Тухайлбал, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын 2024 оны гүйцэтгэл 47.4 тэрбум төгрөг (Сангийн яам, 2024) буюу 2021 оны гүйцэтгэлээс 3.8 дахин буюу 35.2 тэрбум төгрөгөөр өсөж, хуулийн хэрэгжилт 26 хувиас 64.3 хувь болж сайжирсан байна.[35]

---

[32] Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр, Боть 2, Салбарын шинэчлэлийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, Төгсгөлийн тайлан, 6 дахь тал.
[33]Мөн тэнд, 11 дэх тал.
[34] Сэлэнгэ аймгийн Мандал суманд 2025.08.30-ны өдөр зохион байгуулсан фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс.
[35] Алсын хараа 2050 Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлого, 5 жилийн тайлан, 2020-2024 оны хэрэгжилтийн тайлан, 284 дэх тал.

Гэхдээ ойн хөнөөлт шавжийн тархалт, олшролын голомт дорвитой буурахгүй, ойд хөнөөл учруулах хэмжээнд байгаа, нөгөө талдаа тэмцлийн ажлын санхүүжилт хангалтгүй байгаа тул ойд хохирол учруулах эрсдэл өндөр хэвээр байна.[36]

Төв орон нутагт үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг хэрэгжүүлж, БНАТ-ийн орлогыг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд үр ашигтай зарцуулах.[37]

Орон нутгийн төсөвт орж байгаа ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг ойн хөнөөлт шавж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээнд үр дүнтэй зарцуулах.

Байгаль орчны болон байгалийн нөөц ашиглалтын бүртгэл, дүн мэдээ, өгөгдлийг цуглуулах, нэгтгэж тооцоолох, тайлагнах, хянан баталгаажуулах үйлдлийг цахимжуулах.[38]

Ойгоос олох санхүүгийн орлогыг дахин хөрөнгө оруулалтад хангалттай төвлөрүүлдэггүй нь төслийн судалгааны үр дүнгээс тодорхой харагдаж байна. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль одоогоор мөрдөгдөж байгаа ч бодит байдал дээр хэрэгжилт бүрэн хангагдахгүй байна. Шинээр байгуулагдаж буй Ойн агентлаг байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бүрдүүлэх эрхтэй болж, үүгээрээ өөрийн болон орон нутгийн боловсон хүчнийг санхүүжүүлэх төсвийг бүрдүүлдэг байх ёстой.

Фокус бүлгийн ярилцлагад хамрагдсан ойн нөхөрлөлийн төлөөллөөс "...Ойн нөхөрлөлийн урамшууллын асуудал хуульд заасан ойн сангийн хуримтлалын 85 хувиас 20 хувийг ойн нөхөрлөлд хуваарилах..."[39], "...Аймгийн төсөвт тодорхой өндөр дүнтэй төсвийн бүрдүүлэлтийг хийж өгдөг. 80-90 хувийг бүрдүүлж өгдөг. Эргээд зарлага талд орон нутаг салбарыг дэмжсэн бодлого, зарцуулалт байдаггүй..."[40], "...Байгалийн нөөцийн 85 хувийн зарцуулалт хангагдаж байна уу 450-500 сая.төгрөгийн хооронд орлого төвлөрдөг. Сум дээр зарцуулалт хангалтгүй хийгдэж байна..." [41] зэрэг санал, шүүмжийг гаргаж байв. Мөн Ойн тухай хуульд санхүүжилт, хөрөнгө оруулалттай холбоотой эрх зүйн зохицуулалт дутмаг байна.

Дээрхээс дүгнэвэл, Ойн тухай хуулийн 40 дүгээр зүйлд ойн ашигласны төлбөр, хураамжийг зохицуулсан бөгөөд ойн баялгийн нөөц ашигласны төлбөрт ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөр, ойн дагалт баялгийн нөөц ашигласны төлбөр хамаардаг. 2023 онд ойн нөөц ашигласны төлбөр 6,715,026,034 (Зургаан тэрбум долоон зуун арван таван сая хорин зуун мянга гучин дөрөв) төгрөг, 2024 онд ойн нөөц ашигласны төлбөр 8,252,270,131 (Найман тэрбум хоёр зуун тавин хоёр сая хорин зуун далан мянга нэг зуун гучин нэг) төгрөг болж, өмнөх оноос 1.5 тэрбум төгрөгөөр болж өссөн байна.

Гэвч практикт ойн нөөц ашиглалтын төлбөрийн зарцуулалт нь хуульд зааснаар бол буцаад салбартаа хөрөнгө оруулалт орж чаддаггүй бөгөөд ойгоос олох санхүүгийн орлогыг дахин хөрөнгө оруулалтад хангалттай төвлөрүүлдэггүй талаар ойн салбарын үйл ажиллагаа явуулдаг ойн анги, мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлийн зүгээс онцолж байна.

Иймд байгалийн нөөц ашигласны төлбөрөөр ойн салбарт ажиллаж буй орон нутгийн хүний нөөцийг чадавхжуулах, байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг өгсөн нөхөрлөлийн гишүүдийг хуулийн хүрээнд урамшуулах, ойн нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг дэмжих

[36] Мөн тэнд.
[37] Мөн тэнд.
[38] Мөн тэнд.
[39] Сэлэнгэ аймагт 2025.08.29-ний өдөр зохион байгуулсан фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс.
[40] Хөвсгөл аймагт 2025.09.05-ны өдөр зохион байгуулсан фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс.
[41] Булган аймагт 2025.09.04-ний өдөр зохион байгуулсан фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс.

зэргээр үр ашигтайгаар зарцуулах нь зүйтэй. Мөн санхүүжилт, хөрөнгө оруулалттай холбоотой эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, олон улсын жишигт нийцүүлэх нь зүйтэй.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4. Ойн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хамгаалалтын бүсийн ойтой холбоотой зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Тус зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээл үүсэж байгаа эсэх.

Ойн тухай хуулиар ойн бүсийг "хамгаалалт", "ашиглалт", "улсын тусгай хэрэгцээ" гэсэн 3 ялгаатай байдлаар хуульчилсан боловч "хамгаалалт", "ашиглалт" гэсэн нэр томьёонуудыг тодорхойлоогүй байна. Өөрөөр хэлбэл, Ойн тухай хуулийн 8.1-д зааснаар хамгаалалтын бүсийн **ойд цармын бүслүүрийн ой, тусгай хамгаалалттай газрын болон сургалт, судалгааны зориулалттай ой, ногоон бүс, хориотой зурвасын ой, заган ой, баян бүрдийн ой, 100 га хүртэлх хэмжээний төгөл ой, бут, сөөг, 30 хэмээс илүү налуу газрын ой хамаарна** гэж хуульчилсан.

Ойн судалгаа, хөгжлийн төвийн ойн нөөцийн тайланд дурдсанаар ойн сангийн нийт 18.6 сая га талбайгаас ердөө **16.9 хувь буюу 3.1 сая га нь ашиглалтын бүсэд хамрагддаг. Үлдсэн 83.1 хувь буюу 15.5 сая га ой нь тусгай хамгаалалттай газар нутаг, хамгаалалтын бүсийн ойд хамаарч байдаг.**[42]

График 5. Ашиглалтын болон хамгаалалтын бүсийн ойн харьцаа



Европын холбооноос хийсэн судалгаанд Монгол Улсын ойн сангийн нийт талбай 17.96 сая га байна. Хамгаалалтын ойн бүсэд өндөр уулын, тусгай хамгаалалттай газар нутгийн, сургалт, судалгаа шинжилгээнд зориулж тусгаарласан, ногоон бүс, хориотой зурвас, заг, баян бүрдийн, төгөл, бут сөөг бүхий 100 га хүртэлх ойн талбай, 30 градусаас дээш налуу газрын ой мод хамаарна. Хамгаалалтын бүсэд зам, гүүр, ус хангамж, цахилгаан, харилцаа холбооны шугам барих, түймрээс урьдчилан сэргийлэх шороон зурвас байгуулах, ойн нөхөн сэргэлт, ургалтыг дэмжих, ойн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээ хэрэгжүүлэх, ойн дагалт баялгийг ашиглахаас бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Хориотой зурвасын ойд нуур, рашаан, голын эрэг орчмын 1,000 метрийн радиус дахь ой мод, улсын чанартай авто зам, төмөр замын хоёр талаар 100 метрийн доторх талбай багтана. Ойн тухай хуульд зааснаар ашиглалтын ойн бүсэд хамгаалалтын бүс, хориглосон зурвасын ойгоос бусад бүх ой багтана гэжээ.[43]

[42] Forest Research and Development Center (2021). Mongolian forest resources 2020. Annual report.
[43] Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр, Боть 2, Салбарын шинэчлэлийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, Төгсгөлийн тайлан, 2 дахь тал.

Хүснэгт 11. Монгол орны ойн сан, ойн дэглэмийн ангилал

Ойн ангилал	Талбай, га	Хамгааллын ойн хилийг тодорхойлох	Санхүүжилтийг хариуцах эзэн	Хэрэгжүүлж болох ОАА-н үйл ажиллагаа
Өндөр уулын, тусгай хамгаалалттай газар нутгийн, сургалт, судалгаа шинжилгээнд зориулж тусгаарласан, ногоон бүс, хориотой зурвас, заг, баян бүрдийн, төгөл, бут сөөг бүхий 100 га хүртэлх ойн талбай, 30 градусаас дээш налуу дээрх ой	5,328,444	БОАЖЯ	Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн ИТХ	Ойн сэргэн ургалтыг дэмжих зорилгоор арчилгаа, цэвэрлэгээний огтлолт хийх ашиглах, ойжуулах нөхөн сэргээх
Дурсгалт газар	50,407	УИХ	Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн ИТХ	Дурсгалт газраас 3 км радиуст аливаа үйл ажиллагааг хориглоно
Байгалийн цогцолборт газрын онцгой бүс	380,796	УИХ	ТХГ-ын захиргаа	Хөнөөлт шавж өвчинтэй тэмцэх, түймэр унтраах
Байгалийн цогцолборт газрын Хязгаарлалтын бүс	1,113,479	УИХ	ТХГ-ын захиргаа	Ойн санг гэрээгээр нөхөрлөл эзэмших, арчилгаа, цэвэрлэгээний огтлолт хийх дагалт баялаг ашиглах, түймэр болон хөнөөлт шавж өвчинтэй тэмцэх
Байгалийн цогцолборт газрын Аялал Жуулчлалын бүс	84,872	БОАЖЯ	ТХГ-ын захиргаа	Арчилгаа, цэвэрлэгээний огтлолт хийх, дагалт баялаг ашиглах, ойжуулах нөхөн сэргээх, он түймэр болон ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх
Байгалийн нөөц газар	116,600	УИХ	Байгалийн нөөц газрын захиргаа	Хориотой
Дархан цаазат газрын Онгон бүс	423,006	УИХ	ТХГ-ын захиргаа	Хориотой
Дархан Цаазат газрын Хамгаалалтын бүс	549,007	УИХ	ТХГ-ын захиргаа	Хөнөөлт шавж өвчинтэй тэмцэх, түймэр унтраах
Дархан Цаазат Газрын Хязгаарлалтын бүс	1,485,001	УИХ	ТХГ-ын захиргаа	Арчилгаа, цэвэрлэгээний огтлолт хийх, дагалт баялаг ашиглах, ойжуулах нөхөн сэргээх, ойн түймэр болон ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх
Улсын хил дагуух ой (Хориотой зурвасын ой)	279,225	БОАЖЯ	Улсын Тусгай хэрэгцээний газрын захиргаа (Жишээлбэл Хил хамгаалах газар, Нисэх буудал г.м.)	Арчилгаа, цэвэрлэгээний огтлолт хийх, дагалт баялаг ашиглах, ойжуулах нөхөн сэргээх, ойн түймэр болон ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх
Тодорхойлогдоогүй хамгаалалтын бүс	5,045,389	-	-	-
Нийт хамгааллын бүс	**14,857,234**			
Ашиглалтын бүс	3,102,817	Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн ИТХ	Хамгаалалтын бүсийн ойгоос бусад бүх ой	Ойг гэрээгээр ашиглах, мод бэлтгэх, цэвэрлэх, сийрэгжүүлэх, хортон шавжтай тэмцэх, ой

				хээрийн түймэртэй тэмцэх, нөхөн сэргээх
Нийт ойн сан	**17,960,051**			

Дээрх хоёр судалгаанд дурдсан ойн хамгаалалтын болон ашиглалтын бүсийн тоо мэдээ хоорондоо зөрүүтэй боловч ойн хамгаалалтын бүс ашиглалтын бүсээс өргөн хэмжээтэй гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна.

Хамгаалалтын бүсийн ойг тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулж байна. Ингэхдээ Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар хамгаалалтын газрын захиргаа байгуулагдаж, чиг үүрэг нь тодорхой тусгагдсан тул хамгаалалтын дэглэм тодорхой хэмжээнд хэрэгжиж байна. Ийнхүү өөр хуулиар зохицуулах нь практикт хүндрэл учруулдаг талаар Сэлэнгэ, Хөвсгөл, Булган, Төв аймагт зохион байгуулсан фокус бүлгийн ярилцлагад оролцсон мэргэжилтнүүдийг зүгээс онцолж байна. Тухайлбал:

- Тусгай хамгаалалт, дархан цаазат ой бүс нөлөөллийн бүсэд багтдаг учир нөхөн сэргээлт орох боломжгүй нөхцөл байдал үүсдэг.[44]
- Цэвэрлэгээний огтлолд ямар мод орж байна вэ гэдгийг мэргэжлийн бус хүмүүс шалгахаар мэддэггүй. Журмын хашаанд аваачаад хийнэ. Тэгтэл дараа нь мэргэжлийн хүмүүс үзэж хараад шаардлага хангасан модыг огтолсныг тогтоох хүртэл хугацаа их алддаг.[45]
- Ойн ашиглалтын бүс тусгай хамгаалалтын бүсэд харьяалагддаг.[46]
- Тусгай хамгаалалттай газар өөрсдөө болон ойн газраар дамжуулж хүсэлт өгдөг.[47] Ойн тухай хуулийн одоогийн хэрэгжилт бусад хуультай зөрчилдөж байна.
- Дэлхий соёлын өвийг хамгаалах тусгай хамгаалалттай газрын ажлыг хийх процесс гэж байдаггүй.
- Соёлын өв эрх зүйн хангалттай тогтоол байхгүй. Тусгай хамгаалалт газар, ойн тухай хуулиар зохицуулагдаагүй.
- Тусгай хамгаалалт хилийн асуудал, зөвшөөрөл авах процесс нь төвөгшилтэй. Манай аймгийн хувьд "Дэлхийн өв" гэсэн ойлголт байна. Газар зүйн байршил төрийн тусгай хамгаалалттай ойн сан бүхий газартай холбоотой.[48]
- Ялангуяа Төв аймагт зохион байгуулсан фокус бүлгийн ярилцлагаар тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон ойн тухай хуулийн уялдаа холбоогүй байдлаас үүдэж хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгардаг талаар дурдаж байсан бөгөөд тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаанаас нөхөн сэргээлтийг хянадаггүй, зарим газар тусгай хамгаалалттай газар нутагт хамаарах учраас нөхөн сэргэлтийг хийж чаддаггүй. Үүнээс шалтгаалан тусгай хамгаалалттай буюу хамгаалалтын бүсэд ой мод устах эрсдэл бүрдэж байгаа бөгөөд тусгай хамгаалалттай газар нутагт хамаарах ойн бүртгэл мэдээллийг тоо зөрүүтэй зэрэг асуудал тулгарч байна.

Дүгнэн үзвэл, Монгол Улсын хувьд ойг ашиглалтын болон хамгаалалтын бүс хэмээн ангилж ашиглалтын бүсийг ойн тухай хуулиар, хамгаалалтын бүсийг тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар буюу ялгаатай байдлаар зохицуулж байна. Өнөөдрийн байдлаар ойн сангийн 15,471.5 мян.га буюу 83.1 хувь нь хамгаалалтын бүсийн, 3,136.5 мян.га буюу 16.9 хувь нь ашиглалтын бүсийн ойд хамаарч байна. Энэхүү тоо мэдээнээс манай улсад хамгаалалтын бүсийн ой давамгайлдаг

[44]Сэлэнгэ аймгийн Мандал суманд 2025.08.30-ны өдөр зохион байгуулсан фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс.
[45]Мөн тэнд.
[46] Хөвсгөл аймагт 2025.09.05-ны өдөр зохион байгуулсан фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс.
[47] Булган аймагт 2025.09.04-ний өдөр зохион байгуулсан фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс.
[48] Төв аймагт 2025.09.10-ны өдөр зохион байгуулсан фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс.

болохыг харж болохоор байна. Гэвч хамгаалалтын бүсийг ойг хамгаалах, нөхөн сэргээх, цэвэрлэгээ хийх, цаашлаад хамгаалалтын бүсийн ойд нэгдсэн тоо бүртгэлийг гаргахад хүндрэл тулгарч байна.

3.3.“Бусад үр дагавар” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Ойн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан ойд хориглох үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтын хэрэгжилт, тулгамдаж буй асуудал

Ойн тухай хуулийн 29 дүгээр зүйлд “Ойд хориглох үйл ажиллагаа”-г дараах байдлаар хуульчилжээ.

29.1.Ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг хангах, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс ойг хамгаалах зорилгоор дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

29.1.1.насны тавдугаар анги хүртэлх ой, бүх төрлийн өсвөр мод, түүнчлэн жодоо, яшил, заг, тоорой, жигд, яргай, сухай, гандигар, тэс болон чацаргана, мойл зэрэг бүх төрлийн жимсний мод, бутыг огтлох, хугалж гэмтээх;

29.1.2.төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр ойгоос хуш, гацуур, нарсыг бэлтгэх, ашиглах;

29.1.3.ойг хавтгайруулан огтлох аргаар мод бэлтгэх;

29.1.4. ойн сан бүхий газарт зөвшөөрөлгүйгээр өвс хадах;

29.1.5.ойжуулсан, ойн үр бэлтгэх зориулалтаар тусгаарласан болон тарьц, суулгац ургуулсан мод үржүүлгийн талбайд мод бэлтгэх, мал бэлчээх;

29.1.6.энэ хуулийн 14.1, 14.2-т заасан эрх бүхий байгууллагатай зөвшилцөхгүйгээр эзэмшлийн ойд мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах зэрэг үйл ажиллагаа явуулах;

29.1.7.иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага зохих зөвшөөрөлгүйгээр ойгоос мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах, ан агнах, түймрийн аюултай үед зохих зөвшөөрөлгүйгээр аялал, зугаалгаар явах;

29.1.8.байгалийн ойгоос зулзаган модыг түймрээс хамгаалах халз зурвас, эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвас гаргахаар төлөвлөсөн болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордтой давхацсан ойн сангийн талбайгаас аймаг, нийслэлийн байгаль орчны газрын зөвшөөрснөөс бусад тохиолдолд шилжүүлэн суулгах;

29.1.9.барилга байгууламж барих, шинэчлэх, өргөтгөх, засварлах ажилд барилгын хэв хашмалын тулаасны зориулалтаар бөөрөнхий мод ашиглах;

29.1.10.ойн сангийн газарт улсын тусгай хэрэгцээний болон ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэхээс бусад зориулалтаар барилга байгууламж барих, аливаа объект байрлуулах;

29.1.11.мод, сөөг нутагшуулах, тарималжуулахаар хийж байгаа туршилт, судалгааны ажлаас бусад тохиолдолд мод, сөөгний тарьц, суулгац импортлох.

Тус хуульд ойд хориглох үйл ажиллагаа дээрх байдлаар тусгасан боловч тухайн зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хэн, хэрхэн, ямар хариуцлага хүлээлгэх талаар тодорхой тусгаагүй байна. Мөн тухайн зохицуулалтын хэрэгжилтэд хэн хяналт тавих, асуудал, зөрчлийг хэрхэн тогтоох, шийдвэрлэх талаар хуульчлаагүй нь тухайн зохицуулалтын хэрэгжилт хангагдахгүй байхад нөлөөлж байна.

Нөгөөтээгүүр, хууль зөрчсөн, зөрчөөгүй этгээдийн хувьд ижил нөхцөл байдалтай буюу хууль зөрчсөн ч ямар ч хариуцлага хүлээлгэхгүй байгаа нь хориглолт бодитоор үйлчлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал, ойжуулсан, ойн үр бэлтгэх зориулалтаар тусгаарласан болон тарьц, суулгац ургуулсан мод үржүүлгийн талбайд мод бэлтгэх, мал бэлчээх, ойн сан бүхий газарт зөвшөөрөлгүйгээр өвс хадахыг хориглосон гэж заасан боловч практикт энэхүү зохицуулалт огт хэрэгждэггүй бөгөөд тус зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэдэггүй байна.

Хэдийгээр Ойн тухай хуулийн 47 дугаар зүйлд хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын талаар тусгасан нь энэ нь тус хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасан “хориглосон” зохицуулалтыг зөрчсөн

тохиолдолд шууд утгаараа хамаарахгүй байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлд заасан "Хууль бусаар мод бэлтгэх", 24.7 дугаар зүйлд заасан "Ой, хээрийн түймэр тавих" гэмт хэрэг хувьд тус хуульд заасан тус гэмт хэргийн гэмт хэргийн шинжийг хангасан байхыг шаарддаг.

Харин Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлд заасан "Ойн тухай хууль зөрчих" зөрчлийн тухайд Ойн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан ойд хориглох үйл ажиллагаатай холбоотой зарим зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэж болохоор харагдаж байгаа ч практикт ОтХ-ийн 29 дүгээр зүйлд заасан зохицуулалтыг бүхэлд нь хамааруулж зөрчил үйлдсэнд тооцдоггүй байна.

Нөгөөтээгүүр Ойн тухай 29 дүгээр зүйлийн 29.1-д заасан хориглосон зохицуулалтыг зөрчсөний улмаас хариуцлага хүлээлгэж байгаа бус Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан гэмт хэрэг, зөрчлийн шинжийг агуулсан үйлдэлд нь хариуцлага хүлээлгэж байна.

Иймд Ойн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасан ойд хориглох үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт нь практикт бүрэн хэрэгжихгүй байна. Энэ нь тухайн хориглосон зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага тодорхойгүй байгаатай холбоотой гэж үзэж болох юм.

Түүнчлэн, тус хуульд заасан энэхүү хориглосон зохицуулалт нь зарим талаар хэт явцуу зохицуулалт болохыг зарим судалгаанд дурдсан байдаг. Тухайлбал, судалгаагаар[49] "*...Ойн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-т ойг хавтгайруулан огтлох аргаар мод бэлтгэхийг хориглоно гэж заасан нь ман хүнд хязгаарлалт юм. Учир нь онцгой, тодорхой нөхцөлд хавтгайруулан огтлолт хийх нь шинэ ойтой болох хамгийн сайн арга байх боломжтой... мөн зүйлийн 29.1.9-д барилга байгууламж барих, шинэчлэх, өргөтгөх, засварлах ажилд барилгын хэв хашмалын тулаасны зориулалтаар бөөрөнхий мод ашиглах гэж заасан нь барилгын ажилд орон нутгийн мод ашиглахыг зөвшөөрөхгүй гэсэн нэлээд хатуу хязгаарлалт юм. Орон нутгийн модны хэрэглээний нэг хэсэг болгон ашиглахыг зөвшөөрч болно...*" гэж үзжээ. Иймд тус хуульд заасан хориглосон үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг практикт хэрэгжих боломжийг бүрдүүлэхийн тулд хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох, мөн хатуу хориглосон хэм хэмжээг боломжит байдлаар өөрчлөн хуульчлах нь зүйтэй.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Ойн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан ашиглалтын ойн асуудал

Монгол Улсын ойн сангийн талбай 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 18,608.0 мян.га байна. Энэ нь Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 11.9 хувийг эзэлж байна. Ойн сангийн талбайг төлөв байдлын хувьд ойн талбай, ойн бус талбай гэж 2 ангилах ба ойн талбайг дотор нь ойгоор бүрхэгдсэн талбай, ойгоор бүрхэгдээгүй талбай гэж ангилна. Тухайн газар нутгийн ойрхог чанарыг тогтоохдоо ойгоор бүрхэгдсэн талбайгаар тооцож үнэлдэг. Монгол орны ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбай (улсын хэмжээний ойрхог чанар) нь нийт газар нутгийн 7.96 хувийг эзэлж байна. Монгол Улсын ойн сангийн талбайн 84.9 хувийг навч, шилмүүст ой, 15.1 хувийг заган ой эзэлнэ.

[49] ТТ-9899 МОН: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр, Боть 2: Салбарын шинэчлэлийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр, 371 дэх тал.

Зураг 14. Монгол Улсын ойн сан /2020 оны байдлаар/[50]



Монгол орны ойн нөөц 1,248,642,118 шоо.метр байна. Ойн нөөцийн 79.2 хувийг шинэс, 4.9 хувийг нарс, 8.9 хувийг хуш, 0.23 хувийг гацуур, 0.01 хувийг жодоо, 5.9 хувийг хус, 0.18 хувийг улиас, 0.05 хувийг улиангар, 0.01 хувийг хайлаас, 0.28 хувийг бургас, 0.002 хувийг тоорой, 0.15 хувийг заган ойн нөөц эзэлнэ.

Зураг 15. Монгол орны ойн сангийн талбай /талбай-мянган га/ /2020 оны байдлаар/[51]

Аймгийн нэр	Ойгоор бүрхэгдсэн			Дүн	Ойгоор бүрхэгдээгүй							Дүн	Ойн талбайн Дүн	Ойн бус талбайн ДҮН	Бүх талбай
	Байгалийн ой	Сөөг торлог	Таримал ой		Тармаг мод	Шатсан талбай	МБ талбай	Ойжих талбай	Ойжуулсан талбай	хшөн талбай	СЦУ талбай				
Аймаг тус бүрийн газрын төрлийн нэгтгэл (шилмүүст, навчит)															
Архангай	852671	8034	-	860705	58166	61518	24102	11319	-	27902	-	183007	1043712	16285	1059997
Баян-Өлгий	96616	5038	-	101654	37564	96	125	45	-	-	-	37830	139484	-	139484
Баянхонгор	29795	65	-	29860	2443	327	-	844	-	-	-	3614	33474	89	33563
Булган	1343859	66880	210	1410949	118537	212214	26244	11969	1355	20625	-	390944	1801893	120312	1922205
Говь-Алтай	8980	-	-	8980	1407	-	-	6	-	-	-	1413	10393	63	10456
Говьсүмбэр	38	-	-	38	7	-	-	-	-	-	-	7	45	-	45
Дорнод	75396	15508	56	90960	28551	114864	1461	3072	257	0	-	148205	239165	4931	244096
Завхан	458490	43466	2	501958	43237	133102	10522	17984	0	1148	-	205993	707951	25951	733902
Өвөрхангай	144263	364	-	144627	14669	1698	4587	727	198	6748	-	28627	173254	2699	175953
Өмнөговь	142	-	-	142	-	-	-	-	-	-	-	-	142	-	142
Сүхбаатар	635	1583	-	2218	13445	-	-	-	1	-	-	13446	15664	-	15664
Сэлэнгэ	1419319	41874	7190	1468383	108706	226260	31717	20685	20301	331	457	408457	1876840	71132	1947972
Төв	957183	137857	142	1095182	49988	148517	7048	7133	1665	5645	-	219996	1315178	73021	1388199
Увс	197347	3552	30	200929	26678	2042	1971	629	-	26	-	31346	232275	4354	236629
Ховд	12394	-	-	12394	3578	-	-	-	-		-	3578	15972	20	15992
Хөвсгөл	3153151	123367	22	3276540	180851	352659	11333	15887	472	30670	-	591872	3868412	144152	4012564
Хэнтий	989733	186195	159	1176087	120166	391152	3411	11373	244	2638	-	528984	1705071	49666	1754737
Дархан-Уул	64805	1292	79	66176	7152	716	301	3114	0	15	-	11298	77474	4523	81997
Улаанбаатар	90647	4573	13	95233	4812	959	5756	1357	975	3685	-	17544	112777	3480	116257
Орхон	15851	-	-	15851	707	161	478	-	374	78	-	1798	17649	882	18531
Дорноговь	12	-	-	12	112	-	-	-	-	-	-	112	124	-	124
дүн	**9911327**	**639648**	**7903**	**10558878**	**820776**	**1646285**	**129056**	**106144**	**25842**	**99511**	**457**	**2828071**	**13386949**	**521560**	**13908509**
Ойрхог чанар (навчит шилмүүст)				6.75%	Ойн сангийн талбайг Монгол улсын нийт газар нутгийн хэмжээтэй харьцуулсан хувь										8.9%

Монгол орны ойг бүрдүүлэгч моддоос зонхилон тархсан нь шинэс бөгөөд байгалийн ойн талбайн 63.0 хувьд тархан ургаж байна. Шинэсэн ой нь Хөвсгөл аймагт хамгийн их буюу 2,975,465 га талбайд тархан ургаж байна.

[50]БОАЖЯ, Ойн судалгаа, хөгжлийн төв," Монгол Улсын ойн сан".
[51]БОАЖЯ, Ойн судалгаа, хөгжлийн төв," Монгол Улсын ойн сан", (Уб, 2021).

Зураг 16. Ойн сангийн байгалийн ойн талбай модны төрлөөр, талбай- га (2020 оны байдлаар)[52]

№	Аймаг	Модны төрөл														ДҮН
		шинэс	нарс	хуш	гацуур	жодоо	хус	улиас	улиангар	хайлаас	бургас	Навчит, шилмүүст модны дүн	Тоор ой	заг	Заг, тооройн дүн	
1	Архангай	824 577		13 102			2 185	3 618	131	35	9 023	**852 671**			-	**852 671**
2	Баян-Өлгий	84 727		256	441		83	1 921			9 188	**96 616**			-	**96 616**
3	Булган	1 030 951	31 037	17 665	257		245 476	1 011	190	1 870	15 402	**1 343 859**			-	**1 343 859**
4	Баянхонгор	29 534						94	29		138	**29 795**	514	508 978	**509 492**	**539 287**
5	Говь-Алтай	8 952						13			15	**8 980**	5	461 678	**461 683**	**470 663**
6	Говьсүмбэр										38	**38**				**38**
7	Дорнод	6 967	21 866				25 799	102	620		20 042	**75 396**			-	**75 396**
8	Төв	519 944	88 493	242 256	2 958		94 276	1 958	2 015		5 283	**957 183**			-	**957 183**
9	Хэнтий	696 232	45 043	66 752	39		154 815	8 800	1 383	74	16 595	**989 733**			-	**989 733**
10	Завхан	441 314		2 075	4 978		199	260	12		9 652	**458 490**			-	**458 490**
11	Увс	141 357		1 527	330		1 315	11 140			41 678	**197 347**			-	**197 347**
12	Сэлэнгэ	403567	293297	146269	5948	1045	535886	2605	8200	484	22018	**1419319**			-	**1 419 319**
13	Өвөрхангай	121 668		20 404			2 117		2		72	**144 263**		68 523	**68 523**	**212 786**
14	Хөвсгөл	2 975 465	2 204	86 099	4 694	36	71 215	2 492	251	127	10 568	**3 153 151**			-	**3 153 151**
15	Орхон	14 344					1 507					**15 851**			-	**15 851**
16	Улаанбаатар	50 126	11 315	16 520	1 442		6 871	1 939	30		2 404	**90 647**			-	**90 647**
17	Дархан-Уул		11 813				51 016		1 135	5	836	**64 805**			-	**64 805**
18	Сүхбаатар									143	492	**635**			-	**635**
19	Дундговь											-		16 793	**16 793**	**16 793**
20	Дорноговь										12	**12**	5	54 694	**54 699**	**54 711**
21	Өмнөговь									142		**142**	220	604 388	**604 608**	**604 750**
22	Ховд	5 024					1 372	39			5 959	**12 394**		47 313	**47 313**	**59 707**
	ДҮН	7354749	505068	612925	21087	1081	1194132	35992	13998	2880	169415	**9911327**	744	1 762 367	**1 763 111**	**11 674 438**
Модны төрлийн эзлэх%		63.00	4.33	5.25	0.18	0.01	10.23	0.31	0.12	0.02	1.45	**84.90**	0.01	15.10	**15.10**	**100.00**

Хүснэгт 12. Ойн ашиглалтын тайлан /ОМ-4-3/[53]

№	Аймаг	Ойгоос бэлтгэсэн хэрэглээний модны хэмжээ, м3
1	Дархан Уул	
2	Дорнод	283.00
3	Завхан	5,209.90
4	Орхон	93.00
5	Сэлэнгэ	19,425.00
6	Увс	685.00
7	Хөвсгөл	22,843.40
Нийт		48,539.30

Зураг 17. Хөвсгөл, Сэлэнгэ аймгийн ойн нөөц ба түүний орлогын эзлэх хувийн харьцуулалт (2023 оны байдлаар)



Ойн нөөцийн ашиглалтын тухайд дээрх байдлаар Сэлэнгэ болон Хөвсгөл аймгийн ойн нөөцийн хэмжээ харьцангуй өөр ч бэлтгэсэн модны хэмжээ, төлбөрийн орлого нь ижил байгаа нь ойг

[52] Мөн тэнд.
[53] Ойн нөөцийн мэдээллийн сан, https://eic.mn/forestresource/statistics.php?id=6

ашиглахдаа орон зайн хамаарал буюу төв эсхүл алслагдсан газарт байгаа эсэхээс хамаарч байна. Энэ асуудлыг шийдвэрлэх арга зам, зөвлөмжийг судалгааны тайлан, олон улсын байгууллагын зөвлөмжид тусгажээ. Тодруулбал, Алслагдсан бүс нутагт концессын гэрээ байгуулах, ОТМ-ийг хэрэгжүүлэх замаар ойн салбарын эдийн засгийн хөгжлийг дэмжих: Алслагдсан бүс нутагт концессын гэрээг томоохон аж ахуйн нэгжүүдийн дунд нээлттэй тендер хэлбэрээр явуулахыг зөвшөөрөх. Ойн салбар дахь ОТМ-ын туршлагыг сурталчлах, эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор дараах ажлуудыг хийж болно. Үүнд:

-Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгад ойн баялгийг концессын гэрээгээр эзэмшүүлэх заалтуудыг тусгаж, эдгээр гэрээг хэрхэн олгох талаар тодорхой зааврыг тогтоох.

-Ойн сан бүхий газрын гэрээгээр эзэмшүүлэх журмыг ОТМ-ийн замын зураглалын дагуу шинэчлэн, концессын гэрээг ил тод, өрсөлдөөнтэй явуулах нөхцөлийг хангах.

-2024-2030 он хүртэл 30 мянгаас доошгүй га талбайг 10 орчим томоохон аж ахуйн нэгжид концессоор эзэмшүүлэх зорилт тавьж, эдгээр концессын менежментийг ОТМ-ийн зарчимд нийцүүлэх.

-ОТМ-ийн зорилтод хүрэх ахиц дэвшлийг хянах, концессын гэрээ нь аж үйлдвэр, байгаль орчны аль алиных нь хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах найдвартай хяналт, үнэлгээний тогтолцоог бий болгох.[54]

Мөн ойн нөөц ашиглалттай холбоотой дараах шинэчлэлт, өөрчлөлтүүдийг хийх нь зүйтэй. Үүнд:

- Ойн нөөцийн ашиглагч талуудыг тодорхой болгох, бэхжүүлэх, ашиглалтыг нэмэгдүүлэх: Ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ойн нөөц ашиглалтыг үндсэндээ мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлүүд хийх ёстой. Гэхдээ аль түвшинд ямар ашиглалт хийх нь өөр өөр байж болно. Ойн тооллогын дүн мэдээгээр, ойд ашиглах боломжтой модны нөөц хангалттай байна. Иймээс эдгээр оролцогч талуудын эрх, үүргийг тодорхой болгож, ялангуяа эрх зүйн болон зах зээлийн таатай орчныг бүрдүүлэх замаар чадавхыг бэхжүүлэх шаардлагатай (Ойн мэргэжлийн байгууллагын хувьд хувийн хэвшлийг дэмжих бодлогын зөвлөмжийг үзнэ үү). Ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллага нь ялгаатай статустай боловч одоогийн хуульд эрх, үүрэг ойролцоо байдлаар дурдсан байдаг. Цаашдаа хуульд тэдгээрийн үүрэг хариуцлага, эрхийг салгаж, ерөнхийд нь тусгах нь зүйтэй бөгөөд нарийвчилсан зохицуулалтыг журам, дүрэмд тусгаж болно.[55]
- Ойн нөөцийн тогтвортой ашиглалтын босго тогтоох: Ойд нэмэгдэж байгаа ойн нөөцийн хэмжээнээс илүүгүй мод бэлтгэхийн тулд бодит хэмжилт, хяналтад үндэслэн тодорхой босго тогтоох нь нэн чухал юм. Энэ нь ойн аж ахуйн оролцогч талуудад мөрдлөг болж, нөөцөөс давсан ашиглалт явуулахыг бүрэн хязгаарлана. Мөн ойн нөөцийн өсөлтийн хүснэгт, өсөлтийн загваруудын үнэн зөв, найдвартай байдлыг сайжруулах, чанартай мэдээллийг цуглуулах, хуваалцах тал дээр тодорхой болгох шаардлагатай.[56]
- Монгол Улсын ойн аж ахуйн бодлогод ойн үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлогын зорилтууд хоорондоо зөрчилдөж байгаа ба энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд Ойн тухай хуульд нэмэлт оруулах шаардлагатай байгаа. Үүнд: i) Мод бэлтгэх квотыг бууруулж, үндэсний модыг

[54] ADB, FCG Финляндын зөвлөх групп, Монголын ой судлалын нийгэмлэг, TT-9899 MOH: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр боть 2: Салбарын шинэчлэлийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, (Уб, 2023), 51-52 дахь тал.
[55] Мөн тэнд, 44 дэх тал.
[56] Мөн тэнд 46 дахь тал.

импортоор солих бодлогын зорилтууд хоорондоо зөрчилдөж байна. 3.1.5 Төрөөс ойн талаар баримтлах бодлого - хүчингүй болсон. ii) Тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор ашиглалтын ойд ойн замын сүлжээг хөгжүүлэх (3.3.3-ыг үзнэ үү). REDD+ NSAP-ийг Монгол Улсад мөрдөгдөж буй ОТМ-ийн 3.2.8-д үндэслэн боловсруулсан. Одоогийн өргөн мэдүүлсэн Байгаль орчны зорилтот хөтөлбөрийн төсөлд REDD+ NSAP (Үйл ажиллагааны 2.2.1-ийг үзнэ үү) багтсан бөгөөд энэ нь ойн ашиглалт, бэлтгэл, боловсруулалтыг ОТМ, ашиглалтын зарчимд тулгуурлан сайжруулах санааг дэмжиж байна. Үүнээс үзэхэд Ойн тухай хуульд ойн үйлдвэрлэлтэй холбоотой хэсэг байх шаардлагатай. Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгад ойн үйлдвэрлэлийн хэсгийг тусгахын тулд дараах хэрэгжүүлэх арга замыг баримталж болно.

- Ойн үйлдвэрлэлийг амжилттай хэрэгжүүлж буй бусад улс орныг судалж, тэдний сайн туршлагыг үндэсний ойн бодлогод тусгах.
- Ойн үйлдвэрлэлийг дэмжих шаардлагыг боловсруулж, ойн тогтвортой үйл ажиллагааг хангах үүднээс хууль эрх зүйн хүрээнд тусгаж өгөх.
- Ойн үйлдвэрлэл эрхлэхийг хариуцсан байгууллагууд болох ой эзэмшигч, мод бэлтгэгч, боловсруулах аж ахуйн нэгжийн эрх, үүргийг тодорхойлох.
- Санал болгож буй өөрчлөлтийн талаарх санал, сэтгэгдлийг нэгтгэх зорилгоор оролцогч талуудтай олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулах.[57]

Ойн үйлдвэрлэлийн хэрэгцээг хангах үүднээс Ойн тухай хуулийн зохицуулалтыг сайжруулж, мөн ОТМ-ийг хэрэгжүүлэхэд гаргасан зөвлөмжүүд: Үйлдвэрлэлийн болон байгаль орчны аль алиных нь хэрэгцээг хангах ойн үйлдвэрлэлийн хэсгийг багтаан Ойн тухай хуулийн эцсийн үзэл баримтлал, шинэчилсэн найруулгыг батлах. Мод бэлтгэх зөвшөөрлийг квотоор олгодог тогтолцоог халж, ашиглалтын ойн сан бүхий газарт ойн нөөцийг гэрээгээр гүйцэтгүүлэх замаар мод бэлтгэх ажлыг эрчимжүүлэхийн тулд ОТМ-ийг хэрэгжүүлэхдээ дараах ажлуудыг хийж болно.

- ОТМ-ийн туршлагыг сурталчлах, засаглалыг бэхжүүлэх, ойн эзэмшлийн үр өгөөжийг тэгш хүртэх зорилгоор орон нутгийн иргэд болон бусад оролцогч талуудтай түншлэлийн харилцааг хөгжүүлэх.
- Ойн тогтвортой менежментийг дэмжих, мод бэлтгэх зөвшөөрөл, квотын өөр аргуудыг ашиглахыг дэмжсэн хууль эрх зүйн зохицуулалтын шинэ тогтолцоог боловсруулах.
- Ой эзэмшигчид, мод бэлтгэгчид, боловсруулах аж ахуйн нэгжүүдэд мэдлэг олгох, сургах, техникийн дэмжлэг үзүүлэх замаар ОТМ-ын туршлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
- ОМБ-дад ойн нөөцийг гэрээгээр эзэмшүүлэх ажлыг эрчимжүүлж, эдгээр газруудын ойн менежментийн тодорхой удирдамжийг бий болгох.
- Зорилгодоо хүрч байгаа эсэхийг хянаж, баталгаажуулахын тулд ОТМ-ийн практик болон шинэ хууль эрх зүйн зохицуулалтын нөлөөллийг хянаж, үнэлэх.[58]

Монгол Улсын хувьд Ойн тухай хууль нь ойн сангийн ангилал, ашиглалтын үндсэн чиглэл, иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгжийн оролцоог ерөнхий түвшинд зохицуулсан байдаг. Гэхдээ ойн ашиглалтын төрөл, хамгаалалтын бүсийн ангилал, зөвшөөрөл, лицензийн журам, мод бэлтгэлийн ангилал, нөхцөл зэрэг нарийн зохицуулалт хангалтгүй, бодит байдал дээр олон ойлгомжгүй байдал, зөрчил, хууль зөрчсөн нөхцөл үүсэх эрсдэл байсаар байна. Тухайлбал, ойн хоёрдогч нөөц ашиглалт, малын хашаа, аялал жуулчлалын ашиглалт гэх мэт чиглэлд тодорхой журам, зөвшөөрөл, нөхцөл

[57] ADB, FCG Финляндын зөвлөх групп, Монголын ой судлалын нийгэмлэг, TT-9899 MOH: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр боть 2: Салбарын шинэчлэлийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, (Уб, 2023), 50 дахь тал.
[58]Мөн тэнд, 51 дэх тал.

заагаагүй, эсвэл хэт ерөнхий байгаа нь байгаль орчинд хохирол учруулах, менежмент сулрах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. Ойн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтад заасан зам, дэд бүтэцтэй холбоотой зохицуулалтад тулгамдаж буй асуудал

Ойн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт болон 12.2 дахь хэсэгт зааснаар ойн зам барих талаар дараах зохицуулалтыг тусгасан байна.

- Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ойн нөөц бүхий газар нутгийн ашиглалтын бүсийн ойд замын хайгуул хийж, зураг, төсөв боловсруулах, ойн төв зам барьж байгуулах арга хэмжээний зардлыг тухайн жилийн төсөвт тусгах;

- Засгийн газар нь ойгоос мод бэлтгэх, ойн зам барих, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох тарьц, суулгац үржүүлэх асуудлыг хариуцах чиг үүрэг бүхий төрийн өмчит хуулийн этгээд байгуулж болно.

Энэхүү зохицуулалт нь хуульд хэт ерөнхий байдлаар тусгагдсанаас үүдэн практикт олон асуудал үүсэж байна. Тодруулбал,

- Ойн нөөцийн 60 орчим хувь нь ойн гүндээ байдаг. Сүүлийн 30 гаруй жил ойн зам барьж байгуулаагүй, ойн замын сүлжээ байхгүй тул ойн түймэр, ойн хортонтой тэмцэх, аялал жуулчлал хөгжүүлэх, ашиглалт явуулах боломжгүй байна. Ойн мэргэжлийн байгууллагууд ойн зам гүйгээс ойн зах талбайгаас ойрхон давтамжтайгаар мод бэлтгэж ашиглаж ойн чанарыг эрс доройтуулж байна. Иймд ойн замыг засварлах, шинээр байгуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Зам тавих асуудлыг Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас шийдэх ёстой гэж БОУАӨЯ үздэг. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас ойн замтай холбоотой зардлыг жил бүрийн төсөвт тусгах санал гаргадаг ч Сангийн яам дэмждэггүй хасдаг байна. Гурван яамны дунд энэхүү чухал заалт хэрэгждэггүй.[59]

- ОМБ-ууд бэлтгэсэн модоо дунджаар 80 км зайд, харьцангуй бартаатай замаар тээвэрлэж, зүсэх газраа авчирч байна. Сүүлийн 30 гаруй жил ойн зам тавиагүй учраас ойн захад мод огтолж, ойн санг доройтуулж байна. Ойн хуулийн 12.1.4-т "ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ойн нөөц бүхий газар нутгийн ашиглалтын бүсийн ойд замын хайгуул хийж, зураг, төсөв боловсруулах, ойн төв зам барьж байгуулах арга хэмжээний зардлыг тухайн жилийн төсөвт тусгах;" гэж заасан. Гэвч сүүлийн 30 гаруй жил нэг ч километр ойн зам бариагүйгээс шалтгаалан аж ахуйн нэгжүүд ойн зах хэсгээс мод бэлтгэдэг нь ойн экологид сөрөг нөлөө үзүүлж байна.[60]

- Монгол орны ойн нөөц ашиглалтгүй, нөөц хомс, үйлдвэрлэлийн ой нь болц гүйцсэн хөгшин ой давамгайлсан, унанги мод ихтэй. Эдгээр дүгнэлтээс харахад Монгол Улс ойн салбартаа олон жил хөрөнгө оруулалт хийгээгүй, ойгоо ашиглахгүй байгааг, зөв менежмент хийвэл эдийн засгийн чадавхтай болохыг харуулж байна. Мөн **ойн талбайн хүрэлцээ муу, ойн дэд бүтэц, ойн зам байхгүй байгаа нь ойг дутуу ашиглахад нөлөөлж байгаа ч одоогоор энэ тал дээр нарийн тоон судалгаа, мэдээлэл байхгүй байна.**[61]

---

[59] TT-9899 MON: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсын Ойн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид хийсэн дүн шинжилгээ, (Уб, 2023).

[60] TA-9899: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр зах зээл ба өртгийн сүлжээний шинжилгээ, (Уб, 2023).

[61] TA-9899 MON Ойн Салбарын Хөгжлийн Хөтөлбөр: 2-р боть: Салбарын шинэчлэлийн стратеги, Үйл ажиллагааны төлөвлөгөө Хавсралт А3: Ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх замын зураг, (Уб, 2023)

- Ойн зам, агуулахын талбай (гол зам эсвэл төмөр замтай), ОТМ-д суурилсан ойн менежментийн загвар эсвэл туршилтын талбай гэх мэт дэд бүтцийг сайжруулах хэрэгцээ их байна.[62]

Мөн судалгааны хүрээнд фокус бүлгийн ярилцлага хийсэн бөгөөд тус ярилцлагын үр дүнгээс үзвэл:

Шигтгээ 4.

"Ойн замын асуудал хүндрэлтэй тулгардаг. Сүүлийн жилүүдэд замын асуудлыг шийдэх шийдэл, төлөвлөгөө огт яригдаагүй. Үүнээс болж ойн гүнд ажиллахад хүндрэлтэй нөхцөл байдал үүсдэг.

Хөвсгөл аймгийн Ойн ангийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлийн хэсгээс..."

Шигтгээ 5.

" Ойн зам гэсэн ойлголт байдаггүй. Тиймээс ойг бүрэн ашиглах, бүтцийг зөв тодорхойлж чаддаггүй..."

Булган аймгийн Ойн ангийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлийн хэсгээс..."

Дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд ойн нөөцийн ашиглалт, ойн замын хөгжлийн төлөвлөгөө, ойн замын нягтрал, эдийн засаг, экологи, нийгмийн судалгаа, тооцоонд тулгуурлан ойн зам барих төслийг хэрэгжүүлэх, ойн нөөцийн хүртээмжийг сайжруулахын тулд дараах арга хэмжээг авч болно. Үүнд:

✓ Одоо байгаа ойн замуудын судалгааг гаргаж, нөхцөл байдлыг нь үнэлж, арчилгаа, тохижилтын төсөв боловсруулах.

✓ Ойн замын сүлжээний нягтралыг судалж, эдийн засаг, экологи, нийгмийн судалгаа хийж, ойн замын оновчтой хуваарилалт, холбогдох төсвийг тогтоох.

✓ Ойн үйлдвэрлэл, ойн тогтвортой менежментийг бий болгох өндөр боломж бүхий бүс нутгийг эрэмбэлэн ойн шинэ зам барих ажлыг төлөвлөх.

✓ Ойн сан бүхий авто зам барих хөрөнгийг жил бүрийн улсын төсөв, төлөвлөгөөнд тусгах зорилгоор БОУАӨЯ, ХХААХҮЯ, Сангийн яам хооронд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах.

✓ Ойн нөөцийн өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан ойн замын сүлжээний төслүүдийг шинэчлэх.

✓ Ойн зам барих ажлыг хувийн хөрөнгөөр концессын гэрээгээр хэрэгжүүлэх, бүтээн байгуулалтыг нийгэм, байгаль орчин, эдийн засгийн хувьд тогтвортой байлгах.

✓ Эхний ээлжид 2040 он гэхэд Хөвсгөл, Сэлэнгэ, Булган аймагт 170 км ойн зам тавьж, ойн үйлдвэрлэл, ойн тогтвортой менежментийг бий болгох өндөр боломж бүхий бүс нутгийг нэн тэргүүнд тавих.[63]

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4. Ойн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан ойн нөхөрлөлийн чиг үүрэг бусад байгууллагын чиг үүрэгтэй давхардаж буй эсэх

Ойн тухай хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар ойн нөхөрлөл нь ойн сангийн тодорхой хэсгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх ойн менежментийн төлөвлөгөөтэй байх ба өөрсдийн дүрэмтэй байна. Мөн ойн нөхөрлөл нь сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ойн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагааныхаа хөтөлбөр, ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг жил бүр тавина. Үүнээс гадна ойн нөхөрлөл нь дараах эрхийг эдлэхээр хуульд тусгагдсан. Үүнд:

[62] Мөн тэнд.

[63] ТТ-9899 МОН: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр боть 2: Салбарын шинэчлэлийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө Төгсгөлийн тайлан, (Уб, 2023)

- Эзэмшлийн газартаа ойн менежментийн төлөвлөгөөний дагуу хийгдэх үйл ажиллагааг тасралтгүй явуулах;
- Эзэмшлийн газраасаа ойн менежментийн төлөвлөгөө, эрхийн бичгийн дагуу бэлтгэсэн мод, ойн дагалт баялгийг ашиглах, хэрэгцээнээс илүү гарсан мод, ойн дагалт баялгийг худалдан борлуулах;
- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх ойн аж ахуйн арга хэмжээний төсөл, хөтөлбөр боловсруулах, санал өгөх, уралдаант шалгаруулалтад оролцох;
- Ойн менежментийн талаар явуулах сургалт, семинар, мэргэжил олгох, давтан сургах үйл ажиллагаанд хамрагдах.

Мөн ойн нөхөрлөл энэ хуульд заасан үүргийг биелүүлэхийн зэрэгцээ тухайн шатны Засаг даргатай байгуулсан гэрээнд заасан үйл ажиллагааг явуулна.

Дээрх байдлаар ойн нөхөрлөлийн чиг үүргийг хуульд заасан нийтлэг үүрэг болон тодорхой хэсгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх ерөнхий үүрэгтэй гэх байдлаар ерөнхий зохицуулсан.

Одоогийн байдлаар ойн нөхөрлөлүүдийн чадавхыг авч үзвэл:

Зураг 18. Ойн нөхөрлөлийн чадавхын ерөнхий үнэлгээ[64]



Зураг 19. Ойн нөхөрлөлийн менежментийн чадавх

[64] ТА-9899 МОН: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр /Ойн нөхөрлөлүүдэд хийсэн үнэлгээ/, (Уб, 2023)

Үүнээс нийтлэг бэрхшээл нь ашиглалт байхгүй, эргүүл хамгааллын зардал их, орон нутгийн удирдлагуудын дэмжлэг сул, гишүүдийн идэвх суларсан, Ойжуулалтын тендерт оролцож чаддаггүй, ургуулсан тарьц суургацаа борлуулж чаддаггүй, тоног төхөөрөмж дутмаг гэдэг нь тодорхойлогдсон.

Мөн Ойн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан ойн мэргэжлийн байгууллагын чиг үүрэг нь ойн нөхөрлөлийнхтэй ойролцоо байгаа нь чиг үүргийн давхардлыг бий болгож байна. Тодруулбал, Ойн мэргэжлийн байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр байна. Үүнд:

- Ойн баялгийн нөөцийг хамгаалах ажлыг хэрэгжүүлэх;
- Ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшиж ойг зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх ажлыг гүйцэтгэх, эрх олгосон тохиолдолд нөлөөллийн үнэлгээ хийх;
- Ойг нөхөн сэргээх, үржүүлэх үйл ажиллагаа явуулахаас гадна бусад байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт явуулах, төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх;
- Өөрийн гүйцэтгэсэн ажлын үнэн зөвийг хариуцаж, үйл ажиллагааныхаа талаар төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах;

Дээрх давхардлыг олон улсын байгууллагын тайланд дараах байдлаар авч үзсэн.

Ойн нөөцийн ашиглагч талуудыг тодорхой болгох, бэхжүүлэх, ашиглалтыг нэмэгдүүлэх: Ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ойн нөөц ашиглалтыг үндсэндээ мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлүүд хийх ёстой. Гэхдээ аль түвшинд ямар ашиглалт хийх нь өөр өөр байж болно. Сүүлийн ойн тооллогын дүн мэдээгээр, ойд ашиглах боломжтой модны нөөц хангалттай байна. Иймээс эдгээр оролцогч талуудын эрх, үүргийг тодорхой болгож, ялангуяа эрх зүйн болон зах зээлийн таатай орчныг бүрдүүлэх замаар чадавхыг бэхжүүлэх шаардлагатай (Ойн мэргэжлийн байгууллагын хувьд хувийн хэвшлийг дэмжих бодлогын зөвлөмжийг үзнэ үү). Ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллага нь ялгаатай статустай боловч одоогийн хуульд эрх, үүрэг ойролцоо байдлаар дурдсан байдаг. Цаашдаа хуульд тэдгээрийн үүрэг хариуцлага, эрхийг салгаж, ерөнхийд нь тусгах нь зүйтэй бөгөөд нарийвчилсан зохицуулалтыг журам, дүрэмд тусгаж болно.[65]

Иймд ойн нөхөрлөлүүдийн чиг үүргийг хуульд тодорхой тусгаж мэргэжлийн байгууллага болон бусад байгууллагаас ялган тодорхойлох нь зүйтэй. Ийнхүү давхардсанаар орон нутагт давхардал, хийдэл үүсэх эрсдэлтэй байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 5. Ойн тухай хууль ба бусад хуулийн харилцан уялдаа, нийцэлтэй байгаа эсэх

Монгол Улсын Их Хурал 2012 онд Ойн тухай хуулийг баталж, дагаж мөрдөх болсон билээ. Тус хууль нь 7 бүлэг, 47 зүйлтэй бөгөөд өнөөдрийг хүртэл 13 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаар зохицуулж байна.[66]

Ойн тухай хууль нь байгаль орчны салбарын хууль тогтоомж болон бусад хууль тогтоомжтой харилцан уялдаж байдаг. Тухайлбал, БОХтХ, ТХГНтХ, МУЗЗНДНТУтХ, Газрын тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль гэх мэт. Эдгээр хуулиас дараах хуулиудтай Ойн тухай хуульд хэрхэн уялдаж байгаа талаар судлан үзсэн болно.

Ойн тухай хууль болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн харилцан уялдаа

[65] ADB, FCG Финляндын зөвлөх групп, Монголын ой судлалын нийгэмлэг, TT-9899 MOH: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр боть 2: Салбарын шинэчлэлийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, (Уб, 2023), 44-45 дахь тал.
[66] Экологийн эрх зүй гарын авлага, (Уб, 2007), 136 дахь тал.

Ойн тухай хууль нь БОХтХ-ийн дагалдах хууль болохын хувьд өөр хоорондоо уялдаж байх шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах тухай хууль нь 1995 онд батлагдсан бөгөөд нийт 37 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Тус хууль нь Ойн тухай хуультай дараах байдлаар харилцан уялдаж байна. Үүнд:

Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8-д *"Ойн нөхөрлөл" гэж Иргэний хуулийн 481.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3.2.8-д заасны дагуу зохион байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн сайн дурын байгууллагыг* ойлгохоор хуульчилжээ.

Харин Иргэний хуулийн 481 дүгээр зүйлийн 481.1-д "*Хамтран ажиллах гэрээний үндсэн дээр хэд хэдэн этгээд холбоо болон нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдаж үйл ажиллагаа явуулж болох бөгөөд ийм байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэхгүй, бүтэц, зохион байгуулалтыг гишүүд харилцан тохиролцож тодорхойлно"* гэж, БОХтХ-ийн 3 дугаар зүйлийн 3.2.8-д "*Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл" гэж /цаашид "нөхөрлөл" гэх/ нутгийн иргэдэд байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх эрхийг олгож, нөөц ашиглалтыг хамтаараа, ил тод, шударга зарчимд нийцүүлэн зохион байгуулж, түүнээс гарсан үр ашгийг иргэдэд тэнцүү хуваарилах зорилготой нөхөрлөлийг;*" ойлгоно гэж тус тус заажээ.

Дээрх зохицуулалтуудаас дүгнэвэл, Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8-д заасан ойн нөхөрлөл гэх ойлголтод БОХтХ-ийн 3 дугаар зүйлийн 3.2.8-д заасан байгалийн нөөцийн хамтын менежмент нөхөрлөл нь хамаарахаар байна. Өөрөөр хэлбэл, энэхүү хоёр ойлголт нь ижил агуулгыг илэрхийлж байна. Иймд өөр өөр нэр томьёогоор нэг ойлголтыг илэрхийлэхгүй байх нь зүйтэй.

Түүнчлэн, Ойн тухай хуульд 6 дугаар зүйлийн 6.1-д "*Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ойн төлөв байдал, ойн сангийн эзлэх талбайн хэмжээ, нөөц, бүрэлдэхүүн, үнэлгээ, тэдгээрийн өөрчлөлт, ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний талаарх цогц мэдээллийг агуулсан улсын хэмжээний ойн мэдээллийн сантай байна"* гэж заасан.

Харин БОХтХ-ийн 35 дугаар зүйлийн 35.1-д "Улсын мэдээллийн сан дараах зүйлийн талаарх мэдээллээс бүрдэнэ" гэж, 35.1.4-т "ой" гэж заажээ.

Дээрхээс дүгнэвэл, улсын мэдээллийн нэгдсэн сангийн нэг төрөл нь ойн мэдээллийн сан байна. БОХтХ-д улсын мэдээллийн нэгдсэн санд хэрхэн мэдээлэл төвлөрүүлэх талаар зохицуулсан боловч тухайн мэдээллийг цуглуулах, боловсруулах, хэрхэн хэрэглэх талаар харилцааг хангалттай тодорхой тусгаагүй байна.

Ойн тухай хууль болон Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн харилцан уялдаа

Ойн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Тусгай хамгаалалттай газар нутаг дахь ойн хамгаалалтын дэглэмийг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна" гэж заажээ.

Энэхүү зохицуулалтын дагуу тусгай хамгаалалттай газар нутаг дахь ойн хамгаалалтын асуудал нь ТХГНтХ-аар зохицуулагдаж байна. ТХГНтХ нь 1994 онд батлагдсан бөгөөд нийт 17 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.[67]

Өөрөөр хэлбэл, Ойн тухай хууль болон Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль хоорондын зөрчлийг арилгах замаар уялдаа холбоог сайжруулах шаардлага зүй ёсоор бий болжээ. Тодруулбал, Монгол орны ойн сан бүхий газрын ихэнх хэсэг нь тусгай хамгаалалттай газар нутагт хамаарах бөгөөд тухайн ойн сан бүхий газрын менежментийг хэн хариуцах нь эрх зүйн хувьд тодорхойгүй байна. Ойн мэргэжилтнүүдийг (жишээ нь ойн инженер) тусгай хамгаалалттай газрын ойн

[67] Тусгай хамгаалттай газар нутгийн тухай хууль, 1994, https://legalinfo.mn/mn/detail/479

менежментэд оролцуулах шаардлагатай. Ойн аж ахуйн арга хэмжээг хатуу хамгаалалтын дэглэмтэйгээс бусад бүсүүдэд нэмэгдүүлэх боломжтой.[68]

Учир нь тусгай хамгаалалттай газарт хамаарах ойн санд ойн аж ахуйн үйлдвэрлэлийн аливаа арга хэмжээ, үйл ажиллагаа явуулахад хязгаарлагдмал байдаг. ОН-үүдийг шинээр байгуулснаар малчидтай хамтран эргүүл хийх боломжтой болох бөгөөд ойн ашиглалт хийхдээ байгаль орчны газарт мэдэгдэж ажиллах хэрэгтэй юм. Ойн арчилгаа, цэвэрлэгээ хийх шаардлагатай байгаа бөгөөд тэдгээр хамгаалалтын бүсийн ойд ойн дагалт баялаг, бүтээгдэхүүн боловсруулж, ашиглалт хийх боломжтой.[69]

Арчилгааны ажил нь зөвхөн моддын ургалтыг нэмэгдүүлэхээс гадна ойн эрүүл ахуйн орчныг сайжруулж, түймрийн эрсдэлийг бууруулж, усны зохицуулалт, хөрс хамгаалах чадавхыг сайжруулдаг. Ашгийн бус арчилгааны ажил нь ихэнх хамгаалалтын бүсийн ойн санд зөвшөөрөгддөг бөгөөд гагцхүү тусгай хамгаалалттай газрын зарим бүсэд хориглодог байна.[70]

Ашиглалтын ойн бүсийг тусгай хамгаалалтад ихээр авч байгаагаас ашиглалт явуулах ойн нөөцгүй болсон. Үүнээс шалтгаалан иргэд түлээний модоо авахад хүндрэл тулгарч байна.

Мөн Ханхэнтийн Дархан цаазат газар болон орон нутгийн тусгай хамгаалалтад ашиглалтын бүсийн ойгоос хамруулснаас үүдэж хөгширсөн, болц гүйцсэн, өмхөрсөн модыг авах, ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл үүссэн. Энэ нь ойн сан улам доройтох шалтгаан болсон тул тусгай хамгаалалттай ойн санд ойн цэвэрлэгээ хийх эрх зүйн орныг бүрдүүлэх шаардлагатай.[71]

Түүнчлэн, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг 1994 онд баталсан бөгөөд энэ ч утгаар тус хуульд зарим шинэлэг зохицуулалт байхгүй. Тодруулбал, тус хуулиар тусгай хамгаалалттай газарт ойн дагалт баялаг, мод ашиглалт, ойн аж ахуй эрхлэх асуудлыг хамгаалалтын дэглэмтэй уялдуулж тодорхой зохицуулаагүй.[72] Энэ ч утгаараа тусгай хамгаалалтай газарт ойн дагалт баялаг, мод ашиглалттай, ойн аж ахуй эрхлэхтэй холбоотой эрх зүйн орчин тодорхойгүй байна. Тиймээс нэг бол ойн тухай хуулиар тусгай хамгаалалттай газар нутаг дахь ойн асуудлыг шийдвэрлэх замаар цэвэрлэгээ, арчлалт хийх, нөхөн сэргээлт хийх асуудлыг шийдвэрлэх эсхүл тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд эдгээр шинэчлэлийг ойн тухай хуулийг шинэчлэлийг дагалдуулан оруулах нь зүйтэй.

Ойн тухай хууль болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хуулийн харилцан уялдаа

Ойн салбарын удирдлагыг босоо тогтолцоог сайжруулах нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчихгүй тухайд:

Ойн салбарын удирдлагад нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагад нөлөөлж байгаа талаар өмнөх хэсэгт дурдсан. Үүнийг Ойн тухай хуулиас гадна Монгол Улсын Үндсэн хуулиас эх авсан "Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн үзэл баримтлал, зорилго, зарчмаас харж болно.[73] Манай улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь төрийн буюу босоо удирдлага, нэгжийн буюу хэвтээ удирдлагыг тогтолцоог хослуулан хэрэгждэг.

---

[68] ТТ-9899 МОН: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр, Боть 2: Салбарын шинэчлэлийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр, 45 дахь тал.
[69] Мөн тэнд, 509 дэх тал.
[70] Мөн тэнд, 4 дэх тал.
[71] ТТ-9899 МОН: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр, Боть 2: Салбарын шинэчлэлийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр, 15 дахь тал.
[72] Мөн тэнд, 396 дахь тал.
[73] Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, 2020, https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106891904801

Энэ ч утгаараа нийт нутаг дэвсгэрийг тархсан ойн салбар нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хосолсон тогтолцооноос ангид хэрэгжих боломжгүй. Тодруулбал, Монгол Улсын Засаг захиргааны нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.6-д "*Тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчны тэнцвэрт байдалд тавих хяналтад иргэдийн оролцоог хангах ажил*"-ыг багийн чиг үүрэг байхаар хуульчилсан. Мөн тус хуулийн 27.5.10-т засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар байгаль орчныг хамгаалах, орчны бохирдол, нөхөн сэргээлт хийлгэх төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлэхээр хуульчилсан.[74] Эдгээр зохицуулалт нь ойн салбарын удирдлагыг тогтолцоог сайжруулахад саад учруулахгүй. Учир нь нэг талаас МУЗЗНДНТУтХ-ийн 23 дугаар зүйлийн 23.1.6-д заасан багийн чиг үүрэг нь ерөнхий шинжийг агуулсан бөгөөд ойн салбартай холбоотой асуудлыг тухайлан зохицуулаагүй байна.

Мөн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага байгаль орчныг хамгаалах, орчны бохирдол, нөхөн сэргээлт хийлгэх төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэж байгаа тохиолдолд МУЗЗНДНТУтХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасны дагуу хууль эсхүл нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авдаг бөгөөд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын хувьд байгаль орчныг хамгаалах, орчны бохирдол, нөхөн сэргээлт хийлгэх төрийн чиг үүргийг шилжүүлэн авсан нийтийн эрх зүй гэрээ хийгдээгүй байна.

Нөгөө талаас Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2-т *"Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно"* гэж хуульчилсан.[75] Үүнээс төрийн зохих дээд байгууллагын шийдвэр байгаа тохиолдолд нутгийн өөрөө удирдах байгууллага бие даан шийдвэрлэх эрхгүй болох нь харагдаж байна. Төрийн зохих дээд шатны байгууллага гэдэг засаг захиргааны хувьд нийт нутаг дэвсгэрийн хамарсан шийдвэрийг гаргадаг байгууллагын ойлгох бөгөөд агентлагийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Агентлаг нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн" гэж хуульчилсан.[76] Энэ ч утгаараа ойн асуудлыг улсын хэмжээнд хариуцах чиг үүрэгтэй төрийн захиргааны байгууллага болох Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Ойн газар" нь нийт улсын нутаг дэвсгэрийн ойн асуудлыг тухайлан шийдэж байна.

Түүнчлэн, төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д "орон нутгийн төсөвт хуваарилах орлогын нэр төрлийг энэ хуулиар, орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүргийг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулна гэж, мөн хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д "Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны захирагч Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйл, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8.2-т заасан төрийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэнэ" гэж, энэхүү чиг үүргийг холбогдох шатны төсвөөс санхүүжүүлэхээр мөн хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсэгт заасан.

---

[74] Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, 2020, https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106891904801

[75] Монгол Улсын Үндсэн хууль, 1992, https://legalinfo.mn/mn/detail?lawId=367

[76] Агентлагийн тухай хууль, 2004, https://legalinfo.mn/mn/detail/271

Энэхүү зохицуулалтын гол мөн чанар нь чиг үүргийг хэрэгжүүлэх эдийн засгийн баталгааг төр хангах, цаашлаад төрийн чиг үүргийг шилжүүлсэн тохиолдолд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг хамтад шийдвэрлэх эрх зүйн хэм хэмжээтэй холбоотой.[77]

Дээрхээс дүгнэвэл, нэг талаас МУЗЗНДНТУтХ-ийн 23 дугаар зүйлийн 23.1.6-д багийн чиг үүрэгт "*тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчны тэнцвэрт байдалд тавих хяналтад иргэдийн оролцоог хангах ажил*"-ыг ерөнхий байдлаар олгосон бөгөөд тус хуулиар олгосон аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны чиг үүрэгт ойн асуудлыг тухайлан хариуцуулаагүй байна. Нөгөө талаас тус хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.10-т Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар байгаль орчныг хамгаалах, орчны бохирдол, нөхөн сэргээлт хийлгэх төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлж болохоор хуульчилсан. Ийнхүү төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгэх явцад нийтийн эрх зүйн гэрээ байгуулахаар хуульчилсан бөгөөд практик төрийн чиг үүргийг шилжүүлсэн гэрээ хомс байна. Иймд ойн салбарын удирдлага нь МУЗЗНДНТУтХ-аас илүүтэй Ойн тухай хуулиар зохицуулагдаж байна.

Энэ ч утгаараа Ойн тухай хуулийн 17-19 дүгээр зүйлд тухайлан заасан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг дарга, Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх, Баг хорооны иргэдийн нийтийн хурал болон Засаг даргын бүрэн эрхийг өөрчлөх болон эдгээр бүрэн эрхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Ойн газар"-т шилжүүлэх асуудал МУЗЗНДНТУтХ-ийн 23 дугаар зүйлийн 23.1.6, 27 дугаар зүйлийн 27.5.10, 59 дүгээр зүйлийн 59.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэг, 61 дүгээр зүйлийн 61.1, 61.2 дахь хэсэгт заасан орон нутгийн чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх төсвийн санхүүжилттэй холбоотой заалттай уялдаж, нийцсэн байна.

Ойн тухай хууль болон Эрүүгийн хуулийн харилцан уялдаа

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль 2015 онд батлагдаж, 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх болсон билээ.

Тус хуулийн 24 дүгээр бүлэгт "Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг"-ийг тухайлан бүлэг болгон хуульчилсан бөгөөд тус бүлэгт ойтой холбоотой үйлдсэн дараах үйлдлийг гэмт хэрэгт тооцсон байна. Үүнд:

Хүснэгт 13. Эрүүгийн хуулийн зүйл, заалт

Зүйл, заалт	
Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйл. Хууль бусаар мод бэлтгэх	1.Зөвшөөрөлгүйгээр ойд мод бэлтгэсэн, гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг бэлтгэсэн, тээвэрлэсэн, худалдсан, худалдан авсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. 2.Энэ гэмт хэргийг: 2.1.байнга тогтвортой; 2.2.бүлэглэж; 2.3.улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ойд; 2.4.төрийн албан хаагч үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж

[77]МУЗЗНДНТУтХ-ийн 27 дугаар зүйлийн 27.2, 68 дугаар зүйлийн 68.2 дахь тал, https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106891904801

	хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
Эрүүгийн хуулийн 24.7 дугаар зүйл. Ой, хээрийн түймэр тавих	1.Гал, шатамхай зүйлтэй болгоомжгүй харьцсаны улмаас ой, хээрийн түймэр гарч хүний бие махбодод хүнд хохирол учирсан, хүний амь нас хохирсон; их хэмжээний хохирол учирсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Ой, хээрийн түймэр санаатай тавьсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн улмаас: 3.1.хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хүний амь нас хохирсон; 3.2.их хэмжээний хохирол учирсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдсөн өдрөөс буюу 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн хооронд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.6 дугаар зүйлд заасан "Хууль бусаар мод бэлтгэх" гэмт хэрэгт эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн шүүхийн шийдвэрийг судлан үзэхэд нийт 1,624 илэрц олдсон болно.

Харин Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн "Хууль бусаар мод бэлтгэх" гэмт хэргийн талаар судлан үзэхэд:

Хүснэгт 14. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн "Хууль бусаар мод бэлтгэх" гэмт хэрэг (2021-2024)

Он	2021	2022[78]	2023	2024[79]
Бүртгэгдсэн тоо	314	265	221	201

Дээрх тоон мэдээнээс үзвэл, хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг жил бүр тогтмол үйлдэгдэж байх бөгөөд энэ гэмт хэргийн хувьд Эрүүгийн хуульд заасан зарим төрлийн гэмт хэргээс ялгаатай нуугдмал гэмт хэрэгт хамаардаг. Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллагад бүртгэгдсэнээс гадна практикт энэ гэмт хэрэг нэлээдгүй үйлдэгддэг.

Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлд заасан "Хууль бусаар мод бэлтгэх" гэмт хэргийн зохицуулалт нь Ойн тухай хуулийн зохицуулалттай харилцан уялдаг.

Ойн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д "*Энэ хуулийн 32.2-т заасны дагуу аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон хэмжээнд багтаан ойн анги /байхгүй бол сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан/ иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагад* ***мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ олгоно****.*" гэж заасан бөгөөд энэхүү зохицуулалтаас үзвэл, мод бэлтгэх эрхийн гэрчилгээ, гарал үүслийн гэрчилгээг хамтад нь хамааруулан ойлгохоор байна.

Гэтэл Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.6 дугаар зүйлд *"Зөвшөөрөлгүйгээр ойд мод бэлтгэсэн, гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг бэлтгэсэн, тээвэрлэсэн, худалдсан, худалдан авсан бол..."* гэж заасан практикт тус зохицуулалтыг өөр өөрөөр тайлбарлан хэрэглэх, ойлгомжгүй байдлыг бий болгох, хууль хоорондын уялдаа холбоо хангагдаагүй гэх мэт асуудлууд үүсээд байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.6 дугаар зүйлд заасан "зөвшөөрөлгүйгээр" гэх гэмт хэргийн бүрэлдэхүүний обьектив талын шинж нь уг гэмт хэргийн диспозицийг бүхэлд нь хэрэглэхэд төвөгтэй болгосон хэмээн үзэж байна. Зүй нь бол "зөвшөөрөлгүйгээр" биш "эрхийн бичиггүйгээр" гэж томьёолбол уг гэмт хэргийг зүйлчлэхэд ямар нэгэн маргаан үүсэхгүй юм.

[78] https://police.gov.mn/resource/policenew/File/2023/01/11/i06fvqbdah377sml/2022.12%20sar%20medee%20-%20Gemt%20hereg.pdf
[79] https://strategy.police.gov.mn/resource/information/File/2025/01/06/6c3do9phniwnbgiv/%D0%A5%D1%8D%D1%80%D1%8D%D0%B3.pdf

Дээрх байдлаас үүдэн УДШ-ээс анх удаа 2019 оны 5 дугаар сарын 10-ны өдөр 206 дугаартай тогтоолоор *"Хууль ёсоор бэлтгэгдсэн модыг гэрчилгээгүй худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн тохиолдолд гэмт хэрэг болохыг тодорхойлох шаардлагатай"* гэсэн агуулга бүхий "obiter dicta" хийсэн байдаг.[80]

Энэ дагуу 2020 ны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 64 дүгээр тогтоолд "Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлд заасан хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн диспозицид заагдсан гарал үүслийн гэрчилгээгүйгээр, мод модон материалыг тээвэрлэсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцох эсэх асуудлыг шийдвэрлэхдээ тухайн мод, модон материал нь ойд зөвшөөрөлгүйгээр бэлтгэгдсэн эсэхийг зайлшгүй давхар шалгаж, зохих зөвшөөрлийн дагуу ойд бэлтгэгдсэн эсэхийг зайлшгүй давхар шалгаж, зохих зөвшөөрлийн дагуу ойд бэлтгэгдсэн эсхүл зохих зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар ойд мод бэлтгэсэн үйлдэлтэй шалтгаант холбоогүй болох нь тогтоогдвол тухайн мод, модон материал тээвэрлэсэн үйлдлийг гэмт хэргийн шинжгүй гэж үзнэ" гэсэн "казуаль тайлбар"-ыг хийжээ.[81]

Улмаар УДШ-ийн 64 дүгээр тогтоол гарсны дараа шүүхийн практикт тээвэрлэсэн модны гарал үүслийн гэрчилгээтэй байсан эсэхийг төдийлөн авч үзэхгүй, гагцхүү эрхийн бичигтэйгээр мод бэлтгэсэн эсэхэд төвлөрч нотлох баримтыг үнэлэн хэргийг шийдвэрлэх хандлага бүх шатны шүүхүүдэд түгээмэл ажиглагдах болсон.[82]

Түүнчлэн, Ойн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт "Дараах тохиолдолд хууль бусаар мод бэлтгэсэн гэж үзнэ:

35.4.1.гэрээ, зөвшөөрлийн баримт бичигт заасан тоо хэмжээ хэтрүүлсэн, төрөл, зориулалт, бэлтгэх арга, технологийг зөрчиж мод бэлтгэсэн;

35.4.2.зохих гэрээ, зөвшөөрөлгүйгээр мод бэлтгэсэн;

35.4.3.засварласан, хуурамч, хүчингүй гэрээ, эрхийн бичгээр ойгоос мод бэлтгэсэн гэж заасан бөгөөд энэхүү зохицуулалт нь Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлд заасан "Хууль бусаар мод бэлтгэх" гэмт хэргийн зохицуулалттай шууд байдлаар уялддаггүй.

Дээрхээс дүгнэвэл, Ойн тухай хуулийн нэр томьёотой уялдуулан Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлд заасан "Хууль бусаар мод бэлтгэх" гэмт хэргийн зохицуулалтыг өөрчлөн найруулах нь зүйтэй. Ингэснээр хууль хэрэглээний хувьд нэгдмэл байдал үүсэхийн зэрэгцээ хууль нэг мөр ойлгон хэрэглэх боломжийг бүрдүүлнэ.

Түүнчлэн, Ойн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-т "Улсын хил, аймаг, сум, нийслэл, дүүргийн нутаг дэвсгэр дамжсан орон нутгийн хүчээр унтраах боломжгүй ой, хээрийн түймэртэй тэмцэхэд шүүхээс **албадан хөдөлмөр хийлгэхээр** шийтгэгдсэн хүмүүсийг оролцуулах асуудлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цэргийн ангийн асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгч шийдвэрлэнэ" гэж заасан бөгөөд энэхүү зохицуулалтад тусгагдсан "албадан хөдөлмөр хийлгэхээр шийтгэгдсэн" гэснийг Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлийн 1.2-т "нийтэд тустай ажил хийлгэх ял" гэж, Зөрчлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 1.2-т "нийтэд тустай ажил хийлгэх" гэж тус тус заасантай уялдуулан өөрчлөх нь зүйтэй.

Учир нь албадан хөдөлмөр хийлгэх гэх ойлголт нь 2017 оноос шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр нийтэд тустай ажил хийлгэх болж өөрчлөгдсөн. Иймд хууль хоорондын уялдаа холбоог хангаж, хуулийн нэр томьёог нэг мөр болгох нь зүйтэй.

Ойн тухай хууль болон Зөрчлийн тухай хуулийн харилцан уялдаа

---

[80] Б.Батбаяр, Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн шүүхийн практик, хуульчлагдсан байдалд хийсэн дүн шинжилгээ, https://legaldata.mn/buteel/pdf?id=1347

[81] Б.Батбаяр, Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн шүүхийн практик, хуульчлагдсан байдалд хийсэн дүн шинжилгээ, https://legaldata.mn/buteel/pdf?id=1347

[82] Мөн тэнд.

Ойн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан. Харин Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлд “Ойн тухай хууль зөрчих” зөрчлийг хуульчилсан байна. Тус зүйлд:

1.Зөвшөөрөлгүйгээр ойн дагалт баялаг бэлтгэсэн бол зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Гэрээний дагуу эзэмшүүлсэн ойг:

2.1.түймэр;

2.2.хөнөөлт шавж;

2.3.өвчнөөс хамгаалах арга хэмжээ аваагүй бол учруулсан хохирол нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Зохих зөвшөөрөлтэйгөөр мод бэлтгэсэн талбайгаа цэвэрлээгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Мод бэлтгэх, эсхүл ойн дагалт нөөц ашиглахдаа технологийн горимыг зөрчсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5. Ойн сан бүхий газарт хориглосон үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлого, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6. Ойн дагалт нөөцийг менежментийн төлөвлөгөөнд туссан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан, бэлтгэсэн бол хэмжээнээс хэтрүүлэн бэлтгэсэн эд зүйлийг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7. Ойн сан бүхий газарт гал түймэртэй тэмцэх, түүнээс сэргийлэх талаар хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Түймрийн аюултай үед:

8.1.ой, хээрийн бүс нутагт өсвөр, залуу шилмүүст ой, шатсан ой, хуурай, унанги мод ихтэй ой, мод бэлтгэлийн хаягдал, үлдэгдлийг цэвэрлээгүй талбай, өвслөг ургамлын нөөц ихтэй газар, модны доор ил задгай гал түлсэн;

8.2.мод бэлтгэлийн талбайг цэвэрлэхдээ шатаах аргыг хэрэглэсэн;

8.3.шатах, тослох материал шингээсэн цаас, даавуу, хөвөн, бусад зүйлийг зориулалтын бус газар ил хаясан;

8.4.тээврийн хэрэгсэл, бусад техникийг шатахуунаар цэнэглэх үед тамхи татах, цонх, хаалгаар нь шатах, дэлбэрэх аюул бүхий хог хаягдал, үнс, шүдэнз хаях, оч баригчгүй тээврийн хэрэгсэл ашигласан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.Гэрээний дагуу ашиглалт явуулж байгаа газарт түймэр унтраах багаж, хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг тогтоосон норм, нормативын дагуу бүрдүүлээгүй, эсхүл түймэр гарсан үед тэдгээрийг ашиглахад бэлэн байлгаагүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10. Ойн тухай хуулиар тогтоосон шаардлагыг биелүүлээгүй бол учруулсан хохирол нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.Гэрээ байгуулахгүйгээр ойгоос мод бэлтгэсэн, эсхүл гэрээний нөхцөл, болзлыг зөрчин үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар бэлтгэсэн зүйл, олсон орлогыг хурааж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийн тухай хуульд заасан Ойн тухай хууль зөрчих зөрчил нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг агуулаагүй ч хууль зөрчсөн үйлдэл, мөн Ойн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан ойд хориглох үйл ажиллагаатай холбоотой зарим зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэж болохоор харагдаж байгаа ч практикт ОтХ-ийн 29 дүгээр зүйлд заасан зохицуулалтыг бүхэлд нь хамааруулж зөрчил үйлдсэнд тооцдоггүй байна.

Мөн Зөрчлийн тухай хууль болон Ойн тухай хуулийн нэр томьёог өөр хооронд уялдуулах шаардлагатай зүй ёсоор тавигддаг.

Дээрхээс нэгтгэн дүгнэвэл, Ойн тухай хуулийн зохицуулалт болон бусад хууль тогтоомжийг харилцан уялдаа бүхий зохицуулалтуудыг өөр хооронд нь уялдуулж, хуулийг нэг мөр нэгдмэл байдлаар хэрэглэх, хуулийн нэр томьёог жигдлэх, утга агуулгын хувьд ижил өөр өөр нэр томьёо хэрэглэсэн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай. Түүнчлэн, тус хууль болон бусад хуулиар зохицуулсан харилцаанд хамаарахгүй, зохицуулагдаагүй үлдсэн асуудлыг хуульчлан тогтоох нь зүйтэй.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

1.1. ДҮГНЭЛТ

Тус судалгааны хүрээнд Ойн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ыг дагуу гүйцэтгэлээ.

Судалгааны ажлын хүрээнд зорилгод хүрсэн түвшин, практик нийцэж байгаа байдал, бусад үр дагавар шалгуур үзүүлэлтийн хүрээнд нийт 13 шалгуур үзүүлэлт томьёолон тус хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж, дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1. Ойн тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан хуулийн зорилттой холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх:

Монгол Улсын Их Хурлаас батлагдсан урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газраас батлагдсан урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээнд *"Ойн тухай хуулийг ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагын тод тарьж ургуулах санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох, ногоон эдийн засгийг дэмжих, ойн нөөцийг зохистойгоор ашиглах, хамгаалах, зохицуулалтыг бий болгох"* хүрээнд ойн тухай хуулийг сайжруулахаар тусгажээ.

Ийнхүү төрийн бодлогын баримт бичгийн хүрээнд ойтой холбоотой асуудлыг чухалчилж авч үзсэн байх бөгөөд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Ойн тухай хуулийн тухайд тус хуулийн зорилт нь хэт ерөнхий бөгөөд Монгол Улсын Их Хурлаас батлагдсан урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газраас батлагдсан урт хугацааны хөгжлийн бодлогоор дэвшүүлсэн зорилго, зорилттой уялдаагүй байна. Мөн Ойн тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан зорилт хангагдаагүй байна.

2. Ойн тухай хуульд заасан хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх:

Ойн тухай хуульд 15 хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтыг хуульчилсан байна. Гэвч практикт дээрх 15 хэм хэмжээний актаас 7 журмыг баталж, 6 журмыг хүчингүй болгож, 2 журмыг батлаагүй байна. Дээрхээс дүгнэвэл, тус хуульд заасан хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт нь зорилгодоо хүрээгүй гэж үзэх болох юм. Нөгөөтээгүүр хэм хэмжээний актын хэрэгжилт нь хуулийн зорилгод сөргөөр нөлөөлсөн байна.

Учир нь хүчингүй болсон, батлагдаагүй 8 журмаар нарийвчлан зохицуулах ёстой байсан асуудлын хүрээнд эрх зүйн хийдэл буюу зохицуулагдаагүй харилцааг бий болгож байна. Нэгэнт хуульд тодорхой байдлаар тусгаагүй асуудлын хүрээнд журам батлахаар хуульд заасан учир тухайн асуудлыг зохицуулсан эрх зүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатай байдаг.

Нөгөөтээгүүр, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 7 журмын тухайд Ойн тухай хуулийн зохицуулалтыг нарийвчилсан тусгасан бөгөөд тус харилцааг хуулиар бус хэм хэмжээний актаар зохицуулж, энэ нь Ойн тухай хуулийг зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэж байна. Иймд Ойн тухай хуулийг засаж сайжруулах, боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байна.

3. Ойн тухай хууль дахь төрийн болон орон нутгийн байгууллагын бүрэн эрх, засаглалтай холбоотой зохицуулалт зорилгодоо нийцэж байгаа эсэх:

Ойн засаглалд аймаг, сумын ИТХ-ын оролцоо сөргөөр нөлөөлж байна. Учир нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны тогтоосон хязгаарын хүрээнд Аймгийн ИТХ-д сум бүрээр баталдаг. Аймгийн ИТХ-аас мод бэлтгэх хуваарийг баталсны дараагаар сумын ИТХ хуралдаж тухайн жилд ойгоос бэлтгэх хуваарийг дахин хэлэлцэн тогтоодог. Ийнхүү хэлэлцэн тогтоохдоо аймгаас тогтоосон хэмжээг үндэслэлгүй бууруулах, арчилгааны болон цэвэрлэгээний огтлолын хуваарийг 50 хувиар тогтоох, тодорхойгүй үндэслэлээр 2 компаниас зөвхөн нэг компанид олгож байна.

Мөн аймгаас батлагдсан дээд хязгаарыг хэрэглээ болон түлээн дээр үндэслэлгүйгээр бууруулан батлах, аймгийн төвийн сум руу нийлүүлэх хуваарийг огцом багасгаж байна. Энэ нь нэг талаар хуулиар олгогдсон бүрэн эрх боловч нөгөө талаас тухайн жил батлах хуваарийг эцсийн дүндээ сумын ИТХ тогтоох нөхцөлийг бүрдүүлж ойн засаглалд оролцож буй бусад байгууллагуудын оролцоог хязгаарлаж байна.

4. Ойн тухай хуульд заасан ойн мэдээллийн сантай холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх:

Байгаль орчны нэгдсэн мэдээллийн сан нь https://eic.mn/ бөгөөд тус цахим сангийн нэг хэсэг ойн мэдээллийн сан юм. Ойн мэдээллийн сан нь цахимаар хүн бүр тухайн сайтад хандан ойтой холбоотой бүх төрлийн мэдээллийг нэг дороос авах боломжтой байх ёстой боловч боловч сүүлийн жилийн мэдээллүүдийг шинэчлэн байршуулаагүй байна. Энэхүү мэдээллийн сангийн мэдээ, мэдээллийг тогтмол шинэчилж, статистик, тайлан, судалгааг тухай бүрд нь оруулахгүй байгаа нь цахим сангийн ач холбогдлыг алдагдуулж байна.

Иймд Ойн тухай хуульд заасан мэдээллийн сантай холбоотой зохицуулалтууд зорилгодоо бүрэн хүрч чадахгүй байна гэж үзсэн болно.

"Практикт нийцэж байгаа байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1. Ойн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан ойн нөхөрлөлийн үйл ажиллагаа, зохион байгуулалттай холбоотой зохицуулалт нь практикт нийцэж байгаа эсэх:

Ойн нөхөрлөл нь нутгийн иргэдийн сайн дурын, мэргэжлийн бус нэгдэл хэдий ч хуулиар мэргэжлийн байгууллагын шинжтэй үйл ажиллагаа (ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх) хүлээлгэсэн нь ойлгомжгүй давхардал үүсгэж байна.

Ойн нөхөрлөлийг хуулийн этгээдэд тооцдоггүй тул татвар төлөгчийн дугааргүй, санхүүгийн боломж хязгаарлагдмал, ашиг олж нөөц бүрдүүлэх эрхгүй, хамгааллын үүрэгтэй боловч бодит эрх мэдэл дутмаг байна. Түүнчлэн, судалгаанд хамрагдсан нөхөрлөлийн 86 хувь нь төлөвлөгөөтэй боловч тэдгээрийн олонх нь бусдын загварыг хуулбарласан, газар дээр нь судалгаа хийдэггүй, бодит үйл ажиллагаанд ашиглагдахгүй төлөвлөгөө байдаг. Үүний улмаас ойн нөхөрлөлийн ажил "цаасан дээр" үлдэх, бодит үр нөлөө үзүүлэхгүй байна.

Мөн хуулиар сумын ИТХ-д жил бүр тайлагнах зохицуулалттай боловч зөвхөн 45 хувь нь тогтмол тайлагнадаг, үлдсэн хэсэг нь тогтмол бус буюу огт тайлагнадаггүй бөгөөд үйл ажиллагааг үнэлэх, хариуцлага тооцох механизм хангалтгүй, санхүүгийн эх үүсвэргүйгээс ойн нөхөрлөлийн идэвх сулрах, тогтвортой ажиллах нөхцөл бүрдэхгүй байна.

Түүнчлэн, хуульд өөрийн хөрөнгөөр түймрээс урьдчилан сэргийлэхийг заасан нь сайн дурын иргэдийн хувьд хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, үүрэг хүлээлгэхээс гадна төрийн болон орон нутгийн

байгууллагуудын хариуцлага, дэмжлэг тодорхой бус байдаг гэх мэт олон асуудлууд практикт үүсээд байна.

2. Ойн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан ойн тооллого болон ойн зохион байгуулалттай холбоотой зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх:

Манай улсын хувьд үндэсний ойн тооллогыг 2014-2016 онд хийж байсан бөгөөд ойн зохион байгуулалтын ажлыг 2020 онд Увс, Өвөрхангай, Ховд аймгийн ойн санд хийж, улсын ойн сангийн төлөв байдлын мэдээллийг шинэчилсэн байна.[83] Түүнчлэн, 2021 онд Өмнөговь аймаг, 2022 онд Говь-Алтай аймаг, 2023 онд Хэнтий, Дархан-Уул, Сүхбаатар, Орхон аймагт ойн зохион байгуулалтын ажлыг тус тус хийсэн байна.

2024 оны байдлаар 21 аймаг, 238 сум, 1 хот 5 дүүргийн газар нутагт тархан ургаж байгаа ойн сангийн мэдээг нэгтгэн Улсын ойн мэдээг шинэчлэн боловсруулсан байна.

Ойн тооллого болон ойн зохион байгуулалтын ажлыг хуульд заасны дагуу гүйцэтгэж байгаа боловч тухайн салбарын хүний нөөц, ойн тооллого, ойн зохион байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай төсвийн асуудал зайлшгүй хөндөгддөг байна. Нөгөөтээгүүр, хуульд ойн тооллого, ойн зохион байгуулалтыг хамтад нь хуульчилсныг ойлгомжтой болгох үүднээс тухайн ойлголтуудыг өөр хоорондын ялгаатай байдлыг харгалзан тусад нь нэр томьёог тайлбарлан хуульчлах нь зүйтэй.

3. Ойн тухай хуулийн 40 дүгээр зүйл заасан ой ашигласны төлбөртэй холбоотой зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх:

Ойн тухай хуулийн 40 дүгээр зүйлд ойн ашигласны төлбөр, хураамжийг зохицуулсан бөгөөд ойн баялгийн нөөц ашигласны төлбөрт ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөр, ойн дагалт баялгийн нөөц ашигласны төлбөр хамаардаг. 2023 онд ойн нөөц ашигласны төлбөр 6,715,026,034 (Зургаан тэрбум долоон зуун арван таван сая хорин зуун мянга гучин дөрөв) төгрөг, 2024 онд ойн нөөц ашигласны төлбөр 8,252,270,131 (Найман тэрбум хоёр зуун тавин хоёр сая хорин зуун далан мянга нэг зуун гучин нэг) төгрөг болж, өмнөх оноос 1.5 тэрбум төгрөгөөр болж өссөн байна.

Гэвч Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд ой ашигласны төлбөрийн 85-аас доошгүй хувийг байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд дахин хөрөнгө оруулалт хийх ёстой гэж заасан боловч практикт тус зохицуулалт огт хэрэгждэггүй байна.

Мөн санхүүжилт, хөрөнгө оруулалттай холбоотой эрх зүйн зохицуулалт дутмаг, хэрэгжилт хангалтгүй байна.

4.* Ойн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хамгаалалтын бүсийн ойтой холбоотой зохицуулалт практикт *нийцэж байгаа эсэх:

Монгол Улсын хувьд ойг ашиглалтын болон хамгаалалтын бүс хэмээн ангилж ашиглалтын бүсийг ойн тухай хуулиар, хамгаалалтын бүсийг тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар буюу ялгаатай байдлаар зохицуулж байна. Өнөөдрийн байдлаар ойн сангийн 15,471.5 мян.га буюу 83.1% нь хамгаалалтын бүсийн, 3,136.5 мян.га буюу 16.9 хувь нь ашиглалтын бүсийн ойд хамаарч байна. Энэхүү тоо мэдээнээс манай улсад хамгаалалтын бүсийн ой давамгайлдаг болохыг харж болохоор байна. Гэвч хамгаалалтын бүсийг ойг хамгаалах, нөхөн сэргээх, цэвэрлэгээ хийх, цаашлаад хамгаалалтын бүсийн ойд нэгдсэн тоо бүртгэлийг гаргахад хүндрэл тулгарч байна.

***"Бусад үр дагавар" шалгуур үзүүлэлтийн хүрээнд*:**

[83] ҮСХ, Байгаль орчин-эдийн засгийн данс: Ойн нөөцийн данс-2023, (Уб, 2024), 5 дахь тал.

1. Ойн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан ойд хориглох үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтын хэрэгжилт, тулгамдаж буй асуудлын тухайд:

Ойн тухай хуулийн 29 дүгээр зүйлд "Ойд хориглох үйл ажиллагаа"-г хуульчилсан боловч тухайн зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хэн, хэрхэн, ямар хариуцлага хүлээлгэх талаар тодорхой тусгаагүй байна. Мөн тухайн зохицуулалтын хэрэгжилтэд хэн хяналт тавих, асуудал, зөрчлийг хэрхэн тогтоох, шийдвэрлэх талаар хуульчлаагүй нь тухайн зохицуулалтын хэрэгжилт хангагдахгүй байхад нөлөөлж байна.

Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлд заасан "Ойн тухай хууль зөрчих" зөрчлийн тухайд Ойн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан ойд хориглох үйл ажиллагаатай холбоотой зарим зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэж болохоор харагдаж байгаа ч практикт ОтХ-ийн 29 дүгээр зүйлд заасан зохицуулалтыг бүхэлд нь хамааруулж зөрчил үйлдсэнд тооцдоггүй байна.

Нөгөөтэзгүүр Ойн тухай 29 дүгээр зүйлийн 29.1-д заасан хориглосон зохицуулалтыг зөрчсөний улмаас хариуцлага хүлээлгэж байгаа бус Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан гэмт хэрэг, зөрчлийн шинжийг агуулсан үйлдэлд нь хариуцлага хүлээлгэж байна.

Иймд Ойн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасан ойд хориглох үйл ажиллагаатай холбоотой зохицуулалт нь практикт бүрэн хэрэгжихгүй байна. Энэ нь тухайн хориглосон зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага тодорхойгүй байгаатай холбоотой гэж үзэж болох юм.

2. Ойн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан ашиглалтын ойн асуудлын тухайд:

Монгол Улсын ойн сангийн талбай 18.6 сая га буюу нийт нутаг дэвсгэрийн 11.9 хувийг эзэлж, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ 7.96 хувьтай байгаа нь орны байгаль орчин, эдийн засгийн тогтвортой хөгжилд чухал нөөц болж байна. Ойн нөөцийн 79.2 хувийг шинэс дангаараа бүрдүүлж, Сэлэнгэ, Хөвсгөл аймагт зонхилон тархсан нь төвлөрсөн ашиглалт, орон нутгийн ялгаатай хөгжилд нөлөөлж байна. Гэсэн ч ойн нөөцийн ашиглалт харьцангуй бага, орон нутгийн ойрхог чанарын ялгаа, төвөөс алслагдсан бүсийн эдийн засгийн идэвх сул зэрэг асуудал тулгарсаар байна. Хууль эрх зүйн хувьд Ойн тухай хууль нь ойн ангилал, ашиглалтын чиглэлүүдийг ерөнхий түвшинд заасан боловч мод бэлтгэлийн төрөл, зөвшөөрөл, лиценз, хоёрдогч нөөц ашиглалт, аялал жуулчлал, орон нутгийн иргэдийн хэрэгцээг хангах асуудал зэрэгт нарийвчилсан зохицуулалт сул байна. Энэ нь хууль зөрчсөн нөхцөл үүсэх, тогтвортой ашиглалтад эрсдэл учруулах хүчин зүйл болж байна.

Манай улсын хувьд ойн салбарын бодлогын хэрэгжилт, хууль эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.

3. Ойн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтад заасан зам, дэд бүтэцтэй холбоотой зохицуулалтад тулгамдаж буй асуудлын тухайд:

Ойн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 болон 12.2 дахь хэсэгт ойн замын талаар тодорхой зохицуулалт оруулсан хэдий ч практикт хэрэгжилт хангалтгүй байна. Хуульд зөвхөн төсөвт тусгах, төрийн өмчит хуулийн этгээд байгуулах боломжийн талаар ерөнхий заалт орсон боловч нарийвчилсан журам, хэрэгжилтийн хяналтын механизм алга. Үүний улмаас сүүлийн 30 гаруй жилд нэг ч километр ойн зам шинээр баригдаагүй бөгөөд ойн замын сүлжээ бүрдээгүй хэвээр байна.

Ойн зам дэд бүтэц байхгүйгээс болж ойн нөөцийн 60 орчим хувь гүндээ үлдэж, ашиглагдахгүй байгаа бөгөөд ойн мэргэжлийн байгууллагууд замын хүндрэлээс шалтгаалан ойг зөвхөн зах хэсгээс бэлтгэж, чанарыг дорройтуулах хандлагатай байна. Нөгөө талаас, ойн түймэр болон хортонтой тэмцэх, аялал жуулчлал хөгжүүлэх боломж хязгаарлагдаж, ойн менежментийн үр ашиг багасаж байна.

Яамдын уялдаа холбоо сул, БОУАӨЯ, ХХААХҮЯ, Сангийн яам хоорондтөсвийн санал зөрчилдсөөр энэхүү чухал бодлого хэрэгждэггүй. Ойн мэргэжлийн байгууллагууд бэлтгэсэн модоо дунджаар 80 км зайд, бартаатай замаар тээвэрлэдэг нь эдийн засгийн үр ашиггүй байгааг харуулна. Энэ нь салбарт хөрөнгө оруулалт хийгээгүй, дэд бүтэц хөгжөөгүй байна.

Түүнчлэн, судалгааны хүрээнд хийсэн фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс үзвэл практикт ойн зам гэх ойлголт сул байгаа нь салбарын менежментийн чадамжийг бууруулж, ойг зөв ашиглах боломжийг хааж буйг илтгэж байна. Тиймээс ойн замын хөгжлийн төлөвлөгөө, ойн замын нягтрал, эдийн засаг-экологийн тооцоонд тулгуурласан бодлогын шинэчлэл яаралтай шаардлагатай байна.

4. Ойн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан ойн нөхөрлөлийн чиг үүрэг бусад байгууллагын чиг үүрэгтэй давхардаж буй эсэх:

Монгол Улсад ойн нөхөрлөл болон ойн мэргэжлийн байгууллагын чиг үүргийг хуульд ерөнхий байдлаар заасан нь бодит байдал дээр давхардал, хийдэл үүсгэж байна. Ойн нөхөрлөлүүд нь чадавх сул, санхүүжилт, техник хэрэгсэл дутмаг, гишүүдийн идэвх бууралттай тул үйл ажиллагаагаа бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа бол ойн мэргэжлийн байгууллагууд мөн адил төстэй үүргийг хэрэгжүүлж байгаа нь зохион байгуулалтын тодорхойгүй байдлыг бий болгож байна.

5. Ойн тухай хууль ба бусад хуулийн харилцан уялдааны талаар:

Ойн тухай хууль нь байгаль орчны салбарын хууль тогтоомж болон бусад хууль тогтоомжтой харилцан уялдаж байдаг. Энэ хүрээнд Ойн тухай хууль нь БОХтХ, ТХГНтХ, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуультай хэрхэн харилцан уялдаж байгааг судлан үзсэн болно.

Судалгааны үр дүнгээс үзвэл, Ойн тухай хууль болон дээрх хуулиудын хоорондын уялдаа холбоо хангалтгүй байна. Түүнчлэн, хуулийн нэр томьёог нэг мөр болгох, хууль хоорондын зөрүүтэй ойлголтыг жигдлэх, харилцан уялдааг сайжруулах зайлшгүй шаардлагатай болох нь харагдаж байна.

4.2. ЗӨВЛӨМЖ

Судалгааны дээрх дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг боловсруулж байна Үүнд:

"Зорилгод хүрсэн түвшин" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1. Ойн тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан хуулийн зорилттой холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх асуудлын тухайд:

Монгол Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газраас баталсан урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээнд уялдуулах замаар Ойн тухай хуулийг зорилго, зорилтыг "Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагын тод тарьж ургуулах санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох, ногоон эдийн засгийг дэмжих, ойн нөөцийг зохистойгоор ашиглах, хамгаалах, зохицуулалтыг бий болгох" гэсэн агуулгаар сайжруулах Ойн тухай хуулиар зохицуулагдах харилцааны хүрээг өргөжүүлэх.

2. Ойн тухай хуульд заасан хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх асуудлын хүрээнд:

Ойн тухай хуулийг шинэчлэхдээ хэм хэмжээний актыг онцгойлон судлах ингэхдээ ямар эрх зүйн харилцааг ойн тухай хуульд, ямар эрх зүйн харилцааг Ойн тухай хуульд нийцүүлэн журмаар зохицуулах вэ? гэдэгт анхаарах шаардлагатай. Тиймээс ОтХ-ийг боловсронгуй болгох, засаж сайжруулахдаа одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журмуудаас хуульд оруулах журмыг ялган зааглаж үзэх нь зүйтэй. Ингэхдээ:

- Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлэгт заасан хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, хориглосон болон ямар нэг байдлаар хөндсөн агуулга бүхий зохицуулалттай эсэх;
- Гагцхүү хуулиар буюу тусгайлан эрх олгож буй хуулийн агуулга, зорилго, хүрээнээс давсан зохицуулалттай эсэх;
- Тогтмол давтагдах процессын шинжтэй зохицуулалт агуулсан эсэх;
- Нэг удаа батлахад удаан хугацаанд тогтвортой мөрдөгддөг хэм хэмжээ агуулсан эсэх;
- Давхардал, хийдэл, зөрчлийг үүсгэсэн эсэх.

Дээрх шаардлагад үндэслэж Ойн тухай хууль болон тухайлсан хэм хэмжээний актаар зохицуулах харилцааг ялган зааглаж хуульд оруулах нь зүйтэй.

3. Ойн тухай хууль дахь төрийн болон орон нутгийн байгууллагын бүрэн эрх, засаглалтай холбоотой зохицуулалт зорилгодоо нийцэж байгаа эсэх асуудлын хүрээнд:

Ойн тухай хуулиар аймаг болон сумын ИТХ-ын эдлэх бүрэн эрхийг багасгах, модны хуваарийг гаргахдаа сумын ИТХ-ын дээд шатны хязгаарт батлуулан эцэслэн шийдвэрлэдэг байдалд хязгаар тогтоох буюу дээд шатнаас баталсан хуваарийг өөрчлөн батлах эрхийг хязгаарлах, эсхүл бусад судалгаанд дурдсаны дагуу тухайн жилийн бэлтгэх модны дээд хязгаарыг эцэслэн тогтоож буй сумын ИТХ-ын бүрэн эрхийг хүчингүй болгох зүйтэй.

4. Ойн тухай хуульд заасан ойн мэдээллийн сантай холбоотой зохицуулалт зорилгодоо хүрсэн эсэх:

Ойн тухай хуульд ойн тооллого, ойн зохион байгуулалтыг хамтад нь хуульчилсныг ойлгомжтой болгох үүднээс тухайн ойлголтуудыг өөр хоорондын ялгаатай байдлыг харгалзан тусад нь нэр томьёог тайлбарлан хуульчлах нь зүйтэй.

"Практикт нийцэж байгаа байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1. Ойн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан ойн нөхөрлөлийн үйл ажиллагаа, зохион байгуулалттай холбоотой зохицуулалт нь практикт нийцэж байгаа эсэх асуудлын хүрээнд:

- Ойн нөхөрлөлийг зөвхөн "Ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах" биш, харин сумын хэмжээнд батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцох чиг үүрэгтэй болгож тодорхой болгох;

- Ойн нөхөрлөлийн эрх зүйн статусыг тодорхой болгох: сайн дурын иргэдийн бүлэг хэлбэрээр үлдээх эсвэл хуулийн этгээд болгон өөрчлөх боломжийг судлах;

- Ойн нөхөрлөлийн дундын сан бүрдүүлэхэд татварын хөнгөлөлт, байгалийн нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, төсвийн дэмжлэг үзүүлэх;

- "Менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлд суурилсан урамшууллын систем" бий болгож, ой хамгаалах, нөхөн сэргээх ажилд бодит шагнал олгох;

- Тэрбум мод санаачилгатай уялдуулан мод үржүүлгийн газрыг үнэ төлбөргүй эсвэл татварын хөнгөлөлттэй олгох;

- Жил бүрийн тайлагналыг бүх нөхөрлөлөөс тогтмол авч, сумын ИТХ-оор хэлэлцэж үнэлдэг хяналтын тогтолцоог сайжруулах;

- Үйл ажиллагааны тайланг үнэлэх шалгуур үзүүлэлт боловсруулж, олон нийтэд ил тод мэдээлэх;

- Байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажлыг өргөжүүлэх, малын бэлчээрлэлтээс хамгаалах арга хэмжээг хатуу мөрдүүлэх;

- Ойн нөхөрлөлийг мод үржүүлгийн газар байгуулахад татварын болон газар эзэмших дэмжлэг үзүүлэх;

- Ойн нөхөн сэргээлтийн ажлыг төрийн болон олон улсын төсөл, хөтөлбөртэй уялдуулах;

- Ойн түймэртэй тэмцэхэд орон нутгийн төсвөөс тогтмол хөрөнгө батлах, нөхөрлөлийг тоног төхөөрөмж, гар багаж, сургалтаар хангах;

- Түймрийн эргүүл, хяналт хийхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, нөхөрлөлийг орон нутгийн гамшгийн бэлэн байдлын тогтолцоонд нэгтгэх;

- Сумын ИТХ, Засаг даргын төсөвт ойн нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардлыг тусгах;

- Ойн анги, сум орон нутгийн байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, чадавхжуулах сургалт, хяналт, зөвлөгөөг тогтмолжуулах.

2. Ойн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан ойн тооллого болон ойн зохион байгуулалттай холбоотой зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх асуудлын хүрээнд:

Ойн салбарын хүний нөөцийг нэмэгдүүлэх, ойн тооллого, ойн зохион байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай төсвийг шийдвэрлэх. Ойн тухай хуульд ойн тооллого, ойн зохион байгуулалтыг хамтад нь хуульчилсныг ойлгомжтой болгох үүднээс тухайн ойлголтуудыг өөр хоорондын ялгаатай байдлыг харгалзан тусад нь нэр томьёог тайлбарлан хуульчлах.

3. Ойн тухай хуулийн 40 дүгээр зүйл заасан ой ашигласны төлбөртэй холбоотой зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх асуудлын хүрээнд:

Байгалийн нөөц ашигласны төлбөрөөр ойн салбар ажиллаж буй орон нутгийн боловсон хүчнийг чадавхжуулах, байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг өгсөн нөхөрлөлийн гишүүдийг хуулийн хүрээнд урамшуулах, ойн нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг дэмжих зэргээр үр ашигтайгаар зарцуулах нь зүйтэй. Мөн санхүүжилт, хөрөнгө оруулалттай холбоотой эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, олон улсын жишигт нийцүүлэх нь зүйтэй.

4.* Ойн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хамгаалалтын бүсийн ойтой холбоотой зохицуулалт практикт *нийцэж байгаа эсэх асуудлын хүрээнд:

Монгол Улсын хувьд ойг ашиглалтын болон хамгаалалтын бүсийг тусдаа хуулиар бус нэгдсэн байдлаар зохицуулах нь зүйтэй. Ингэснээр хамгаалалтын болон ашиглалтын бүсийг ойг хамгаалах, нөхөн сэргээх, цэвэрлэгээ хийх, цаашлаад хамгаалалтын бүсийн ойд нэгдсэн тоо бүртгэлийг гаргах боломж бүрдэнэ.

"Бусад үр дагавар" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1. Ойн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан ойд хориглох үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтын хэрэгжилт, тулгамдаж буй асуудлын хүрээнд:

Ойн тухай хуульд заасан хориглосон үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг практикт хэрэгжих боломжийг бүрдүүлэхийн тулд хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох, мөн хатуу хориглосон хэм хэмжээг боломжит байдлаар өөрчлөн хуульчлах нь зүйтэй.

2. Ойн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан ашиглалтын ойн асуудлын хүрээнд:

Хууль эрх зүйн нарийвчилсан зохицуулалт бий болгох: Ойн ашиглалтыг төрөлжүүлэн ангилж, тус бүрд нарийвчилсан журам, нөхцөл, зөвшөөрөл, хяналтын тогтолцоог тогтоох нь чухал. Ингэснээр зөвшөөрөлгүй ашиглалт, хууль бус бэлтгэлийн эрсдэл буурна.

Зах зээл, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх: Концессын гэрээ, ОТМ-ийн зарчмаар томоохон аж ахуйн нэгжид тодорхой талбайг эзэмшүүлэхдээ ил тод, өрсөлдөөнтэйгөөр зохион байгуулж, хяналтын найдвартай тогтолцоо бий болгох хэрэгтэй.

3. Ойн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтад заасан зам, дэд бүтэцтэй холбоотой зохицуулалтад тулгамдаж буй асуудлын хүрээнд:

Монгол Улсад ойн замын хөгжил хангалтгүй байгаа нь ойг зөв ашиглах, хамгаалах, сэргээхэд саад болж байна. Иймд хамгийн түрүүнд ойн замын нөхцөл байдлыг нарийвчлан судалж, бодит төлөвлөлт хийх шаардлагатай. Санхүүжилтийг зөвхөн улсын төсөвт найдалгүй хувийн хэвшил, олон улсын хамтын ажиллагаанаас татах нь зүйтэй. Нэн түрүүнд эдийн засгийн өгөөж өндөртэй бүс нутагт ойн зам барьж, ойн замын сүлжээний өмнөх төлөвлөгөөг шинэчлэн хэрэгжүүлэх хэрэгтэй. Замын бүтээн байгуулалтыг агуулах, ачих буулгах цэг зэрэг дэд бүтцийн хамт цогцоор нь төлөвлөснөөр ойг зохистой ашиглах, хамгаалах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжтой.

4. Ойн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан ойн нөхөрлөлийн чиг үүрэг бусад байгууллагын чиг үүрэгтэй давхардаж буй эсэх асуудлын хүрээнд:

Цаашид хууль тогтоомжид ойн нөхөрлөл болон ойн мэргэжлийн байгууллагын чиг үүргийг тодорхой ялган зааж, давхардлыг арилгах шаардлагатай. Үүний зэрэгцээ ойн нөхөрлөлийн чадавхыг нэмэгдүүлэхийн тулд санхүүжилт, сургалт, тоног төхөөрөмжөөр хангах, орон нутгийн удирдлагын

оролцоог идэвхжүүлэх, зах зээлийн нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй. Энэ нь ойг тогтвортой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэх гол нөхцөл болно.

5. Ойн тухай хууль ба бусад хуулийн харилцан уялдааны талаарх асуудлын хүрээнд:

Ойн тухай хууль болон бусад хуулийн харилцан уялдааг хангах шаардлагатай. Үүний тулд холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах нь зүйтэй. Ийнхүү хуулийн харилцан уялдааг хангахдаа хууль нэр томьёо, хуулийн зохицуулалт, зохицуулагдаагүй харилцаа, өөр хоорондын холбоо хамаарлыг харгалзан үзэх нь чухал.

---oOo---

ТАВ. НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он;
2. Агентлагийн тухай хууль, 2004 он;
3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 2012 он;
4. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он;
5. Зөрчлийн тухай хууль, 2017 он;
6. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, 2020 он;
7. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, 1993 он;
8. Ойн тухай хууль, 2012 он;
9. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, 1995 он;
10. Хууль тогтоомжийн тухай хууль, 2015 он;
11. Эрүүгийн хууль, 2016 он;
12. Монгол Улсын Их Хурлын Тогтоол, Дугаар 52, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг батлах тухай, 2020 он;
13. Монгол Улсын Их Хурлын Тогтоол, Дугаар 488 “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг батлах тухай”, 2010 он;
14. Монгол Улсын Их Хурлын Тогтоол, Дугаар 21, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”, 2024 он;
15. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Дугаар 350, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, 2021 он;
16. Монгол Улсын Засгийн Газрын Тогтоол, Дугаар 59, Аргачлал батлах тухай
17. Монгол Улсын Их Хурлын Тогтоол, Дугаар 106, “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай”, 2021 он;
18. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Дугаар 58, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, 2021 он;
19. Монгол Улсын Засгийн Газрын Тогтоолын хавсралт, Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ;
20. Монгол Улсын Засгийн Газрын Тогтоол, Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл;
21. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын тушаал, Дугаар А/68, Захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох тухай”;

Ном, сурах бичиг, судалгаа

1. Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах төсөл”, Хууль тогтоомжийн тухай хууль, аргачлал, /Гарын авлага/, 2016 он;
2. Д.Баттулга, “Хэм хэмжээний актаар зохицуулах харилцааны хүрээ, хязгаар, болон хяналтын зарим асуудлыг боловсронгуй болгох нь”, 2016 он;
3. Азийн хөгжлийн банк, ТТ-9899, Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр, Боть 2:Салбарын шинэчлэлийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсгөлийн тайлан, 2023 он;
4. ТА-9899 МОН: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр (сум дундын) ойн ангийн үнэлгээ Тайлангийн төсөл, 2023 он;
5. ТТ-9899 МОН: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр тэрбум мод хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд ойн нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг бэхжүүлэх заавар, 2023 он;
6. ТА-9899: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр зах зээл ба өртгийн сүлжээний шинжилгээ, 2023 он;
7. ТА-9899 МОН: Ойн Салбарын Хөгжлийн Хөтөлбөр: 2-р боть: Салбарын шинэчлэлийн стратеги, Үйл ажиллагааны төлөвлөгөө Хавсралт А3: Ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх замын зураг, 2023 он;
8. ТА-9899 МОН: Ойн салбарын хөгжлийн хөтөлбөр /Ойн нөхөрлөлүүдэд хийсэн үнэлгээ/, 2023 он;

9. ҮСХ, Байгаль орчин-эдийн засгийн данс: Ойн нөөцийн данс-2023, 2024 он;
10. БОАЖЯ, Ойн судалгаа хөгжлийн төв, Монгол Улсын ойн сан /албан хэрэгцээнд/, 2020 он;
11. Б.Удвал, Хушны самрыг зүй зохистой түүж бэлтгэх, ашиглах гарын авлага, 2020 он;
12. Ч.Доржсүрэн, Ч.Дугаржав, Ц.Чулуунбаатар, Ойн нэр томьёоны товч тайлбар толь, 2017 он;
13. "Хуулиар нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоох эрхийг захиргааны байгууллагад шилжүүлэх заалтын хүрээ хязгаар, хууль, хэм хэмжээний актын харилцан хамаарлыг тодорхойлох онолын харьцуулсан судалгаа"

Бусад

1. Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 191 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн ахлагч, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаярын баталсан "Захиргааны хэм хэмжээний актыг цэгцлэн хуулийн төсөл боловсруулах ажлын удирдамж"
2. МХЕГ, Ойн тухай хуулийн зөрчил, анхаарах асуудал сэдэвт танилцуулга, 2022 он;
3. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Байгаль орчны төлөв байдлын тайлан (2019-2020 он), 2021 он;
4. Байгаль орчин, аялал жуулчлалын яам ойн судалгаа, хөгжлийн төв," Монгол Улсын ойн сан", 2019 он;

Гадаад хэл дээрх эх сурвалж

1. The forest code of the russian federation no. 200-fz of december 4, 2006, adopted by the state duma on november 8, 2006, endorsed by the federation council on november 24, 2006, https://www.wto.org/english/thewto_e/acc_e/rus_e/wtaccrus58_leg_255.pdf
2. The code of the republic of kazakhstan forest code of the republic of kazakhstan (as of july 8, 2003, no.477-ii), https://faolex.fao.org/docs/pdf/kaz41426e.pdf
3. Federal forest act of 2 may 1975 (federal law gazette i p. 1037), last amended by article 112 of the act of 10 august 2021 (federal law gazette i p. 3436), https://www.gesetze-im-internet.de/bwaldg/bjnr010370975.html

Цахим эх сурвалж

1. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сан, https://finance.eic.mn/implement?y=2024&a
2. ЕХ-ны 2030 оны Ойн Стратеги, https://environment.ec.europa.eu/strategy/forest-strategy_en
3. ЕХ-ны Байгаль орчны комисс, https://environment.ec.europa.eu/topics/forests_en
4. ЕХ-ны Ойн хяналтын хууль, https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/HTML/?uri=CELEX%3A52021DC0572
5. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолын хавсралт, Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч, https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141010887611&showType=1
6. Статистикийн мэдээллийн нэгдсэн - www.1212.mn
7. Батбаяр, Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн шүүхийн практик, хуульчлагдсан байдалд хийсэн дүн шинжилгээ, https://legaldata.mn/buteel/pdf?id=1347